

ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ

№03
2023 ОН

2023.12.21



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ЛӨГЧ
Ухнаагийн ХҮРЭДСҮХ:

2023 он бол "Хүнсний хувьсгал"-ыг
гардан гүйцэтгэж буй баялаг бүтээгч,
үндэсний үйлдвэрлэгчдийн

**ҮЙЛ АЖИЛЛАГАА ӨРГӨЖИН
ТЭЛСЭН, АМЖИЛТАД ХҮРСЭН
ЖИЛ БАЙЛАА**





4 БАЙНГЫН ХОРОО

- УИХ-ын 36-р тогтоол
- УИХ-ын тус хорооны 02-р тогтоол



ХУНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

99 АГА ХӨМӨӨ

35 ТӨР, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУД

Засгийн газрын
63-р тогтоол

ЕТГ ХУНСНИЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН АЛБА

1. Төр, захиргааны 35 байгууллагын үйлдвэр хэлбэрт хөнгөлөх
2. Тогтоолын зорилгунд хяналт тавих
3. Соён газаруулах

ХУНСНИЙ ХУВЬСГАЛ

Ажлын үр дүнд хэрэгжүүлэх / Хөнгөлөх бус хэрэгжүүлэх

СИСТЕМИЙН 10 БАНК

БАНК БАГА ХҮҮТЭЙ ИТ ХӨТӨЛӨӨТӨЙ ЗЭЭЛ

5% - зогсолтын хэрэгнэгийн
6% - өрчлөлт оруулалтын
ТАТААС 13%

Хунс, хөдөө аж ахуйн салбарын холбоосдын нэгдэл
"ХУНСНИЙ ХУВЬСГАЛ" ТББ

Хунс, хөдөө аж ахуйн салбарын
ЭРДЭМТДИЙН ЗӨВЛӨЛ

ОЛОН УЛСЫН
БАЙГУУЛЛАГУУД

ХУНСНИЙ ХУВЬСГАЛ ЦӨРӨӨНӨНТ

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН
БАЙГУУЛЛАГУУД

- Төсөл
- Өмчлөлт
- Соёл
- Санхүү
- Соёлчилал

Соён газаруулах
ДЭ-р тогтоолын 4 заалт





АГУУЛГА:



12

ТӨРИЙН ТЭРГҮҮН УЛС ТӨРИЙН
МАНЛАЙЛАЛ ҮЗҮҮЛЖ,
“ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ”-ЫГ
САНААЧЛАН ЭХЛҮҮЛСЭН

14

ТӨРИЙН ТЭРГҮҮНИЙ АЙЛЧЛАЛУУД
ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧДЭД ДЭЛХИЙН
ЗАХ ЗЭЭЛД ГАРАХ “ГҮҮР” БОЛОВ



40

“ХҮНСНИЙ ХАНГАМЖ,
АЮУЛГҮЙ БАЙДАЛ”
ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ
ЗОРИЛГЫГ БИЕЛҮҮЛЭХИЙН
ТУЛД ТӨРӨӨС ЯМАР АРГА
ХЭМЖЭЭ АВСАН БЭ?



30

ҮНДЭСНИЙ
ҮЙЛДВЭРЛЭГЧИД БА
ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ



54

ХҮНИЙ НАСАН ТУРШИЙН
ЗӨВ ХООЛЛОЛТ БАГА
НАСНААС ЭХТЭЙ



58

ШИНЭ ЗЕЛАНД
ЛУГАА ХӨГЖЬЕ



64

ДЭЛХИЙН ХЯМРАЛТ ЦАГ
ҮЕ БА ЭРСДЭЛИЙГ СӨРӨХ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
САНААЧИЛГА





2023.12.06. Ургацын баяр-2023
(Улаанбаатар хот)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Ухнаагийн ХҮРЭЛСҮХ:
**“2023 он бол “Хүнсний хувьсгал”-ыг гардан
гүйцэтгэж буй баялаг бүтээгч, үндэсний
үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаа өргөжин тэлсэн,
амжилтад хүрсэн жил байлаа**

Эрхэм хүндэт хүнс үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчид ээ,

Эрхэм хүндэт нөхөд өө,

Эх орноо эрүүл хүнсээр хангах, цаашлаад хүнс экспортлогч орон болох их үйл хэргийн төлөө оюун ухаан, мэдлэг чадвар, хөдөлмөр зүтгэлээ дайчлан ажиллаж буй эрхэм хүндэт Та бүхэндээ чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье.

Монгол төрийн бодлогын цөмд монгол хүн, монгол өрх байсаар ирсэн, цаашид ч байх учиртай.

Тиймээс Монгол Улсын Ерөнхийлөгч тогтвортой хөгжлийн зорилтыг ханган хэрэгжүүлэх хүрээнд “Эрүүл монгол хүн”, “Тэрбум мод”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал” гэсэн харилцан уялдаа, холбоотой үндэсний хөдөлгөөнүүдийг санаачлан улс орон даяар хэрэгжүүлж байна.

Хөрс, хүнс, хүн гурав хүйн холбоотой юм.

Хөрс эрүүл байвал хүнс эрүүл байна. Хүнс эрүүл байвал хүн эрүүл байна. Монгол хүн эрүүл байвал монгол үндэстэн хүчирхэг байна.

Монгол улсын үндэсний аюулгүй байдлын нэг суурь баталгаа бол хүн ардын хүнсний хангамж, аюулгүй байдал юм.

Тиймээс “ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ”-ын хүрээнд

ирэх таван жилд гол нэр төрлийн 19 хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, улмаар Монгол Улс бүс нутагтаа хүнс экспортлогч улс болох зорилт тавин ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн энэхүү санаачилгыг УИХ, Засгийн газар дэмжин, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоол гаргаж, Засгийн газар энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө хичээл зүтгэл гарган ажиллаж байна.

Уг тогтоолын хэрэгжилтийг ханган хэрэгжүүлэхэд



2022.10.17. “Цалуут Имлекс” ХХК (Налайх, 2022.10.17)

төр, захиргааны 35 байгууллага хамтран ажиллаж, хууль дүрэм, төсөв санхүү, хөнгөлөлттэй зээл, гааль татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөөс эхлүүлээд



2023.09.08. "Сэлэнгэ тариа" ХХК
(Сэлэнгэ аймаг Цагааннуур сум)

99 төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэн, идэвхтэй ажиллаж байгаад талархалтай байна.

Тухайлбал, тус хөдөлгөөний хүрээнд арилжааны 10 банкаар дамжуулан, 5-6 хувийн хүүтэй нийт 982 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг хүнс үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчдэд олгохоор шийдвэрлэж, өнөөдрийн байдлаар 1857 аж ахуйн нэгж болон иргэнд нийт 675 орчим тэрбум төгрөгийн зээл олгогджээ.

Мөн экспортын нөөц боломж өндөртэй хүнс, хөдөө аж ахуйн нийт 19 төрлийн үйлдвэрлэлд нэн шаардлагатай 428 төрлийн тоног төхөөрөмжид импортын гаалийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг үзүүлээд байна.

Үүний үр дүнд "Хүнсний хувьсгал"-ийг гардан гүйцэтгэж буй малчид, тариаланчид, ногоочид, баялаг бүтээгчид, үндэсний үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаа өргөжин тэлж, зохих амжилтад хүрч байна.

Мөн манай баялаг бүтээгчдийн маань нөр их хүч хөдөлмөр, хичээл зүтгэл, санал санаачилга амжилтын үндэс болж байгааг тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Тухайлбал, хүнсний салбарт он гарсаар олон улсын шаардлагад нийцсэн мал төхөөрөх 2, мах боловсруулах 2, бяслаг үйлдвэрлэх 7 буюу нийт 11 үйлдвэр шинээр ашиглалтад орсон байна.

Мөн 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр ил талбайн хүнсний ногоо 30 хувиар, хүлэмжийн ногоо 27 хувиар, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 12 хувиар, мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 6 орчим хувиар тус тус нэмэгдэх тайлан мэдээ гарч байна.

Ялангуяа жимс жимсгэнэ, хүнсний ногооны нэр төрөл нэмэгдэж, түүхэндээ хамгийн өндөр хэмжээний ургац хураан авч, хүнсний ногооны дотоодын хангамж энэ оны эцэс гэхэд 85 хувь хүртэл нэмэгдэхээр байна.

Түүнчлэн сонгино, саримс, лууван болон өндөгний дотоодын хангамж 2023 онд 3-12 хувиар өсөх тооцоо гарчээ.

Мөн 2023 оны эхний 11 сарын байдлаар махны экспорт эрс нэмэгдэж, 277 сая ам.долларын экспортын орлого оллоо.

Үүний зэрэгцээ манай улсын хүнсний



2023.10.01. "Газар Агро" ХХК
(Сэлэнгэ аймаг Зүүнбүрэн сум)

бүтээгдэхүүний импорт 12 хувиар буурсан үзүүлэлт гарлаа.

Өөрөөр хэлбэл 1 тэрбум гаруй ам.доллаар гадаадаас хүнсний бүтээгдэхүүн худалдаж авдаг байсан манай улс энэ жил 120 сая орчим ам.долларыг эх орондоо үлдээх боломжийг бүрдүүллээ.

Дээр дурдсан олон зэрэг, нааштай үзүүлэлтүүд нь манай төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны бодит үр дүн, баялаг бүтээгчдийн маань өрнүүн хөдөлмөр, их ажлын үр шим юм.

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дотоодын хангамж ийнхүү нэмэгдэж байгаа хэдий ч цаашид бид уур амьсгалын өөрчлөлт, хөрсний доройтол, урийн чанар, хүнсний үйлдвэрлэлийн түүхий эдийн чанар, стандарт зэрэг олон асуудлуудад онцгой анхаарч, ажиллах шаардлагатай байгааг тэмдэглэн хэлэхийг хүсэж байна.

Эрхэм хүндэт хүнс үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчид ээ,

"Хүнсний хувьсгал" хэрэгжиж эхэлснээс хойш Монгол Улсын Ерөнхийлөгч нийт 55 хүнс үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, баялаг бүтээгчдийн үйл ажиллагаатай биечлэн танилцаж, газар тариалангийн бүс нутгуудаар явж, мөн Хөдөө аж ахуйн их сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд болон лабораториудад ажиллалаа.

Энэ үеэр манай хүнс үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчид, эрдэмтэн судлаачдын зүгээс тавьсан санал хүсэлтийг багцлан үзвэл хүнс, хөдөө аж ахуйн бодлогыг шинжлэх ухаанчаар тодорхойлох, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж, тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн үйлчилгээг хүнд



2023.09.08.
(Сэлэнгэ аймаг Цагааннуур сум)

Манай улс 1 тэрбум гаруй ам.доллаар гадаадаас хүнсний бүтээгдэхүүн худалдаж авдаг байсан бол

2023 ОНД 120 САЯ ОРЧИМ АМ.ДОЛЛАРЫГ эх орондоо үлдээх боломжийг бүрдүүллээ.



2023.09.29. "Бялхам Ивээл" ХХК
(Сэлэнгэ аймаг Баянгол сум)



сурталгүй, хөнгөн шуурхай болгох, хүнсний худалдаа борлуулалтын оновчтой сүлжээ, тогтолцоог бий болгох, шинэ дэвшилтэт технологи

г нэвтрүүлэх, урт хугацааны хөнгөлөлттэй зээл, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэрэг олон тулгамдсан асуудлуудыг хөндөж байлаа.

Тиймээс УИХ, Засгийн газар, холбогдох байгууллагууд дээрх санал хүсэлтийг нарийвчлан судалж, зохих арга хэмжээг авч, шуурхай ажиллахын зэрэгцээ "Хүнсний хувьсгал"-ыг амжилттай хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшил дараах асуудлуудад анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

Эн тэргүүнд төсөв, хөрөнгийн нөөц боломжоо бүрэн дүүрэн зөв зарцуулах, зээл санхүүжилт, татвар, даатгал зэрэг эдийн засгийн хөшүүргүүдийг оновчтой, хүртээмжтэй ашиглах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжихэд онцгой анхаарах хэрэгтэй байна.

Мөн хөдөө аж ахуйн салбарын 90 орчим хувийг бүрдүүлдэг уламжлалт мал аж ахуйн салбараа улам боловсронгуй болгон, нүүдлийн болон эрчимжсэн мал аж ахуйг шинжлэх ухаанчаар хөгжүүлэх, малын

ашиг шимийг бүрэн гүйцэд ашиглах, улмаар малчдын орлого, амьжиргааг сайжруулах явдал нь "Хүнсний хувьсгал"-ын амин чухал зорилтын нэг билээ.

Энэ хүрээнд малчдын залгамж халааг бэлтгэх, малын эрүүл мэндийг хамгаалах, нэгдэж хоршиж ажиллах, малын үүлдэр угсааг сайжруулах, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээрийн менежментийг сайжруулах зэрэг олон асуудлуудад анхаарал хандуулж, тодорхой үр дүн гаргах хэрэгтэй байна.

Ялангуяа, ирэх 2024 онд малын вакцинжуулалт, био-бэлдмэлийн үйлдвэрлэлд онцгой анхаарч, Монгол Улс малын өвчингүй эрүүл бүс болох зорилтод бодит ахиц дэвшил гаргах шаардлагатай байна.

Тиймээс цаашид Табид цөлжилт, шороон шуурганы эрсдэлийг бууруулах, ногоон хөгжлийг дэмжих, хүнс, хөдөө аж ахуйн кластер, цогцолборуудыг байгуулах, түүхий эд бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын нэгдсэн тогтолцоо, тээвэр логистикийн оновчтой сүлжээг бий болгох, жижиг, дунд үйлдвэрүүдийг дэмжих, шинэ техник технологийг нэвтрүүлэх, боловсон хүчнийг бэлтгэх зэрэгт төр, хувийн хэвшлийн бодлого, үйл



2023.05.16. Малын удмын сангийн үндэсний төв (Дархан-Уул аймаг)



ажиллагааг нэгтгэн, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх шаардлагатай байна.

Энэ хүрээнд “Агро-Ойн аж ахуй”, суулгац үржүүлгийн төв, жимс, жимсгэнэ болон үрийн аж ахуйг хөгжүүлэх, олон тарималт сэлгээ болон ээлжлэн тариалалтын техник, технологийн шинэчлэлийг хийж, хөрсний доройтлыг бууруулахад онцгой анхаарах нь зүйтэй.

Түүнчлэн үйлдвэрлэж, импортолж, экспортолж, борлуулж байгаа бүх хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар стандартын асуудлыг шат шатандаа онцгой анхаарч, хүнсний аюулгүй байдлын хяналтыг чангатгах нь чухал байна.

Дээрх зорилтуудыг төр, хувийн хэвшлийн үр дүнтэй түншлэлээр хамтран хэрэгжүүлснээр ард иргэдээ гарал үүсэл нь тодорхой чанартай, найдвартай, дотоодын эрүүл хүнсээр хангахын зэрэгцээ ажлын байр нэмэгдэн, иргэдийн амьдралын чанар дээшилж, улмаар манай улс хүнс экспортлогч орон болох боломж бүрдэнэ.

Өрх бүлээрээ хүнс үйлдвэрлэгч, улс орноороо хүнс экспортлогч болох эрхэм зорилгод төр, засаг, түмэн олноороо нэгдэн нийлж, эх оронч сэтгэлээр хамтран зүтгэж, “Хүнсний хувьсгал”-ыг амжилттай хийцгээе!

Мөнх тэнгэрийн хүчин дор Монгол Улс мандан бадрах болтугай.



2023.09.29. Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын Ахмад тариаланч С.Батмөнхийн хамт



ХХААХҮ-ийн сайд
Х.БОЛОРЧУЛУУН:



**Олон улсад хүлээн
зөвшөөрөгдсөн
мах экспортлогч
улс болно**



2023.10.01. “Занаду Разорбак” ХХК
(Булган аймгийн Хутаг-Өндөр сум)

- “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн өрнөөд багагүй хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний бодит үр дүнгээс танилцуулах уу?

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийн хүрээнд гол нэрийн 19 хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах зорилт тавьсан.

Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор салбарт эргэлтийн болон хөрөнгө оруулалтын 5-6 хувийн хөнгөлөлттэй зээлийг арилжааны 10 банкаар дамжуулан үйлдвэрлэл эрхлэгчдэд олгоод байна.

Зээлд хамрагдсан үйлдвэрүүд хүчин чадлаа нэмэгдүүлж, бүтээгдэхүүний нэр төрлөө баяжуулах нь элбэг байна. Тухайлбал, Грийн групп хөнгөлөлттэй зээлд хамрагдан хүчин чадлаа 3 дахин нэмэгдүүлсэн төдийгүй хоногт 150 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал бүхий гоймонгийн шинэ үйлдвэр ашиглалтад оруулах гэж байгаа нь бодит үр дүн төдийгүй тус хөнгөлөлттэй зээл нь үндэсний

үйлдвэрлэгчдэд томоохон дэмжлэг болж байгааг харж болохоор байна.


2023 оныг “Газар тариалангийн сэргэлт”-ийн жил болгон зарласан. Газар тариалан ч жинхэнэ утгаараа сэргэж, арвин ургац хураалаа. Сүүлийн 10 жилд хураагаагүй өндөр ургац авлаа. Дотоодын улаан буудайн хэрэгцээгээ бүрэн хангасан бол хүнсний ногооны 85 хувийг хангаад байна. Хаврын тариалалтад зориулан 382 аж ахуйн нэгж, иргэнд нийтдээ 12.0 мянган тонн улаан буудайн үрийг 20-30 хувийн урьдчилгаа төлбөртэйгөөр олгож, тариалалтад дэмжлэг үзүүлж, үрийн шинэчлэл хийснээр нэгжээс авах ургацын хэмжээ нэмэгдсэн.

Мал, мах үйлдвэрлэгчдийн хувьд экспорт нэмэгдсэн сайн үзүүлэлттэй байгаа. Одоогоор махны экспорт 70 мянган тонн-д хүрсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4 дахин нэмэгдсэн. Махны экспортыг нэмэгдүүлэх нэг цонхны цахим системийг хэрэглээнд нэвтрүүлээ. Ингэснээр бичиг баримтын давхардал, үйлчилгээний хүнд суртал арилж, зөвхөн нэг цонхны системээр л гэхэд 11 мянган тонн мах экспортлох нөхцөлийг бүрдүүлээд байна. Мөн өнгөрсөн сараас бүх төрлийн махыг тоо хэмжээний

хязгаарлалтгүй экспортолж эхэлсэн төдийгүй 11 жилийн дараа агаарын тээврийн экспортыг дахин эхлүүлээ. Ойрхи Дорнодын улсууд руу үйлдвэрийн аргаар төхөөрсөн хонины гулууз махыг агаарын тээврээр нойтон буюу шинээр нь амжилттай хүргэсэн. Цаашид махны экспортыг байнга нэмэгдүүлэхийн сацуу Монгол малын махны үнэ цэнийг өсгөх “мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс” 5 аймагт байгуулахаар ажиллаж байна. Тухайн эрүүл бүсээр дамжуулан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн малын махыг экспортлох жишиг тогтооно.

- Стратегийн хүнс болсон махны экспорт 4 дахин нэмэгдсэн талаар та ярилаа. Тэгвэл хүн амын хүнсний гол хэрэглээ болсон сүүний үйлдвэрлэл ямар түвшинд байна вэ?

Засгийн газрын 2020 оны “Журам батлах тухай”



130 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг хэрэгжүүлснээр хуурай сүүний импортын хамаарал буурч, сэрүүний улирлын шингэн сүүний нийлүүлэлт нэмэгдээд байна. Сүүний урамшуулал өгч эхлээгүй өвлийн улиралд 6.8 сая литр түүхий сүү нийлүүлж байсан бол сүүний урамшуулал өгснөөр сүүлийн 3 жилийн дунджаар жилд 10.3 сая литр стандартын шаардлага хангасан түүхий сүүг үйлдвэрт нийлүүлж, түүхий сүүний нийлүүлэлт 51.5 хувиар нэмэгдсэн.

- Манай улс экспортлогч улс болохоор зорьж байгаа. Тэгвэл импортын хүнсний бүтээгдэхүүн дээр ямар бодлого баримтлах вэ?

Импортын хүнсний бүтээгдэхүүнийг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэгч цөөн байна. Импортыг орлох хүнсний бүтээгдэхүүн гэлтгүй импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг тогтвортой үйлдвэрлэл эрхлэх боломжоор ханган бодлогоор дэмжин, үндэсний үйлдвэрлэгч буюу баялаг бүтээгчдээ “төрийн хамгаалалт” -д авах шаардлагатай. Бид үндэсний үйлдвэрлэгчдээ хамгаалж, импортын бараа бүтээгдэхүүний гаалийн импортын татварыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ. Өөрсдийн үйлдвэрлэх боломжтой бүхнийг эх орондоо үйлдвэрлэж, дотоодын хэрэгцээгээ тодорхой түвшинд хангадаг байх нь чухал. Төр



2022.09.28. “Өгөөж Мандал Уул” ХХК (Сэлэнгэ аймгийн Хушаат сум)

бодлогоор баялаг бүтээгчдээ дэмжихийн сацуу иргэд эх оронч худалдан авалтаар мөн дэмжих нь зүйтэй.

- Та саяхан Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн хамт Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс (БНАЛАУ)-д Төрийн айлчлалд оролцсон. Хоёр улсын хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд ач холбогдолтой айлчлал болсон гэж харсан.

Тийм ээ. Айлчлалын хүрээнд Монгол Улсын гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэн нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлыг амжилттай зохион байгуулж, ахиц дэвшил гарсан айлчлал болж өндөрлөсөн. “Цагаан будааны худалдааны тогтвортой байдлын тухай” харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Ингэснээр Монгол Улс БНСВУ-аас жил бүр 30,000 тонн хүртэлх цагаан будааг тогтвортой худалдан авч, Монголын зах зээлд нийлүүлэх боломж бүрдэж байна. Мөн Монгол Улсаас Вьетнам Улсад экспортлох хонь, ямааны махны олон улсын мал эмнэлгийн гэрчилгээний загварын тухай баримт бичиг нь хоёр улсын хүнс, хөдөө аж ахуй, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд бодит хувь нэмэр оруулах юм.

- Хүнсний хангамжтай зэрэгцээд хүнсний аюулгүй байдал зайлшгүй анхаарах асуудал. Хүнсний аюулгүй байдлыг хангахад салбар яамнаас хэрхэн анхаарч байгаа вэ?

Хүн хямд, чанар муу хувцас, эд хэрэглэж болох ч чанар, стандарт хангаагүй хүнс хэрэглэж хэрхэвч болохгүй. Тиймээс хүнс, худалдааны салбарт төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг тогтмол хийж, зөрчлийг цаг тухайд нь барагдуулах чиглэл өгч ажиллаж байна. Мах бэлтгэлийн үйлдвэрүүд, мах худалдааны төвүүдэд энэ онд удаа дараагийн хяналт, шалгалтаар зөрчил илэрсэн мах бэлтгэлийн 7 үйлдвэрт хэрэг үүсгэн прокурорт шилжүүлсэн нь шийдэгдэж байна. Стандартын шаардлага хангаагүй, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх магадлалтай мах бэлтгэсэн аж ахуй нэгжийн 15,6 тонн махыг устгалын комиссоор дамжуулан устгуулаад байна.

Ярилцсан: Ч.Энхжаргал



Хүнс, хөдөө аж ахуйн салбарын

БАЯЛАГ БҮТЭЭГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨН

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Хүнс, хөдөө аж ахуйн салбарын баялаг бүтээгчдийн зөвлөгөөн” Төрийн ордонд 2023.03.03-ны өдөр зохион байгуулагдав.

Зөвлөгөөн нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх хүрээнд баялаг бүтээгчдийн санал бодлыг нь сонсон, цаашдын бодлого, шийдвэртээ нарийвчлан тусгах зорилготой юм. Мөн хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангахад төр, хувийн хэвшлийн оролцоо ямар байх талаар хэлэлцүүлэг өрнүүллээ.

ЗӨВЛӨГӨӨНӨӨР:

- “Хүнс, хөдөө аж ахуйн салбарын эрх зүйн шинэчлэлт, өөрчлөлт”,
- “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжүүлсэн ажил, цаашид авах арга хэмжээ”,
- “Хүнсний үйлдвэрлэл, мал аж ахуй, газар тариалангийн салбарын санхүүжилт”,
- “Үндэсний үйлдвэрлэл ба экспорт”,
- “Сүү, сүүн бүтээгдэхүүний хангамж, үйлдвэрлэл”,
- “Хүлэмжийн аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, шинэ ургацын ногоогоор тогтвортой хангах”,
- “Тахианы аж ахуйн үйлдвэрлэл ба хүн амын хүнсний хангамж дахь оролцоо” зэрэг сэдвээр илтгэл сонсов.

... Эзэн богд Чингис хаан нэгэнтээ “Чи бусдын хийсэн хоолыг идэж, бусдын хийсэн хувцсыг өмссөн тэр цаг дор бусдын боол болсон хэмээн бод” хэмээн айлдсан байдаг.



“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнтэй холбоотойгоор төр, засгийн зүгээс шаардлагатай бодлого, шийдвэрүүд гарч, “Хүнсний хувьсгал” бодит ажил хэрэг болон хэрэгжиж эхэлсэн. Гагцхүү “Хүнсний хувьсгал”-ыг бодитоор гардан хэрэгжүүлэгч хүнс үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчдийн оролцоо, манлайлал, хүчин чармайлт хамгийн чухал болохыг онцлож байв.

Мөн “Хүнсний хувьсгал”-ын хүрээнд төр, хувийн хэвшлийн зүгээс дараах асуудлуудад анхаарч, хамтран ажиллах шаардлагатай гэж үзлээ.

Үүнд:

■ Хөдөлгөөний хэрэгжилтийг улс орны хөгжлийн бодлого, түүн дотроо Бүсчилсэн хөгжлийн бодлоготой зөв уялдуулах, хүнс, хөдөө аж ахуйн кластеруудыг бодлогоор хөгжүүлэх, хүнсний үйлдвэрлэлийн цогцолборууд байгуулах, түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, тээвэр логистикийн оновчтой сүлжээг шинжлэх ухаанчаар төлөвлөн хэрэгжүүлэх,

■ Дотоодын хүнс, хөдөө аж ахуйн бараа, бүтээгдэхүүнийг дэмжих, хамгаалах эдийн засгийн зөв арга хэрэгслийг ашиглах, хүнс үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчдээ хамгаалах, хөгжүүлэх эрх зүйн орчныг сайжруулах,

■ Таван жилийн дотор малын өвчингүй эрүүл бүс болоход шаардлагатай вакцинжуулалт, био-бэлдмэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зэрэг суурь асуудлыг шийдвэрлэж, 2023 онд тодорхой бодит ахиц, дэвшил гаргах,

■ Хязгаарлагдмал төсөв, хөрөнгийн нөөц боломжоо бүрэн дүүрэн, үр дүнтэй ашиглаж, зээл, санхүүжилт, татвар, даатгал зэрэг эдийн засгийн оновчтой, хүртээмжтэй хөшүүрэг ашиглах, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааг дэмжих,

■ Төрийн худалдан авалтын бодлогыг эх оронч худалдан авалтад чиглүүлж, ард иргэд, аж ахуйн нэгжүүдэд үндэсний үйлдвэрлэлээ дэмжих хандлагыг төлөвшүүлэх,

■ Үндэсний хөдөлгөөний гүйцэтгэл, хүрэх үр дүнг жил бүрээр нарийвчлан төлөвлөж, бодит үр дүнг олон нийтэд хагас жил тутам тайлагнах нь зүйтэй юм.



2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр мөн “Эх оронч худалдан авалт-Үндэсний үйлдвэрлэл-2023” үзэсгэлэн МҮХАҮТ-д боллоо. Үзэсгэлэнд 100 орчим үндэсний үйлдвэрлэгч, 50 гаруй төрийн байгууллагын төлөөлөл оролцов.





2023.11.02.
(БНСВУ, Ханой хот)

Ерөнхийлөгчийн Тамгын газрын
дарга **Я.Содбаатар**:

“Төрийн тэргүүн улс төрийн манлайлал үзүүлж, “Хүнсний хувьсгал”-ыг санаачлан эхлүүлсэн

- Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг санаачлан эхлүүлэх болсон шалтгааныг уншигчид сонирхох байх?

Монгол Улсын Ерөнхийлөгч хүнсний хангамж, аюулгүй байдалд онцгой анхаарч, 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг хуралдуулж, зөвлөмж гарган, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд дэлгэрэнгүй мэдээлэл хийж, улс орон даяар “Хүнсний хувьсгал” эхлүүлсэн. Энэ нь гурван шалтгаантай. Эхнийх нь дэлхий нийтээрээ геополитикийн асуудал хурцадсан, дайн байлдаантай байгаа энэ цаг үед улс орон бүр хүнсний хангамжийн асуудалдаа анхаарч байна. Мөн олон улсын байгууллагууд энэ асуудлыг анхаарч, ард иргэдийнхээ хүнсний хангамжийг шийдвэрлэхгүй бол дэлхий нийтээрээ хүнсний хомсдолд орж болзошгүй гэж сануулга өгч байгаа. Хоёрдугаарт цар тахал, ковид-19 тархан улс орнууд хилээ хааж, олон сөрөг үр дагаваруудыг бий болгосон. Тиймээс бид дотоодын үйлдвэрлэлээр ард иргэдийнхээ хүнсний асуудлыг шийдэх зайлшгүй шаардлагатай гэдэг нь тод томруун харагдсан.

Хэзээ ч дахин хил хаагдаж магадгүй юм байна. Тэр үед монголчууд өөрсдөө тог цахилгаан, нефть, хүнсээ хангадаг байж эрсдэлийг даван туулна гэж үзсэн. Гуравдугаарт бид өвөг дээдсээс уламжилж ирсэн өргөн уудам газар нутаг, байгаль дэлхийгээ хайрлаж, энэ хөрс шороогоо ашиглаж зөвхөн уул уурхайдаа найддаг биш ургуулж, үржүүлдэг байх ёстой гэж Монгол Улсын Ерөнхийлөгч үздэг. Энэ утгаараа газар нутаг, мал аж ахуйгаа ашиглан хөдөө аж ахуйн салбараа хөгжүүлж, бүс нутагтаа хүнс экспортлогч улс болох боломжтой. Өөрөөр хэлбэл Ерөнхийлөгчийн хэлдэгчлэн монголчууд усан далайд гарцгүй ч хүн далайд гарцтай ард түмэн. Эдгээр гурван шалтгаанаар эх орондоо “Хүнсний хувьсгал” хийх болсон.

- 2023 оны эхэн үед төрөөс гарах ёстой бүх бодлого шийдвэр гарсан гэдгийг онцолж байсан. Эдгээр бодлого шийдвэрүүд бодит хөрсөн дээрээ бууж чадсан уу?

Анх “Хүнсний хувьсгал” гэж нэрлэн, УИХ-ын 36-р тогтоолын төслийг батлуулан, тогтоолын төслийн хүрээнд нарийвчилсан төлөвлөгөөнүүд гарган, бүх шатанд төр хувийн хэвшлийн түншлэлийг ханган,



2023.09.09. Хүнс хөдөө аж ахуйн Гавьяат ажилтан Ц.Рэнчинсэнгээгийн хамт (Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум)

үндэсний үйлдвэрлэгчид ч идэвх санаачлагатай, сэтгэл зүрхээ зориулж ажиллаж энэхүү ажил эхэлсэн. Нөгөө талдаа “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх бүх ажлууд эзэн биетэй байсан. Хэн, ямар ажил хийж, ямар үр дүн гаргах ёстой гэдэг нь тодорхой байсан. Тал талдаа хичээл зүтгэл гаргасан тул 2023 онд томоохон үр дүнгүүд гарч эхэлсэн гэж бодож байна. Бид нийт хүнсний ногооныхоо 85 хувийг дотоодоосоо хангаж чадлаа. “Хүнсний хувьсгал”-ын хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэгчдэд бага хүүтэй, урт хугацаатай зээл олгосон, хүнсний ногооны тариаланчдын газар, хүлэмж гэх мэт хөрөнгийг зээлийн барьцаанд авдаг болсон, хямдралтай, эргэн төлөх нөхцөлөөр үр олгож эхэлсэн, мөн хүнсний ногоочдын хоршоолол бий болоход дэмжлэг үзүүлсэн гэх мэт зөвхөн хүнсний ногоочдод чиглэсэн шат дараалсан арга хэмжээ авсны үр дүнд сүүлийн жилүүдэд байгаагүй их хэмжээний ургацыг хурааж авч байна. Яг энэ жишигээр мах, давс, өндөг гэх мэт 19 нэр төрлийн хүнс тус бүрт чиглэсэн ажлуудыг хийж, өмнөх үеийн байсан түвшингээсээ бүгд өссөн байна.

Энэ бол тайвшрах зүйл биш. Ирэх 3-4 жилд үргэлжлүүлэн ажил хэрэг болгосноор дотоодын хэрэгцээгээ хангах боломж бүрдэнэ. Ерөнхийлөгч ч мөн гадны улс орнуудад айлчлах үедээ хүнс, хөдөө аж ахуйн салбарт чиглэсэн асуудлыг дурдаж, хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрүүдийг хийж, экспортлогч улс болох боломжийг эрэлхийлж байна. Айлчлалын бүрэлдэхүүнд бизнес баг дагалдаж явдаг бөгөөд тухайн улсын үйлдвэр, аж ахуйн нэгжүүдтэй танилцаж, хамтын ажиллагааны гэрээ байгуулах гэх мэт ажлууд зохион байгуулагддаг. Энэ бүх ажлын үр дүн гарч байгаа нь 5 жилийн хугацаанд зорьсон зорилтоо биелүүлж чадна гэсэн итгэл өгч байгаа.

- “Хүнсний хувьсгал”-ыг хэрэгжүүлэхэд ЕТГ гол уялдаа холбоог нь хангаж ажиллаж байх шиг байна?

Монгол Улсын Ерөнхийлөгч улс төрийн манлайлал үзүүлж ажиллаж байна гэж ойлгож болно. Монгол Улсын аюулгүй байдал, амжиргаа, эрүүл мэнд, хөгжил дэвшилтэй холбоотой гол асуудал бол хүнсний хангамж, аюулгүй байдал юм. Тийм учраас төрийн тэргүүн энэ томоохон асуудлыг дэвшүүлж, нийгмийн анхаарлын төвд тавьж, олон улсын тавцанд ярьж, улс төрлийн манлайлал үзүүлж байна. Харин УИХ, ЗГ, орон нутгийн байгууллагууд гардан хэрэгжүүлэх учиртай. ЕТГ-ын зүгээс төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангаж, 6 сар

тутамд хийж хэрэгжүүлж буй ажлынх нь талаар мэдээлэл авч, санал солилцох уулзалтуудыг хийж байна.

- 2023 онд хүнс, хөдөө аж ахуйн салбарт түүхэнд бичигдэхүйц хэмжээнд дэмжлэг үзүүлсэн. Энэ дэмжлэг ирэх онд үргэлжлэх болов уу?

Бид хэдий үр дүнтэй ажиллаж чадсан ч гэсэн хүссэн үр дүндээ хүрээгүй байна. Тиймээс төрөөс хэрэгжүүлж буй ажил үргэлжилж, дэмжлэг үзүүлсээр байх болно. 2024 оны улсын төсөв батлах үед энэ онтой адилхан улаан будааны татаас, сүүний урамшуулал, хүнсний ногоочдын урамшуулал гээд бүх дэмжлэг үргэлжлэх болсон.

- Бага хүүтэй, урт хугацаатай зээлийг ч мөн дахин олгоно гэсэн үг үү?

Тийм. “Хүнсний хувьсгал”-ыг хэрэгжүүлэхэд УИХ өмнөх жилийнхээс дутахааргүй мөнгө төсөвлөсөн. Мөн олон улсын байгууллага, хандивлагч орнууд, бусад улс орнуудын хамтын ажиллагааны хүрээнд олон шинэ төсөл, зээл тусламж авахаар ярьж байгаа. Тиймээс ирэх онд илүү их үр дүн гарна гэсэн хүлээлттэй байна.

- Иргэд “Хүнсний хувьсгал”-ыг хэрхэн дэмжих вэ?

Мэдээж иргэн бүр дэмжиж, бодит үр дүн гарч байж энэ асуудлыг хөдөлгөөн болгон хэрэгжүүлсэн хэрэг гарна. Иргэд эх оронч худалдан авалт хийж, дотоодын үйлдвэрлэлээ дэмжих нь чухал байна. Тиймээс Монгол улсын иргэн бүр эх оронч худалдан авалт хийж, “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг хамтарч хэрэгжүүлээсэй гэж уриалж байна.

Ярилцсан: Б.Урантуяа



2023.01.27. УИХ-ын 36-р тогтоолыг хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудын зөвлөлдөх уулзалт I



2023.06.27. УИХ-ын 36-р тогтоолыг хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудын зөвлөлдөх уулзалт II



ТӨРИЙН ТЭРГҮҮНИЙ АЙЛЧЛАЛУУД ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧДЭД ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРАХ “ГҮҮР” БОЛОВ

XXI зуунд дэлхий энхтайван, эв нэгдэл рүү тэмүүлэхээс гадна шинжлэх ухаан, технологийн ололтуудаа зөв зүйлд ашиглахыг зорьж байна. Энэ цаг үед улс орон хөгжин цэцэглэх, амар тайван амьдрах нь гадаад харилцааны уур амьсгал, баримталж буй бодлоготой нягт холбоотой.

Дэлхий дахин энх тайванд тэмүүлсэн ч улс хоорондын зөрчил, хүн төрөлхтөнд тулгамдаж буй асуудлууд гарсаар байна.

Нөхрийн хэрэг бүтвэл, өөрийн хэрэг бүтнэ гэдэг шиг монголчууд дэлхий дахинд, хүн төрөлхтөнд тулгамдаж буй асуудлуудыг шийдэхэд хувь нэмэр оруулж, гадаад харилцаагаа өргөтгөн хөгжүүлэх цаг ирсэн.

Энэ хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх гадаад харилцаа, хамтын ажиллагааг эерэгжүүлэх олон алхам хийж буй юм. Тэрээр Монгол Улсын төрийн тэргүүнээр сонгогдоод хоёр жил өнгөрч байгаа бөгөөд энэ хугацаанд олон улсын хурал уулзалтад идэвхтэй

оролцон, дэлхийн хөгжлийн дүр зургийг тодорхойлогч улс орнуудтай төрийн түүхэн айлчлалуудыг хийж Монгол гэдэг улс энэ дэлхийд оршин тогтнож, хүн төрөлхтний төлөөх үйлсэд манлайлж буйг сануулсаар байна.

Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хугацаанд одоогийн эрчээрээ ажиллавал Монгол Улсын гадаад харилцаанд томоохон сэргэлт бий болох нь тодорхой гэдгийг салбарын мэргэжилтнүүд онцолж байв.

Мөн энэ удаагийн айлчлалууд харилцан ашигтай нөхцөлийг санал болгосон, хамтран ажиллах томоохон гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурж, хамтын ажиллагааг эхлүүлсэн, дотоодын үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчдийнхээ хүрээг тэлсэн, эдийн засаг, улс төр болон олон улсын тавцан дахь Монгол Улсын

нэр төрийг өргөсөн айлчлалууд болов.

**Асар их үнэ цэнээр
бидэнд үлдсэн
эх орон гэх үнэт
зүйлээ өнгөлж,
тордож, дэлхий
дахинд эерэг
дүртэй дараагийн
үедээ үлдээх нь
монгол хүн бүрийн
үүрэг.**



2023.04.24

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, гэргий Л.Болорцэцэг нарын урилгаар Бүгд Найрамдах Польш Улсын Ерөнхийлөгч Анджей Дуда гэргий Агата Корнхаузер-Дудагийн хамт төрийн айлчлал хийв.



2023.05.21

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн урилгаар Бүгд Найрамдах Франц Улсын Ерөнхийлөгч Эммануэл Макрон Монгол Улсад төрийн айлчлал хийв.



2023.07.04

Бүгд Найрамдах Энэтхэг Улс цахим хэлбэрээр зохион байгуулсан Шанхайн хамтын ажиллагааны байгууллага /ШХАБ/-ын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд хэлсэн үгэндээ “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний талаар тэмдэглэж, хамтран ажиллахад бэлэн байгааг дурдав.

2023.07.09

Бүгд Найрамдах Киргиз Улсын Ерөнхийлөгч С.Н.Жапаров Монгол Улсад хүрэлцэн ирэв.



2023.09.15

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Бүгд Найрамдах Куба Улсын Ерөнхийлөгч Мигель Марио Диаз-Канел Бермудезтай уулзлаа.



2023.07.24

Итали Улсын нийслэл Ром хотноо НҮБ-ын Дэлхийн хүнсний аюулгүй байдлын талаарх дээд хэмжээний уулзалтад оролцов.



2023.09.01

Гэгээн Ширээт Улсын төрийн тэргүүн Пап Францис Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн урилгаар айлчлал хийв. Түүхэнд тодоор тэмдэглэгдэн үлдэх энэ айлчлал хоёр улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, Монгол Улсын гуравдагч хөршийн болон энх тайванч гадаад бодлого, үйл ажиллагааг бататгах ач холбогдолтой.



2023.09.21

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганы Ерөнхий санал шүүмжлэлд үг хэлэв.



2023.10.18

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх “Бүс ба Зам” олон улсын хамтын ажиллагааны дээд түвшний гурав дахь удаагийн чуулга уулзалтад оролцов.



2023.12.02

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх “Далайд гарцгүй хөгжиж буй орнууд дахь уур амьсгалын өөрчлөлтийн өвөрмөц сорилт, бэрхшээлийг түншлэлийн замаар шийдвэрлэх нь” сэдэвт өндөр түвшний хуралдаанд оролцож үг хэллээ.



2023.12.02

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дэлхийн удирдагчдын дээд түвшний уулзалтад оролцов.

2023.10.19-20

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх БНХАУ-ын Нинся хотон үндэстний Өөртөө засах оронд зочиллоо.

FRANCE



1252 онд Людовик IX хааны зарлигаар Францын Эзэн хааны элчин төлөөлөгчөөр Виллиам Дэ Рубрук Их Монгол улсын нийслэл Хархорумд анх ирсэн нь манай хоёр улсын түүхэн хэлхээний эхлэл байв. Энэ үеэс хойш 771 жилийн дараа хоёр улс хамтын ажиллагааны шинэ хуудсыг нээлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Бүгд Найрамдах Франц Улсын Ерөнхийлөгч Эммануэл Макроны урилгаар 2023 оны 10 дугаар сарын 10-14-ний өдрүүдэд Франц Улсад төрийн айлчлал хийв.

Хоёр улсын Ерөнхийлөгчид анх удаа харилцан төрийн айлчлал хийсэн нь түүхэн үйл явдал боллоо.

Айлчлалын үеэр БНФУ-ын Ерөнхийлөгч Эммануэл Макрон:

- “Хөгжлийн түлхүүр болсон хүүхэд багачуудын хооллолт, хүнсний асуудлаар дэлхийн хүнсний хөтөлбөртэй хамтран ирэх долоо хоногт Парисын сургуулийн сурагчдын хооллолтын талаарх сэдэвт хурал зохион байгуулах гэж байгаа бөгөөд танай улсын энэ салбарыг дэмжиж буйгаа илэрхийлье” хэмээсэн.





2023.10.12.
(БНФУ, Парис хот
Элизейн ордон)



Энэ хүрээнд НҮБ-ын Дэлхийн хүнсний хөтөлбөрийн санаачилгаар Франц, Финланд тэргүүтэй гишүүн орнуудын “Сургуулийн хоолны эвсэл”-д Монгол улс нэгдэн гишүүнээр элсэж, Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Үдийн цай хөтөлбөрийг боловсронгуй болгох, бусад улс орнуудын Засгийн газар болон судалгаа шинжилгээний хүрээлэн, иргэний нийгэм, ТББ-тай хамтран хүнсний системийг боловсронгуй болгоход хамтран ажиллаж эхэллээ.



2023.05.21. (Монгол Улс,
Улаанбаатар хот)



2023.10.12. Монгол Улсын Соёлын
элч-Морин хуурын чуулга
Версалийн ордны Хааны дуурийн
театр (БНФУ, Парис хот)

Энэхүү төрийн айлчлалын хүрээнд хоёр улсын хамтын ажиллагааны баримт бичигт гарын үсэг зурав. Үүнд:



Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төслийн санхүүжилт олгох тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээр



Монгол Улсын Засгийн газар болон “Орано майнинг” компанийн хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл боловсруулах ажлын хэсгийн хэлэлцээний протокол

Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төслийн санхүүжилт олгох тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээр



Бүгд Найрамдах Франц Улсын Геологи уул уурхайн судалгааны товчоо, Францын геофизикийн ерөнхий компани болон Монголын үндэсний геологийн алба хоорондын эрмэлзлийн захидал

Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон БНФУ-ын “Thales Alenia Space” компанийн хоорондын Харилцан ойлголцлын тухай санамж бичиг



Геологийн шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны тухай чиглэлээр хамтран ажиллах тухай Францын Геологи, уул уурхайн судалгааны товчоо болон Монголын Үндэсний геологийн алба хоорондын Харилцан ойлголцлын санамж бичиг

БИЗНЕС ФОРУМ:

Айлчлалын бүрэлдэхүүнд хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, инженер технологи, уул уурхай гэх мэт салбарын 70 орчим байгууллагын 100



гаруй бизнес эрхлэгчид багтсан бөгөөд энэ удаагийн айлчлалаас эхлэн бизнес форум болон бизнес тур арга хэмжээг хослуулан



зохион байгуулдаг шинэ жишиг тогтлоо. “Франц-Монгол бизнес форум”-д Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх биечлэн оролцож, нээлтийн үг хэллээ. Энэхүү форумд

хоёр улсын 200 гаруй бизнес эрхлэгчид оролцон, зарим аж ахуйн нэгжүүдийн хооронд хамтын ажиллагааны баримт бичигт гарын үсэг зурж, хоёр талын бизнесийн төлөөлөгчид худалдаа, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны талаар чөлөөт уулзалт хийв.

Францын нийт 66 компани манай улсад бүртгэлтэй байгаа бөгөөд тэдний хөрөнгө оруулалтын 80 орчим хувь нь уул уурхайн салбарт хөрөнгө оруулсан байна. Хоёр орны эдийн засгийн харилцан ашигтай, хамтын ажиллагааг солонгоруулан хөгжүүлэхэд тус бизнес форум чухал нөлөө үзүүлсэн юм.



2023.10.11. (БНФУ, Парис хот Нийтийн аж ахуйн үндэсний холбооны байр)

БИЗНЕС АЯЛЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС :

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын 30 гаруй бизнес эрхлэгчид шөнийн 03:00 цагт босон Франц улсын төдийгүй дэлхийд хамгийн томд тооцогдох “Ранжис” хүнсний зах, Кластер мөөгний үйлдвэр, Сургалт, ферм хосолсон практик төвүүдтэй танилцан, мэдлэг туршлагаас нь судалж, нэг өдрийг оюуны олз дүүрэн өнгөрүүлэв.

Монголын хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэгчид дэлхийн хамгийн том хүнсний захтай танилцлаа.

Парис хотын гол зах зээл нь Ранжис олон улсын захад эргэлддэг бөгөөд ихэвчлэн хүнс, хүнсний ногоо болон цэцэрлэгжүүлэлттэй холбоотой бүх төрлийн бүтээгдэхүүн худалдаалдаг.



2023.10.13. Meat Department of Rungis International Market (БНФУ, Ранжис хот)

Х-XX зууны дунд үе хүртэл Парисын төв зах нь хотын төвд, Лес Халлес хэмээх 10 га талбайд байрладаг байв. Энэ нь бизнесийн бүх эрэлт хэрэгцээг хангахад хэтэрхий жижиг болж, 1969 онд зах зээлийг хотын зах руу шилжүүлснээр энэхүү худалдааны төв байгуулагджээ. Ранжис нь төмөр зам, хурдны замаар явахад хялбар, Орли олон улсын нисэх онгоцны буудалтай ойрхон байрладаг маш том давуу талтай.

2023.10.13. Flower Department of Rungis International Market (БНФУ, Ранжис хот)



2023.10.13. “La Bergerie Nationale” сургалтын төв (БНФУ, Рамбуйе хот 2023.10.13)



Ранжис захаас гарсан хог хаягдлыг дахин боловсруулж, шатаах зуухнаас гаргаж авсан эрчим хүчийг зах болон ойролцоох Орли нисэх онгоцны буудлыг халаахад ашигладаг байна.

Өдөрт 13,000 хүн ажиллаж, 26,000 тээврийн хэрэгсэл орж гардаг. Мөн өдөрт 18 сая хүн ямар нэг байдлаар Ранжис захын бүтээгдэхүүнийг хэрэглэдэг байна.

Кофены шааранд мөөг тарьж, ургуулдаг Франц улсын “La Boîte à Champignons” үйлдвэртэй танилцлаа.

Тус компани нь 2016 оноос хойш үйл ажиллагаа явуулж эхлэн, кофены шааранд 3 төрлийн мөөг тариалж байна. Кофены шаар нь мөөгийг илүү ашиг шим, амттай болгож, байгаль экологид ээлтэй үйл ажиллагаа явуулахад тус болдог гэв.



2023.10.13. “La Boîte à Champignons” үйлдвэр



2023.10.13. Cheese Department of Rungis International Market (БНФУ, Ражжис хот 2023.10.13)



2023.10.13. Vegetable Department of Rungis International Market (БНФУ, Ражжис хот 2023.10.13)



2023.10.14. Бретанийн гүнгийн шилтгээн - Нантын түүхийн музей (БНФУ-ын Нант хот)

Тухайлбал Франц улсын аж ахуйн нэгжүүдэд хог хаягдлын асуудлаа шийдэхэд хүндрэл их гардаг бөгөөд зөрчсөн тохиолдолд хатуу хариуцлага үүрдэг. Тиймээс энэ төрлийн бизнес эрхлэгчид тус мөөгний үйлдвэрийн чухал түүхий эд болох кофены шаарыг үнэгүй өгч, хаягдлыг нь шийдэж өгсөнд талархан төлбөр төлдөг байна. Нийт цугласан кофены шаарны 10 хувийг нь л ашигладаг. Харин үлдсэн 90 хувийг бордоо болгож байна.

Франц улсын хүнс, хөдөө аж ахуйн чиглэлийн “La Bergerie Nationale” сургалтын төвтэй танилцлаа.

1786 онд 16-р Людовик Франц улсын хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хүчирхэгжүүлэх зорилгоор энэхүү сургалтын төвийг байгуулсан бөгөөд өнөөдрийг хүртэл тогтвортой үйл ажиллагаа явуулж иржээ. Иймд Франц улсын хөдөө

аж ахуйн салбарын онцлог, мэдлэг туршлага бүхэн энэ сургалтын төвд нэвт шингэсэн байна.

Тус сургалтын төвд 15-22 насны 420 оюутан суралцан мал үржүүлэг, эмчилгээ, морин спортын чиглэлээр мэргэшиж байна. Сурагчдын 70 хувь нь байрлаж хичээллэдэг. Мөн нийт төгсөгчдийн 85 хувь нь шууд ажлын байртай болдог, үлдсэн хувь нь үргэлжлүүлж суралцдаг байна.

Энэхүү сургалтын төвд гаднын оюутан сурагчид хэдий ховор байдаг боловч Монгол улстай хамтран ажиллаж, оюутнуудаа Монгол улс руу явуулахыг хүсэж байгаагаа илэрхийлж байв.

Мөн айлчлал өндөрлөх өдөр /2023.10.14/ Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх, Бүгд Найрамдах Франц Улсын Ерөнхийлөгч Эммануэл Макроны ивээл дор зохион байгуулж буй “Чингис хаан – Монголчууд дэлхийг өөрчилсөн нь” үзэсгэлэнгийн нээлтийн ёслол боллоо. Энэ үеэр монголын экспортын чиг баримжаатай бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдав.



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх гэргий Лувсандоржийн Болорцэцэгийн хамт Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ерөнхийлөгч Во Ван Тыенг-ийн урилгаар 2023 оны 11 дүгээр сарын 01-05-ны өдрүүдэд Вьетнам Улсад төрийн айлчлал хийв.



Айлчлалын үеэр талууд улс төр, аюулгүй байдал, батлан хамгаалах, эдийн засаг, боловсрол, шинжлэх ухаан, технологи, зам тээвэр, ложистик, соёл, аялал жуулчлал, иргэдийн солилцоо зэрэг хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх бодит арга хэмжээний талаар болон бүс нутаг, олон улсын харилцан сонирхсон асуудлаар санал солилцов. 2024 онд тохиох Монгол, Вьетнамын хооронд дипломат харилцаа тогтоосны түүхт 70 жилийн ойг тохиолдуулан хоёр улсын харилцааг “Иж бүрэн түншлэл”-ийн түвшинд хүргэх чиглэлээр идэвхтэй хамтран ажиллахаар санал нэгджээ.



2023.11.02. Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ерөнхийлөгчийн ордон (Ханой хот)

Талууд 2019 онд байгуулсан “Хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах тухай санамж бичиг”-ийн хэрэгжилтийг үр дүнтэйгээр хангаж үргэлжлүүлэн ажиллахаар тохирлоо. Монгол Улсаас БНСВУ-д экспортлох ямаа, хонины махны “Мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээ” болон БНСВУ-аас Монгол Улсад экспортлох шувууны мах, махан бүтээгдэхүүний “Мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээ”-г тус тус харилцан тохирсон нь хоёр улсын хооронд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний солилцоо хийх таатай нөхцөл бүрдүүлэв.

V
E
T
N
A
M



Айлчлалын үеэр талууд дараах баримт бичигт гарын үсэг зурав. Үүнд:



Дипломат, албан болон энгийн паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр;




Монгол Улсаас БНСВУ-д экспортлох ямаа, хонины махны “Мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээ” болон БНСВУ-аас Монгол Улсад экспортлох шувууны мах, махан бүтээгдэхүүний “Мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээ”.



Үндэстэн дамнасан мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх тухай Монгол Улсын Хууль зүй, Дотоод хэргийн яам, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Нийгмийн аюулгүй байдлын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг;

Цагаан будааны худалдааны тогтвортой нийлүүлэлтийн тухай Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Аж үйлдвэр, худалдааны яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг;



Стратеги судалгааны чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Нийгмийн аюулгүй байдлын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг;

Хамтран ажиллах тухай Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Нийгмийн аюулгүй байдлын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг;

Мэдээлэл солилцоо болон цагаачлалын менежментийн тухай Монгол Улсын Хууль зүй, Дотоод хэргийн яам, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Нийгмийн аюулгүй байдлын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг;



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх гэргийн хамт Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ерөнхийлөгч Во Ван Тьенг болон Вьетнамын ард түмэнд Монголын төлөөлөгчдийг халуун дотно, найрсгаар хүлээн авч буйд талархал илэрхийлж, Ерөнхийлөгч Во Ван Тьенг-ийг ирэх 2024 онд тохиох Монгол, Вьетнамын хооронд дипломат харилцаа тогтоосны түүхт 70 жилийн ойн хүрээнд Монгол Улсад төрийн айлчлал хийхийг урив.



БИЗНЕС ФОРУМ:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Франц улсад хийсэн төрийн айлчлалаас эхэлсэн шинэ жишиг болох бизнес форум, бизнес тур арга хэмжээг хослуулан зохион байгуулах ажил БНСВУ-д мөн амжилттай хэрэгжив.

Монгол- Вьетнамын бизнес форумд хоёр улсын 200 орчим бизнес эрхлэгчид оролцож, хамтран ажиллах гэрээ байгууллаа. Энэхүү форумд Монгол Улсын Ерөнхийлөгч биечлэн оролцож, Монгол, Вьетнамын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хүнс, хөдөө аж ахуй, уул уурхай, зам тээвэр, эрчим хүч, байгаль орчин, аялал жуулчлал зэрэг бүхий л салбарт өргөжүүлэн хөгжүүлэх нөөц боломж байгааг онцлон тэмдэглэв.

Бизнес форумын үеэр Вьетнам Улсын Вьет-Жет авиакомпанийн Начанг-Улаанбаатар-Начанг чиглэлийн нислэгийн нээлтийн ёслол арга хэмжээ боллоо. Энэхүү нислэг нь 2023 оны 12 дугаар сарын 15-наас эхлэн тогтмол давтамжтайгаар хийгдэж эхлэх юм.



Мөн 30 гаруй Монголын үндэсний үйлдвэрлэгчийн бараа бүтээгдэхүүнийг танилцуулсан үзэсгэлэн зохион байгуулагдлаа.

Бизнес форумаар Монголын хүнс, хөдөө аж ахуйн салбарын мэргэшсэн холбоодын нэгдэл “Хүнсний хувьсгал” төрийн бус байгууллагын Удирдах зөвлөлийн гишүүн Т.Мөнхтөр “Монгол-Вьетнамын хүнс, хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагааны боломжууд” болон, “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийн талаар танилцууллаа.



2023.11.03. (БНСВУ, Ханой хот, Тхай Бинь муж)

БИЗНЕС АЯЛЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлалын хүрээнд үндэсний үйлдвэрлэгчдийг туршлага судлуулах, хамтын ажиллагааг нь дэмжих зорилгоор БНСВУ-д Бизнес тур зохион байгууллаа. Энэ хүрээнд Ханой хотын Нам Танг Лонг аж үйлдвэрийн паркт байрлах “Бао Мин” хүнсний үйлдвэр болон “Тхай бинь сийд” будааны үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцав. Бизнес группийг Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаяр ахлан ажиллав.

“Бао Мин” хүнсний үйлдвэр:

“Бао Мин” хувьцаат компани нь 2006 онд байгуулагдсан, ногоон будааны төрөл бүрийн жигнэмэг, бялуу, амттан үйлдвэрлэдэг БНСВУ-ын тэргүүлэгч үндэсний үйлдвэр юм.

“Бао Мин” үйлдвэр нь ISO 22000:2005 стандартад нийцсэн машин механизмын системтэй, орчин үеийн тоног төхөөрөмж, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйг бүрэн хангасан 2 үйлдвэр байртай, өдөрт 30 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж савлах, хадгалах хүчин чадалтай.

“Тхай Бинь Сийд” цагаан будааны үйлдвэр:

Монгол улсын 80 гаруй бизнес эрхлэгч Тхай Бинь хотод байрлах 50 жилийн түүхт “Тхай Бинь Сийд” будааны үйлдвэрт зочиллоо.

Тус компани нь европ технологи бүхий өндөр чанартай үр боловсруулах 2 үйлдвэр, үрийн судалгааны лаборатори, туршилтын лаборатори, тариалангийн судалгааны хүрээлэн зэрэг үйлдвэрлэл, боловсруулалт хийх дэд бүтцийг бүрэн шийдсэн.

Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001: 2008 ISO/IEC 17025-2005, TQM-ийг хэрэгжүүлсэн бөгөөд Ази, Номхон далайн үрийн холбооны гишүүн, Вьетнамын үрийн худалдааны нийгэмлэг (VSTA), Вьетнамын худалдаа, аж үйлдвэрийн танхим (VCCI), Тайландын Бинх аж ахуйн нэгжийн нийгэмлэг (ТВЕА) -ийн гишүүн бөгөөд 2012 оноос хойш шинжлэх ухаан, технологийн салбар луу орж үйл ажиллагаагаа өргөжүүлсэн юм.



“Хүнсний хувьсгал”-ын хүрээнд байгуулагдсан хүнс, хөдөө аж ахуйн салбарын мэргэшсэн холбоодын нэгдэл “Хүнсний хувьсгал” ТББ-ын БНСВУ-ын хөдөө аж ахуйн “Digital agriculture alliance” холбоотой хамтын ажиллагааны санамж бичиг байгуулахаас гадна тус улсын салбартаа тэргүүлэгч DABACO группийн үйл ажиллагаатай танилцлаа.

“DABACO” группийн Ерөнхий захирал, БНСВУ-ын Хөдөлмөрийн баатар, 14-р Үндэсний Ассамблейн гишүүн Нгуен Нху Со өөрийн биеэр группийн үйл ажиллагаагаа танилцуулж, талууд хамтран ажиллах нөхцөл боломжийн талаар санал солилцсон юм.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн
Гадаад бодлогын зөвлөх **Э.Одбаяр**:



**Ерөнхийлөгчийн
санаачилсан
хөдөлгөөн дэлхий
нийтийн тулгамдсан
асуудлуудыг
шийдвэрлэхэд хувь
нэмэр оруулна**



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх хөрс, хүнс, хүнээ эрүүл байлгахыг эрхэмлэн гурван салбарыг түлхүү дэмжиж байна. Энэ хүрээнд “Тэрбум мод”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Эрүүл монгол хүн” гэсэн гурван хөдөлгөөнийг санаачлан эхлүүлсэн. Эдгээр хөдөлгөөн амжилттай хэрэгжих нь зөвхөн манай улсад бус олон улсын түвшинд ач холбогдолтой зүйл юм. Бид ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй үндэсний хөдөлгөөнүүдээр дамжуулан дэлхий нийтэд тулгамдаж буй асуудлыг шийдэхэд тодорхой хувь нэмэр оруулж байна гэсэн үг. Үүнийг гаднын улс орнууд болон олон улсын байгууллагууд эерэгээр харж, сайшааж байгаа. Мөн харилцан ашигтай хамтын ажиллагааг эхлүүлэх санамж бичиг, гэрээнүүдэд гарын үсэг зурсан нь манай улсын үндэсний үйлдвэрлэгч, баялаг бүтээгчдэд маш том боломж болж, дэлхийн зах зээлд гарах замыг нь нээж өгсөн. Үүнээс гадна айлчлалын


бүрэлдэхүүнд салбар тус бүрийн бизнес эрхлэгчдийг багтаан бизнес форум болон бизнес аялал арга хэмжээнүүдийг зохион байгуулж тухайн улсын бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллах, туршлага судлах нөхцөлөөр хангадаг шинэ жишиг тогтоосон.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлалуудын гол онцлог нь зөвхөн манай тал айлчлаад өндөрлөх бус харилцан айлчилдаг буюу хоёр урсгалтай болсон явдал юм. Талууд харилцан айлчлал хийснээр найрсаг харилцаа, хамтын ажиллагаа илүү батжиж, гадаад харилцаагаа хөгжүүлэх шинэ боломж бүрддэг. Ирэх 2024 онд өмнөх туршлагууддаа суурилан дэлхий нийтийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд Монгол Улсын оруулж ирсэн хувь нэмрийг улам өсгөх, үндэсний хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд гадаад харилцааг өргөтгөн хөгжүүлж, түүний үр өгөөжийг улам нэмэгдүүлэхийг зорино.





LAOS



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад хийж буй төрийн айлчлалын хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны дараах баримт бичгийг байгуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Ерөнхийлөгч Тонглун Сисүлитийн урилгаар 2023 оны 11 дүгээр сарын 05-07-ны өдрүүдэд тус улсад төрийн айлчлал хийлээ.



2023.11.06. Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Ерөнхийлөгчийн ордон (Вьентьян хот)



Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, БНАЛАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хооронд хамтран ажиллах санамж бичиг



Ургамал хамгаалал, хорио цээрийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр



Мал эмнэлэг, мал амьтны хорио цээрийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр

Байгалийн нөөц, байгаль орчныг хамгаалахад хамтран ажиллах тухай Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Байгалийн нөөц, байгаль орчны яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг

Соёлын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Соёлын яам, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Мэдээлэл, соёл, аялал жуулчлалын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг



Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Мэдээлэл, соёл, аялал жуулчлалын яам хоорондын хэлэлцээр






2023.11.06. Landmark Mekong Riverside зочид буудал (БНАЛАУ, Вьентьян хот)

БИЗНЕС ФОРУМ:

Вьентьян хотод зохион байгуулагдсан бизнес форумын үеэр хоёр улсын бизнес эрхлэгчдийн дунд B2B уулзалт, Монгол Улсын экспортын бараа бүтээгдэхүүний танилцуулах үзэсгэлэн худалдаа боллоо. Монголын 30 орчим үндэсний үйлдвэрлэгчдийн 500 гаруй бүтээгдэхүүнийг БНАЛАУ-ын албаны хүмүүс болон бизнес эрхлэгчид үзэж, үйлдвэрлэгчдэд хамтран ажиллах, бүтээгдэхүүн худалдан авах саналууд ирсэн юм.



БИЗНЕС АЯЛЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС:

Энэхүү айлчлалын хүрээнд монголын хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, аялал жуулчлал, уул уурхай гэх мэт салбарын 80 орчим үйлдвэрлэгч, бизнес эрхлэгч БНАЛАУ-ын туршлагаас судлан, зах зээлд нэвтрэх боломжийг эрэлхийллээ.




2023.11.05. Патусай-Ялалтын хаалга (БНАЛАУ, Вьентьян хот)

Itecc mall:

Монгол Улсаас туршлага судлахаар зочилж буй бизнес эрхлэгчдийн багагүй хувь нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид байснаараа онцлог. Тиймээс Лаос улсын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүнээ борлуулдаг шөнийн захаар зочилж туршлага судаллаа.



2023.11.06. Вьентьян хотын логистикийн төв (БНАЛАУ, Вьентьян хот)



Таналенг хуурай боомт:

БНАЛАУ болон Монгол улс нь далайд гарцгүй гэдгээрээ адилхан бөгөөд зөв зохион байгуулалт бүхий хуурай боомтыг бий болгосноор үр ашигтай ажиллах боломжийг монголын бизнес эрхлэгчид тус улсаас судаллаа. Мөн “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд тээвэр логистикийн асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэхээр зорьж байгаа тул энэхүү хуурай боомтын сайн туршлагыг судлах нь ихээхэн ач холбогдолтой юм.

Тус боомт нь НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрээр батлагдсан “Олон улсын ач холбогдол бүхий” 9 хуурай боомтын нэгд багтдаг бөгөөд Меконг мөрний дээгүүр орших анхны найрамдлын гүүрнээс ердөө 1 км-ийн зайд оршдог.



Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний
бодлогын зөвлөх, доктор (Ph.D), профессор
Чимиддоржийн **ДАВААБАЯР**:

**“Аливаа ажлыг үр дүнтэй
болгохын тулд санхүүжилтийг
шийдвэрлэх нь тухайн
салбарын амь тариа болдог**

- “Хүнсний хувьсгал” хөдөлгөөнийг ганц салбарын яам хэрэгжүүлэх бололцоогүй. Үндэсний хэмжээний хөдөлгөөн гэдэг утгаар нь авч үзвэл олон талын оролцоо чухал байна байх?

- Монгол Улсын Ерөнхийлөгч улс орны нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор “Халамжаас хөдөлмөрт, Олборлолтоос боловсруулалтад, Импортоос экспортод” шилжих суурь реформын хүрээнд “100 жил-10 зорилт” хөгжлийн санаачилгыг дэвшүүлсэн. Энэхүү санаачилгын нэг чухал зорилт нь хүнсний аюулгүй байдлыг хангах, эрүүл, аюулгүй хүнсээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах, мал аж ахуй, газар тариалангаа эрчимжүүлэн хөгжүүлэх, бүс нутагтаа хүнс экспортлогч улс болох явдал юм.

“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд нийт 114 ажлыг төлөвлөн ажиллаж байна. Үндсэн ажлыг нугалах салбар бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам юм. Түүнчлэн уг хөдөлгөөнийг хэрэгжүүлэхээр УИХ-ын дөрвөн байнгын хороо, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэргэдэх Хүнсний төсөл хөтөлбөрийн алба, Хүнс, хөдөө аж ахуйн салбарын эрдэмтдийн зөвлөл, төрийн захиргааны 35 байгууллага, олон улсын байгууллагууд, “Хүнсний хувьсгал” ТББ, арилжааны 10 банк, хэвлэл мэдээллийн баг зэрэг өргөн бүрэлдэхүүнээр ажиллаж байна.

- Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүнийг экспортлох асуудлыг та юу гэж бодож байна вэ?

- Монгол Улс бол мал аж ахуйн орон. Ийм ч утгаараа эдийн засгийн томоохон хөшүүрэг болно гэдэгт итгэдэг. Мал аж ахуйн салбарт 240 гаруй мянган айл өрх, 70 гаруй сая малыг хариуцан ахуй амьдралаа залгуулан, Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд тодорхой хувь нэмэр оруулан ажиллаж байна. Хэдий хангалттай тооны малтай, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, дотоодын хэрэгцээгээ хангах, цаашлаад экспортлох бүрэн нөөц боломж байгаа мэт харагдаж байгаа боловч малын эрүүл мэндийн асуудлыг бодлогоор шийдвэрлэхгүй бол хүн амын хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх, экспортын зах зээлд байр сууриа эзэлхэд хүндрэл учирна. Иймд Монгол Улсын Засгийн газраас экспортыг дэмжих зорилгоор тусгаарлах бүс байгуулах, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2022 онд 27 тэрбум төгрөг, 2023 онд 59,4 тэрбум төгрөг, 2024 онд 69.8 тэрбум төгрөг тус тус төсөвлөн үр дүнтэйгээр ажиллаж байна.

Мах, махан бүтээгдэхүүний аюулгүй байдал, экспортын чиг баримжаатай үйлдвэрлэлийг тогтвортой ажиллуулахын тулд **WOAH** (Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага) **CODEX** (Хүнсний аюулгүй



2023.09.30. Сэлэнгэ аймаг Зүүнбүрэн сум
эрчимжсэн үхрийн аж ахуй



2023.02.02. "Жин туул" ХХК хамт олон



2023.09.20. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 78 дугаар чуулган (АНУ, Нью Йорк хот)



2023.09.15. Хөгжиж буй орнуудын 77-гийн бүлгийн дээд түвшний уулзалт (Бүгд Найрамдах Куба Улс)



2023.11.29. "Төгс Ургац" ХХК-ийн дөрвөн улирлын гидропоник хүлэмж

байдлын конвенц) гэсэн суурь стандартыг нэвтрүүлэх шаардлагатай.

Бид дээрх стандартыг нэвтрүүлснээр нэгдсэн нэг чанарт шилжиж, монгол махны брэндийг бий болгож, нэг цонхны бодлогоор махыг экспортолно.

Мөн адил манай газар тариалангийн салбар сэргэн хөгжиж, сүүлийн жилүүдэд хангалттай хэмжээний ургацыг хүлээн авч, улаанбуудай, улаанбуудайн гаралтай бүтээгдэхүүн (хивэг, гурил, хүүхдийн будаа) төмс болон зарим төрлийн тэжээлийг экспортлох боломж харагдаж байна.

Иймд Дэлхийн худалдааны байгууллагын "Эрүүл ахуй, ургамлын хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэх хэлэлцээр", ХАА-н гаралтай бүтээгдэхүүнийг экспортлох, импортлох Ургамал хамгааллын олон улсын конвенц (IPCC)-д нэгдэх шаардлагатай байна.

Ер нь манай улсын нийт нутаг дэвсгэрийн 77 хувь нь цөлжилтөд өртөөд байна. Малчид тооны араас биш мах, сүүний чиглэлийн гэх мэт ашиг шимээр төрөлжүүлэх, газар тариалангийн хувьд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон технологийг нэвтрүүлэх, хөрсний үржил шимийг сайжруулах нь чухал.

-Манай улс жимс жимсгэнийг бараг 100 хувь гаднаас оруулж ирдэг. Тус хөтөлбөрт энэ тал дээр ямар зорилт дэвшүүлээд байна вэ?

Монгол Улсын Ерөнхийлөгч Хүнс эрүүл бол монгол хүн эрүүл байна. Монгол хүн эрүүл бол монгол үндэстэн хүчирхэг байна гэдгийг УИХ-ын чуулганы индэр дээрээс хэлсэн. Жимс жимсгэнэ бол хүн амыг эрдэс, амин дэмээр хангах, хүнсний шим тэжээлийг нэмэгдүүлэх үнэт түүхий эд. Ийм ч утгаараа бид ургадаг хүнсийг "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнтэй уялдуулан, тарих модны 200 сая нь жимс, жимсгэнийн мод байхаар зорилтыг дэвшүүлсэн.



2023.03.20 Монголын анхны Махны чиглэлийн "Оргио" тахианы аж ахуйн цогцолбор

- Хяналтын тогтолцоог хэрхэн сайжруулах вэ?

- Хүнсний аюулгүй байдлын хяналтын тогтолцоог сайжруулах нь бидний тулгамдсан асуудлын нэг. Тэр дундаа хүнсний түүхий эд бүтээгдэхүүний худалдааны аюулгүй байдалд нэн тэргүүнд анхаарах нь зүйтэй. Ийм ч утгаараа хүнсний эрүүл, аюулгүй байдлыг бүрэн хангасан төвлөрсөн худалдааны төв, логистикийн төвтэй болох хэрэгтэй.

Өөрөөр хэлбэл, жижиглэнгээр худалдан борлуулах эрхээ тухайн худалдааны төвөөс авдаг тогтолцоонд бид шилжих хэрэгтэй. Бүтээгдэхүүний хадгалалт, хүргэлтийг нэг дор төвлөрүүлсэн төвөөр дамжуулж хүнсээ шийддэг туршлага олон улсад байна. Хүнсний түүхий эд бүтээгдэхүүний худалдаа ийм жишиг тогтолцоо руу шилжих нь энэхүү хөдөлгөөний нэг хэсэг байх болно.

Ингэснээр хүнсний түүхий эд бүтээгдэхүүний гарал үүсэл илүү тодорхой, аюулгүй байдал хангагдахын зэрэгцээ хяналт тавихад хялбар болно.

-Үндэсний хөдөлгөөний зорилтот хугацаанд бид ямар үр дүнд хүрсэн байх бол?

УИХ-ын 36-р тогтоолыг бүрэн төгс, бодитоор хэрэгжүүлж чадвал монголчууд бид 19 гол нэр төрлийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, цаашлаад 56 нэрийн бүтээгдэхүүнийг дотоодоосоо хангах болно. Цаашлаад дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын нэр төрөл нэмэгдэнэ гэж харж байна.

Аливаа ажлыг үр дүнтэй болгохын тулд санхүүжилтийг шийдвэрлэх нь тухайн салбарын амь тариа болдог.

Ийм ч учраас 2023 онд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлд нийт 2000 орчим иргэн, аж ахуйн нэгжид 700 гаруй тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгоод байна.

Ярилцсан: Б.Туул

Монголы үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлаг



2023.08.21. Дархан-Уул аймаг эрдэнэшиш, малын ногоон тэжээл, шар буурцаг, вандуйн тариалангийн талбайд.

ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧИД БА ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ



2023.10.01. "Газар Агро" ХХК
(Сэлэнгэ аймаг, Зүүнбүрэн сум)

"Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх нийт 55 үндэсний үйлдвэрт ажиллаж, санал хүсэлтийг нь сонсжээ. Энэ хүрээнд гаргасан бодлого шийдвэрүүд нь хүнс, хөдөө аж ахуйн салбараа сэргээх, монголд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн дэлхийн брэнд болох эхлэл болсон юм.



2023.10.01. "Эг тариа" ХХК
(Булган аймгийн Хутаг-Өндөр сум)

**БУЛГАН
АЙМГИЙН
ХУТАГ-ӨНДӨР
СУМЫН ГАЗАР
ТАРИАЛАН
ЭРХЛЭГЧИД**



Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Хантай багийн нутагт ажиллаж, газар тариалан эрхлэгчдийн төлөөлөлтэй уулзлаа. Булган аймаг энэ жил 55.5 мянган га талбайд тариалалт хийсэн бөгөөд урьдчилсан балансаар 37 мянган га талбайгаас 50 мянган тн улаанбуудайн ургац хураан авах тооцоо гарчээ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Хүнсний хувьсгал" нь хүнс, хөдөө аж ахуйн салбарт маш том дэмжлэг болж, тариалалт нэмэгдэж байгааг тариаланчид хэлж байв.





2023.02.06. "Есөн Од" ХХК

"Есөн од" ХХК

2004 онд дотоодын зах зээлд "Голден Гоби" шоколадыг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд одоогоор 100 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Дотоодын зургаан үйлдвэр шоколад, шоколадан бүтээгдэхүүний зах зээлийн долоон хувийг хангадаг бөгөөд 93 хувийг экспортын бүтээгдэхүүн эзэлдэг.



"Сүү" ХК

"Сүү" ХК-ийн үйлдвэрийг 1958 онд нийслэлийн хүн амыг сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах зорилгоор байгуулсан түүхтэй. Одоогоор 4200 харилцагч, 511 ажилтан, 7,000 хувьцаа эзэмшигчтэйгээр үйл ажиллагаа явуулж, хоногт 130-180 тн сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулан, 70 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Улаанбаатар хот орчим болон Төв, Дархан, Сэлэнгэ, Орхон, Хэнтий аймгийн 30 гаруй чиглэлийн 2,500 малчин, фермерээс жилийн турш сүүг нь авч байна. 2022 оны 12 дугаар сарын байдлаар гэхэд л 27.8 тэрбум төгрөгийн 21.2 сая литр сүү татан авчээ.



2023.02.06. "Сүү" ХХК

"Сүү" ХК-ийн ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.БОЛОД:

“Сүү, цагаан идээ нь монголчуудын хүнс тэжээлийн голлох бүтээгдэхүүний нэг бөгөөд хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай. Нэг хүн амд ноогдох сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ нь улс орны үндэстний хөгжлийн түвшний чухал үзүүлэлтүүдийн нэгд тооцогддог. Иймд сурагчдын “Үдийн цай” хөтөлбөрт сүү, сүүн бүтээгдэхүүн заавал байх ёстой.



"ЭЙЛ БИ ЭЙЧ ТЕХНОЛОГИ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ О.ДАШДУЛАМ:

“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн хэрэгжиж эхэлсэн нь манай компанийн хувьд маш том боломж олголоо. Бид эрдэмтдийн багийн судалгаанд үндэслэн монгол малын ашиг шимийг нэмэгдүүлэх, цаашлаад цөлжилт, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тэмцэхэд чухал нөлөө үзүүлэх бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Олон удаагийн туршилтаар баталгаажсан, үр дүнтэй бүтээгдэхүүнээ олон нийтэд таниулах л хамгийн том асуудал болоод байна.



"Эйл Би Эйч Технологи" ХХК

2019 оноос био-технологийн чиглэлээр судалгаа шинжилгээ, үйлдвэрлэл явуулж байгаа бөгөөд мал, амьтанд зориулсан Мимо эрдсийн нэмэлт бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж байна. Мимо эрдэст нэмэгдэл тэжээл нь малын ерөнхий эрүүл мэнд, дархлаанаас гадна тэжээл шингэцийг 10-20 хувь сайжруулдаг. Мөн тэжээлийн зардлыг 10-20 хувь бууруулж, сүүн ашиг шимийг 10-15 хувь, махан ашиг шимийг 20-25 хувь нэмэгдүүлэн, малын биеийн хорыг саармагжуулж, хорт бодисыг гадагшлуулдаг байна.



2023.02.06. "Эйл Би Эйч Технологи" ХХК



ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ
Хөрс эрүүл бол хүнс эрүүл



“ӨГӨӨМЖ АРХАД” ХХК-ИЙН ЗАХИРАЛ Н.ЭНХЖАРГАЛ:

“Цар тахлын үед төрөөс аж ахуйн нэгжийн цахилгаан, дулаан, усны төлбөрийг бүрэн хариуцаж байсан нь ажлын байрыг хадгалах, үйл ажиллагаагаа хэвийн явуулахад томоохон дэмжлэг болсон. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөнд манай хамт олон идэвхтэй оролцож, хүн амаа эрүүл хүнсээр хангахад хамтран ажиллах болно. Цаашид энэ ажлын хүрээнд дотоодын аж ахуйн нэгжүүдээ татварын бодлогоор дэмжээсэй гэж хүсэж байна.

“Өгөөмж архад” компани

2000 онд байгуулагдсан тус компани 130 гаруй ажилтан, албан хаагчтай, 30 гаруй нэр төрлийн нарийн боов, 30 нэр төрлийн бялуу, бэйкери, кофе шопийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Дотоодын гурил, гурилан бүтээгдэхүүний зах зээлийн 14 орчим хувийг хангадаг бөгөөд үйлдвэрлэлийн нийт хүчин чадлын 50 хувийг хөөмөл, 25 хувийг чанамал бүтээгдэхүүн эзэлдэг байна.

2023.02.07. “Өгөөмж Архад” ХХК



2023.02.07. “Хүн Од” ХХК



“Хүн Од” ХХК

“Хүн од” ХХК 1992 онд байгуулагдсан. ХБНГУ-ын тоног төхөөрөмж, технологиор 1994 оноос хиам, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн үндэсний аж ахуйн нэгжийн нэг юм. Улсын хэмжээнд бүрэн зогсоод байсан нөөшилсөн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 2000 онд анхлан сэргээж, 2011 онд бүх төрлийн хиам, махан бүтээгдэхүүн савлах цехийг ашиглалтад оруулж байжээ. Шинээр бий болгосон “Агмос” брэндийн 16 нэр төрлийн хиам, 15 нэр төрлийн нөөшилсөн бүтээгдэхүүнээс гадна хаягдал өөхийг боловсруулж, саван үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж байна. 60 гаруй ажилчинтай.



2023.02.07. “Ивэн түрүү” ХХК (Сэлэнгэ аймаг Баруунбүрэн сум)

“ИВЭН ТҮРҮҮ” ХХК

Тус компани нь эргэлтийн 2100 га талбайтай. Энэ жил 1200 га талбайд улаан буудай, 400 га талбайд малын тэжээл, тосны ургамал тариалж байна. Жил бүрийн ургацаасаа дараа жилийн тариалалтад зориулан 200-300 тн чанар сайтай үрийг нөөцлөн лабораторийн шинжилгээнд хамруулж, нутагшуулан тариалж байгаа нь үр дүнгээ өгч усалгаагүй талбайгаас 24-28 центнер ургац хураан авч байна.



2023.02.07. "ЭкоПак Монгол" ХХК

**"ЭКОПАК МОНГОЛ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Ч.МӨНХБАЯР:**

“ Үндэсний үйлдвэрүүд амжилттай ажиллаж, импортын бүтээгдэхүүнийг орлохын тулд зээлийн хүртээмжийг сайжруулж, урт хугацаатай богино хүүтэй зээл авах боломжийг бүрдүүлэх, мөн тогтвортой ажиллах боловсон хүчин чухал байна.



"ЭкоПак Монгол" ХХК

Тус компани нь 100 гаруй ажилтантай бөгөөд 2010 онд дотоодын хөрөнгө оруулалтаар цаасан хайрцаг, сав, баглаа боодол үйлдвэрлэх бүрэн автомат үйлдвэрийг ашиглалтад оруулж байсан. Тэгвэл 2022 онд Монголын анхны цаасан хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийг нээсэн байна.

Хаягдал цаас дахин боловсруулах үйлдвэр нь нийлүүлэгчдээс хаягдал цаас худалдан авч, 100 хувь саарал ус ашиглан хайрцаг, сав, баглаа боодлын анхдагч түүхий эд болох бор цаасыг хоногт 30 тонныг үйлдвэрлэх хүчин чадалтай. Харин үндсэн үйлдвэр нь жилд дунджаар 25.2 сая ширхэг цаасан хайрцаг үйлдвэрлэх хүчин чадалтай. Өмнө нь энэ төрлийн бүтээгдэхүүнийг Монгол Улс импортоор авдаг байсныг орлож чадсан. Хоногт 70-80 мянган ширхэг цаасан хайрцаг үйлдвэрлэж байна.



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь 10,000 гаруй хувьцаа эзэмшигчидтэй олон нийтэд нээлттэй хувьцаат компани бөгөөд компанийн 91%-ийг Монгол Улсын иргэд эзэмшиж байна. СУ Хоол үйлдвэрлэлийн төв нь олон улсын хүнсний аюулгүй байдлын НАССР стандартын гэрчилгээтэй Монголын хамгийн анхны бэлтгэсэн хоолны үйлдвэр бөгөөд түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний чанарын хяналтын лаборатори, хоол үйлдвэрлэлийн хагас автоматжуулсан 5 шугам, гадна орчны бохирдлоос сэргийлэх вакум ариутгалын байгууламжтай. Өдөр бүр 30,000 гаруй бэлтгэсэн хоолыг шинээр үйлдвэрлэн СУ -ийн 300 салбар дэлгүүрт түгээн борлуулдаг.

Мөн тус компани өөрийн хүйтэн хэлхээний түгээлтийн төвөөр дамжуулан СУ Хоолны үйлдвэр болон дотоодын 40 гаруй үйлдвэрлэгчдийн 200 гаран нэр төрлийн, 80-100 мянган ширхэг шинэ хоол, температурын горим шаарддаг бүтээгдэхүүнийг СУ сүлжээний 300 дэлгүүрт өдөр бүр түгээдэг.

**"СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ
ЭС" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Г.ЧИНЗОРИГ:**

“ Манай компанийн хувьд бага хүүтэй, урт хугацаатай зээл хамгийн чухал. Учир нь шинэ салбар нээх бүрт их хэмжээний хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, боловсон хүчинг бэлтгэх шаардлага тулгардаг. "Хүнсний хувьсгал" бидний үйл ажиллагааг өргөжихөд дэмжлэг үзүүлнэ гэж итгэж байна.



2023.03.16. "Сэнтрал Экспресс Си Ви Эс" ХК





ХҮНСНИЙ ХУВСГАЛ



“Шинэ Гантиг” ХХК

2016 оноос Монгол улсын хөнгөн үйлдвэрийн салбарт уул уурхайн хүнд даацын шуудай үйлдвэрлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Тус компани нь уул уурхайн хүнд даацын шуудайны зах зээлийн ууган үйлдвэрлэгчдийн нэг бөгөөд уг салбарт байгуулагдсан 2 дахь үндэсний үйлдвэрлэгч юм.



2023.03.16. “Шинэ Гантиг” ХХК




“ШИНЭ ГАНТИГ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ж.ЦЭРЭННАДМИД:

“Монгол улсын хэмжээнд сав баглаа боодлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 50 гаруй аж ахуйн нэгж байдаг ба 2000 гаруй иргэдийг ажлын байраар хангаж жилдээ 150 орчим тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэсэн судалгаа бий. Энэ нь дотоодын үйлдвэрлэлийн нийт зах зээлийн 40 орчим хувь юм.



2023.04.13. “Еден” ХХК



“ЕДЕН” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ц.ХҮРЭЛБААТАР:

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд урт хугацаатай, хүү багатай зээл олгож, гаалийн албан татвар болон НӨАТ-ын чөлөөлөлт, хөнгөлөлт үзүүлж байгаа нь үйлдвэрлэлээ тасралтгүй явуулах, хүчин чадлаа нэмэх том боломж, дэмжлэг боллоо.



“ТРАСТ ТРЕЙД” ХХК

140 гаруй нэр төрлийн мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг “Траст трейд” компани нь 200 гаруй ажлын байр бий болгож, жил бүр улсад 800 саяас 1 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төлдөг. Цаашид мал төхөөрөх үйлдвэр нь ашиглалтад орсноор нэмж 100 хүнийг ажлын байраар хангах бөгөөд монголын нийт хэрэглэгчид илүү баталгаатай эрүүл махан бүтээгдэхүүн хэрэглэх юм.



2023.03.16. “Траст Трейд” ХХК (УБ хот, Налайх дүүрэг Городок)

“ЕДЕН” ХХК

Тус компани 80 гаруй ажилтантай. 20 орчим төрлийн жимсний чанамал, өтгөрүүлсэн шүүс үйлдвэрлэн 5,000 гаруй худалдааны цэгээр дамжуулан борлуулдаг. Увс, Завхан, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Ховд аймагт 300 гаруй бэлтгэн нийлүүлэгчтэй. Үйлдвэр нь хоногт 20,000-25,000 ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд шинэ сугам ашиглалтад оруулж үйлдвэрлэлээ өргөтгөхөөр төлөвлөж байна.

Цаашид жимс, ногоо боловсруулах шинэ үйлдвэр, 648 мв.кв талбай бүхий гүн хөлдөөх, 837 м.кв талбайтай бэлэн бүтээгдэхүүний агуулах барьж, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд жимс тариалах жишиг аж ахуй байгуулахаар төлөвлөжээ.

“ТРАСТ ТРЕЙД” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р.САНСАРМАА:

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд 5 жилийн хугацаанд дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах хүнсний бүтээгдэхүүний нэн тэргүүнд мах, махан бүтээгдэхүүн багтана. Иймд энэ салбарын үйлдвэрлэгчдэд үйл ажиллагаагаа өргөтгөж, хүчин чадлаа нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох асар их боломж бүрдэж байна.





2023.04.13. "Cheese Republic Mongolia" ХХК

CHEESE MONGOLIA REPUBLIC

Монголчууд дотооддоо 150-160 тонн бяслаг үйлдвэрлэж, импортоор 3,000 тн бяслаг авдаг гэсэн судалгаа байдаг. Бяслаг үйлдэрлэгчид юуны өмнө үйлдвэрлэлийн технологи, бүтээгдэхүүний чанарын шаардлагыг олон улсын түвшинд хүргэх, өрсөлдөх чадвараа сайжруулахыг зорьж байна.

"МОНГОЛЫН МЭРГЭШСЭН БЯСЛАГ ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН ХОЛБОО"-НЫ ТЭРГҮҮН Я.ЭНХЭЭ:

“ Төр, засгаас санхүү, хөрөнгө оруулалт, татвар гээд бүх талын дэмжлэг үзүүлбэл ойрын жилүүдэд Монголын гэсэн өвөрмөц онцлогтой бяслагаар дотоодын хэрэгцээгээ хангаж, улмаар экспортод гаргах бүрэн боломжтой.



“ХАНБОГД КАШИМЕР”

“Ханбогд Кашимер” ХХК 500 гаруй ажилтантай бөгөөд 80 гаруй хувь нь эмэгтэйчүүд эзэлдэг. Жилд 1,500 гаруй тонн ноолуур боловсруулж, 200,000 ширхэг сүлжмэл, 150,000 ширхэг нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Өнгөрсөн 24 жилийн хугацаанд ноолуурын экспортоор тэргүүлэгч аж ахуйн нэгжийн нэг болж, валютын нөөцийг нэмэгдүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулж иржээ.



2023.04.14. “Ханбогд Кашимер” ХХК

“УЛААНБААТАР ГУРИЛ” ХК

“Улаанбаатар Гурил” компани нь хамгийн сүүлийн үеийн эко горимтой Алапала брэндийн босоо технологиор, өндөр чанартай гурилыг үйлдвэрлэж байна. Уг технологи нь 100 хувь автомат бөгөөд цахилгаан зарцуулалтыг 25%, усыг 12% хэмнэдэг байгальд ээлтэй шийдэл юм. Тус компани нь 21 аймагт байрлах 4,000 харилцагчдаар дамжуулан эрүүл мэндийн болон үндсэн ангилал бүхий 10 гаруй төрлийн гурил болон дайвар бүтээгдэхүүнийг Монгол орон даяар нийлүүлэн ажиллаж байна.



2023.05.16. Төв аймаг, Борнуур сумын тариалангийн талбай



2023.05.17. “Улаанбаатар гурил ХК (Дархан-Уул аймаг)

Ургамал газар тариалангийн хүрээлэн

Үр тарианы селекцийн судалгааны үр дүнд үр тарианы 100 гаруй шинэ сорт бүтээж, 20 орчим сорт нутагшуулж үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байна. Төмсний таван сорт шинээр гарган, 13 сорт нутагшуулж, 15 сортыг ирээдүйтэй сортоор шалгаруулан үйлдвэрлэлд шилжүүлсэн. Шинэ сортын төмсний ургац улсын дунджаас 15-30 хувь илүү байна. Мөн хүнсний ногооны 68 сорт, жимс, жимсгэнийн 50 гаруй сортыг нутагшуулж, гоёл чимэглэлийн 5 сортыг тарималжуулсан нь үр дүнгээ өгчээ. Тус хүрээлэн 25,000-30,000 сортын үрийг дунд хугацааны горимоор хадгалах хүчин чадалтай бөгөөд урт хугацаанд хадгалах төхөөрөмжид 10,000 сорт дээж хадгалж байна.



2023.05.16. "Нэйшнл бизнес маркет" ХХК (Төв аймгийн Баянчандмань сум)

"НЭЙШНЛ БИЗНЕС МАРКЕТ" ХХК ДӨРВӨН УЛИРАЛ ХҮЛЭМЖИЙН АЖ АХУЙ У.ЭРДЭНЭЗОЛ:

“ Шөнийн цагт хэрэглэсэн цахилгааныг 100 хувь хөнгөлж, стандартын шаардлага хангасан өргөст хэмх, улаан пооль, чинжүү, навчит ногооны тн тутамд 100,000 төгрөгийн урамшуулал олгон, хүлэмж болон тоног төхөөрөмжийг импортоор оруулж ирэхэд гаалийн болон НӨАТ-аас 100 хувь чөлөөлсөн нь том дэмжлэг болж байна.



"НЭЙШНЛ БИЗНЕС МАРКЕТ" ХХК

Тус хүлэмж нь нэг дор 10,000 үрсэлгээ гаргаж, сард 20 тн, жилд 150-200 тн ургац хураан авах хүчин чадалтай. Цаашид 20.000 кв.м шилэн хүлэмж ашиглалтад оруулж, нарийн ногоог төрөлжүүлэн тариалах, 50-70 тогтмол ажлын байр бий болгох, импортын бүтээгдэхүүнийг орлох 1.500 тн нарийн ногоо зах зээлд нийлүүлэхээр төлөвлөжээ.



Малын удмын сангийн үндэсний төв

Малын удмын сангийн үндэсний төв 2022 онд дотооддоо 22 мянган тун үр үйлдвэрлэж, гадаад улсаас 16 мянган тун үр импортлосон байна. Энэ жил 24 мянган тун үр үйлдвэрлэж, 1,000 тун үр импортлох юм. Богино хугацаанд өндөр ашиг шимтэй мал гарган авах, нэгэн жигд өнгөтэй 14,0-15,0 микро нарийнтай ноолуур өгдөг ямаа олноор үйлдвэрлэх, дурангийн аргаар зохиомол хээлтүүлэг хийх зэрэг төсөл хэрэгжүүлж байна. 2024 он гэхэд Монгол Улсад баталгаажсан 56 үүлдэр, үүлдрийн хэсэг, омгийн стандарт, шаардлагад тэнцсэн хээлтүүлэгчээс үр үйлдвэрлэн үндэсний генийн санд бүрэн хадгалж дуусахаар төлөвлөжээ.



"БАЯЛАГ ТАХИА" ХХК

Тус компани нь "Махны чиглэлийн тахианы аж ахуйн цогцолбор"-ын төслийг 2022 онд эхлүүлж, 2023 оны 06 дугаар сард иж бүрэн автомат үйлдвэрийг ашиглалтад оруулжээ. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд жилд 50-60 сая ам долларыг импортод зарцуулж, 22.5 мянган тн тахианы махыг авдаг. Дотоодын аж ахуйн нэгжүүд жилийн хэрэгцээний 2-3 хувийг хангаж байсан юм. Харин тус үйлдвэр нь сард АНУ-ын "Ross-308" үүлдрийн 240 мянган ширхэг тахиа үржүүлэх, мөн цагт 3000 шувуу нядлах, ангилан боловсруулах, савлах, хадгалах хүчин чадалтай юм. Үйлдвэрийг ашиглалтад оруулснаар тахианы махны дотоодын хэрэгцээний 10 хувийг дангаараа хангах боломж бүрджээ.

Тус компани 350 ажлын байрыг шинээр бий болгосон бөгөөд ойрын 2-3 жилд хүчин чадлаа тав дахин нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээний 50 хувийг хангах зорилт тавьсан байна.



"БАЯЛАГ ТАХИА" ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Д.АНГАР:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд тус компанийн тахианы тэжээлийн үйлдвэр 1 тэрбум төгрөгийн зээл авсан. Харин "Баялаг тахиа" ХХК нь хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлөх хөнгөлөлтөд хамрагджээ. Монгол Улсын Ерөнхийлөгч "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг санаачилсны дараа тахианы махны импортыг бууруулж, дотоодын зах зээлд эрүүл, шинэ мах нийлүүлэх зорилгоор "Баялаг тахиа" төслийг эхлүүлсэн.



2023.09.29. "Баялаг тахиа" ХХК (УБ хот, СХД 21-р хороо 61 гарам)





2023.09.08. "АПУ" ХК-ийн "Монгол бяслаг, Шигүдэри" урлах үйлдвэр (Сэлэнгэ аймгийн Мандал сум)

"Монгол бяслаг" үйлдвэр

"Монгол бяслаг, Шигүдэри" урлах үйлдвэр нь Европын Холбооны стандартыг хангасан, байгаль орчинд ээлтэй тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон. Тус үйлдвэр нь бяслагийн дотоодын хэрэгцээний 20 хувийг дангаараа хангаж, импортын хамаарлыг бууруулах, монгол үнээний сүүгээр үйлдвэрлэсэн органик бяслагийг жилийн турш хэрэглэгчдэд нийлүүлэх боломжийг бүрдүүлж байна.

Монгол Улс жилд 3,000 орчим тн бяслаг буюу дотоодын хэрэгцээний 92 хувийг импортоор авдаг гэсэн судалгаа байдаг. Харин өнөөдрийн байдлаар дотоодын 10 гаруй үйлдвэрлэгч энэ салбарт үйл ажиллагаа явуулж байна.

СЭЛЭНГЭ ТАРИА ХХК

"Сэлэнгэ тариа" ХХК нь 12 мянган га эргэлтийн талбайтай бөгөөд 1 га тутмаас 20-22 центнер улаанбуудай болон үр тариа хураан авч, бусад үндэсний үйлдвэрүүдэд нийлүүлж байгаа аж. "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд тус ХХК нь "Анхан шатны үр үржүүлгийн төв, үтрэм байгуулах" төсөлд хамрагдаж, хөнгөлөлттэй зээл авчээ. Төслийн хүрээнд Цагааннуур суманд нийт 7,500 тн улаанбуудай, үр тариа хадгалах хүчин чадалтай, хатаалга болон цэвэрлэгээний бүрэн автоматжуулсан үтрэм шинээр байгуулахаар ажиллаж байгаа гэдгээ танилцууллаа.





2023.09.09. "Сэлэнгэ тариа" ХХК (Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум)



"МОНГОЛ БЯСЛАГ, ШИГҮДЭРИ" УРЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЗӨВЛӨХ С.ЦЭЦГЭЭ:

"Монгол бяслаг, Шигүдэри" урлах үйлдвэр нь хоногт 8-24 тн шингэн сүү хүлээн авч боловсруулан жилд 700 тн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд хаягдалгүй үйлдвэр.

"ГАЗАР АГРО" ХХК

Эрчимжсэн мал аж ахуйн жишиг фермер болсон "Газар Агро" ХХК нь 2008 оноос эхлэн хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн суманд жилдээ 1900-2000 га талбайд тариалалт хийдэг түүний 80 орчим хувьд нь улаанбуудай тариалж байна. Газар тариалангийнхаа суурин дээр мал аж ахуйгаа хөгжүүлэн 2012 оноос Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн, Баруунбүрэн сумын нутагт нь махны чиглэлийн сайжруулсан үүлдрийн үхрийн аж ахуйг эрчимжсэн технологийн дагуу эрхлэх дэд бүтцийг байгуулжээ.

"ГАЗАР АГРО" ХХК-ИЙН ЗАХИРАЛ Д.БАТЖАРГАЛ:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөн асар өндөр ач холбогдолтой, алсыг харсан бодлого гэж харж байна. "Идэж уухаа айлаас гуйхгүй өөрсдөө болгодог байя" гэх нь сонсоход жижиг мэт боловч улсын аюулгүй байдал яригдаж байна. Хэн нэгнээс хараат бус орчин бүрдүүлнэ гэдэг хамгийн чухал. Бид энэ хөдөлгөөн, санаачилгыг улсаараа дэмжиж, нэгдэн оролцох ёстой. Хоёрдугаарт, "хүнсний аюулгүй байдал" гэдэг дан ганц идэж уух асуудал биш, түүнийг үйлдвэрлэж байгаа үйлдвэрлэгч, аж ахуй нэгж, иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой асуудал. Үйлдвэрлэгч өөрөө эрүүл мэнд, аюулгүй байдлаа хангасан цагт хүнсээ эрүүл байлгаж, хүнсний аюулгүй байдал хангагдана гэж бодож явдаг.



2023.10.01. "Газар Агро" ХХК (Сэлэнгэ аймаг, Зүүнбүрэн сум)



2023.10.01. “Занаду Разорбак” ХХК
(Булган аймгийн Хутаг-Өндөр сум)



“ЗАНАДУ РАЗОРБАК” ХХК

Тус компанийн үүсгэн байгуулагч, Канад Улсын иргэн Жереми Тиссен 1993 онд Монгол Улсад анх ирсэн бөгөөд 2009 онд “Занаду Разорбак” ХХК-ийг үүсгэн байгуулжээ. Анх газар тариалангийн чиглэлээр ажиллаж байгаад 2011 оноос үйл ажиллагаагаа өргөжүүлж, махны чиглэлийн эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх болсон байна. “Занаду Разорбак” ХХК нь нийт 15 ажилчинтай бөгөөд өдөрт 10 үхэр нядлах хүчин чадалтай. Тус компани нь үхрийн гол бордоо болох ногоон тэжээлийг өөрсдөө бэлтгэдэг гэдгээрээ онцлогтой.

“ЗАНАДУ РАЗОРБАК”
ХХК ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ
ЖЕРЕМИ ТИССЕН:



**Монгол
үхрийн
мах амт,
чанараараа
дэлхийд
өрсөлдөх
боломж бий**



“ОРХОН ТАРИА” ХХК

Тус компани нь 2002 онд байгуулагдсан бөгөөд нийт 20 ажилчинтай. Сайн чанарын улаанбуудайг нутагшуулан тарьж үржүүлэх, төмс, хүнсний ногоог тариалж борлуулах, адуу, үхэр, шувуу, гахайн сүргийг фермерийн зохион байгуулалтаар өсгөж үржүүлэн сүү цагаан идээ боловсруулах, жимс, жимсгэний мод, бут сөөгийг тариалах үржүүлэх, хадлан тэжээл бэлтгэх зах зээлд нийлүүлэх чиглэлээр 21 дэх жилдээ үйл ажиллагаа явуулж байна. Нийт 1700 га эргэлтийн талбайтай бөгөөд энэ онд 960 га талбайд үр тариалсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд нийт 1.5 тэрбум төгрөгийн зээлд хамрагдсан байна.



“ОРХОН ТАРИА” ХХК-
ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
Д.ДЭЛГЭРБАЯР:

**Үндэсний хөдөлгөөний
хүрээнд хүнс, хөдөө
аж ахуйн гаралтай
түүхий эд боловсруулах
зориулалттай, шинэ
тоног төхөөрөмжийг
2027 он хүртэл гаалийн
албан татвараас
чөлөөлснөөр тоног
төхөөрөмжийн
импортын чиглэлд
ажиллаж буй
компаниудын үйл
ажиллагаа өргөжиж,
хүртээмж нэмэгдсэн. Энэ
нь тариаланчид бидэнд ч
давуу тал болж байна.**



2023.10.01. “Орхон тариа” ХХК
(Орхон аймгийн Жаргалант сум)



2023.09.29. “Бялхам ивээл” ХХК
(Сэлэнгэ аймгийн Баянгол сум)

“БЯЛХАМ ИВЭЭЛ” ХХК

Нийт 3 га ашигтай талбай бүхий зуны 66, үрсэлгээний 24 хүлэмж, мөн задгай талбайд туршилт, судалгааны зорилгоор төмс, чихэрлэг төмс, навчит ногоо, усан үзэм зэрэг 30 гаруй төрлийн ногоо, жимс тариалж байна. Үүнээс тарvas, амтат гуа, үрлэн помидор, өргөст хэмх, амтат чинжүү, хулуу, кимчи байцаа, эрдэнэшиш, хаш, бүдүүн ногоон сонгино, сармис гэх мэт 11 нэр төрлийн нарийн ногоог борлуулдаг.

“БЯЛХАМ ИВЭЭЛ” ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ КИМ СОН
ЧЕЛЬ:



**Монголд
ургасан
жимс
хамгийн
амттай.**





УИХ-ын дарга Г.Занданшатар, ажлын хэсгийн ахлагч төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Ерөнхийлөгчийн зөвлөх Ч.Даваабаяр нар үндэсний үйлдвэрүүд дээр ажиллалаа.

Татварын цогц шинэчлэл, Нийтийн буюу Төрийн санхүүгийн реформыг богино хугацаанд хийхээр УИХ-аас ажлын хэсэг гаран ажиллаж байна. Энэ хүрээнд Монгол Улсын татварын тогтолцооны өнөөгийн нөхцөл байдал, шинэчлэх хэрэгцээ шаардлагын талаар хэлэлцэх, гол асуудлуудыг тодорхойлох “Татварын цогц шинэчлэл” хэлэлцүүлэг зохион байгуулж, үйлдвэрлэгчдээс санал хүсэлтийг нь сонсож байна.

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаяр, Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх Б.Даваадалай болон Хүнсний хувьсгал ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүд УИХ-ын гишүүн, Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Ж.Батжаргалтай уулзаж, мал аж ахуй, газар тариалангийн салбарт тулгамдаж буй асуудлаар санал солилцлоо.



2023.12.05. Төрийн ордон

Монгол Улсад Шинжлэх ухааны үндэслэлтэй Мал эмнэлэг, үржлийн алба үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойн баярын хурал Төрийн ордонд боллоо.



2023.12.13. “Метагро” ХХК (Хэнтий аймгийн Хэрлэн сум)

Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаяр, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа болон бусад албаны хүмүүс мал аж ахуй, газар тариаланг харилцан ашигтайгаар хослуулан хөгжүүлж, Монгол махыг дэлхийн стандартад нийцүүлэн экспортлох гарааг эх орны зах зээлээс эхлүүлж буй “Метагро Хөдөө аж ахуйн цогцолбор”-ын үйл ажиллагаатай танилцлаа.



“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний зорилгыг биелүүлэхийн тулд

ТӨРӨӨС ЯМАР АРГА ХЭМЖЭЭ АВСАН БЭ?



■ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын нийгэм, эдийн засгийн ерөнхий төлөвийг 2022 оны статистик тоо, мэдээнээс харвал, тус салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 32.3 хувийг, мөн орон нутгийн үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь 85 хувь орчим байна. Нийт газар нутгийн 72.9 хувь хөдөө аж ахуйн эдэлбэр газар бөгөөд нийт ажиллах хүчний хоёр хүн тутмын нэг нь энэхүү салбарт хөдөлмөр эрхэлж байгаа тоо, мэдээ байна. Энэ нь манай улсын нийгмийн ихэнх үзүүлэлтэд ямар их ач холбогдолтой салбар вэ гэдгийг харуулж байгаа хэдий ч экспортын орлогоор авч үзвэл 5.5 хувь гэсэн чамлахаар дүнг харж болно.

■ Хүнсний аюулгүй байдлыг хангахад чухал нөлөө үзүүлэх үйлдвэрийн аргаар боловсруулсан махны хэмжээг нэмэгдүүлэх, чанар стандартын шаардлага хангасан орчинд махыг бэлтгэж нийтийн хэрэгцээнд нийлүүлэх зорилгоор Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтыг

2022 оны Засгийн газрын 224 дүгээр тогтоолоор баталсан.

Түүнчлэн сүү, сүүн бүтээгдэхүүний хангамж, хүртээмжийг тогтвортой байлгах, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам”-д Засгийн газрын 2023 оны 363 дугаар тогтоолоор сэрүүний улиралд үйлдвэр, цехэд нийлүүлсэн сүүний 1 л тутамд 500.0 төгрөг байсныг 1000.0 төгрөг болгож нэмэгдүүллээ.

■ Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг жигд, тогтвортойгоор хангах, үнийн хөөргөдөл, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийслэл болон орон нутагт стратегийн хүнсний улирлын нөөцийг бүрдүүлэхээр Засгийн газрын 2023 оны “Журам батлах тухай” 344 дүгээр тогтоолоор эрх зүйн орчныг бүрдүүллээ.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ЗЭЭЛ ЗЭЭЛИЙН ЯВЦЫН МЭДЭЭ /тэрбум төгрөг/

2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар



■ Гол нэрийн 19 хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах зорилтын хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, хоршоодод эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын зээлийг 5-6 хувийн хүүтэйгээр, 3-5 жилийн хугацаатай Мал аж ахуйн үйлдвэрлэлд 132.3 тэрбум төгрөг, Газар тариалангийн үйлдвэрлэлд 342.6 тэрбум төгрөг, Хүнсний боловсруулах, сав баглаа боодлын үйлдвэрлэлийг дэмжихэд 507.1 тэрбум төгрөгийн нийт **982.0 тэрбум** төгрөгийн зээлийг банкны эх үүсвэрээс олгохоор шийдвэрлэсэн.

Үүний хүрээнд өнөөдрийн байдлаар (2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар) хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлд нийт 1850 иргэн, аж ахуйн нэгжид 667.3 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна. Салбараар нь авч үзвэл Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр

449.9 тэрбум төгрөгийг, Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр 168.8 тэрбум төгрөгийг, Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр 48.7 тэрбум төгрөгийн зээл олгогдсон.

■ Түүнчлэн хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэхэд зориулан хөнгөлөлттэй зээл олгохоос гадна зарим бодлогын арга хэмжээг аваад байна. Үүнд хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай, тухайн үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх шинэ тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас 100 хувь хөнгөлөхөөр Засгийн газрын 2023 оны 107 тоот тогтоолоор баталсан. Тус тогтоолын хүрээнд 19 чиглэлийн үйлдвэрлэлийн 428 нэр төрлийн тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд чөлөөллөө.



■ Аж үйлдвэрийн салбарт хүнсний үйлдвэрлэл 2023 оны 9-р сард өмнөх оны мөн үеэс 70%-иар өссөн байна. Үүн дотроо мах боловсруулах үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 2 дахин, үр тарианы үйлдвэрлэл 49%, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 31%, бусад хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 25%-иар өссөн дүнтэй байгаа нь та бидний үр дүнг харуулж байна.

■ Цаашлаад дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, өөрсдөө тарьж ургуулах, өсгөж үржүүлэх болон боловсруулах, үйлдвэрлэх боломжтой барааны гаалийн импортын албан татварын хувь, хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж байна.




ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

/Улсын Их Хурлын
2022 оны 36 дугаар
тогтоол/



ХУДАЛДААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД /сая ам.доллар/



Хүнсний импорт үнийн дүнгээрээ буурч байна

- Нийт хүнсний бүтээгдэхүүний импорт 12%-иар буурах төлөвтэй.

Хүнсний экспортын орлого огцом өсөх таамаглалтай байна

- Хүнсний бүтээгдэхүүний экспортын орлого 2 дахин нэмэгдэх төлөвтэй байна.
- Махны экспортын тоо хэмжээ 2018 оныхоос давах төлөвтэй байна.
- Самрын экспортын үнэ 2023 онд 2018 оныхоос 3.65 дахин өссөн нь голчлон нөлөөлсөн байна.



ЕТГ-ын Хүнсний
төсөл, хөтөлбөр
хариуцсан
албаны дарга
А.Амаржаргал:

“ Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан 3 үндэсний хөдөлгөөн нь ус агаар мэт уялдаа холбоотойн адил Монгол хүнд зориулан үйлдвэрлэж буй хүнсийг бэлтгэхэд газар тариалан, мал аж ахуй, хөрсний шим тэжээл, усны нөөцийн бодлого, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа, технологи нь зайлшгүй харилцан бие биеэ шүтэлцсэн байх нь чухал билээ. Гадаад, дотоод нөхцөл байдлаас хүнсний аюулгүй байдал алдагдах, хил боомтын үйл ажиллагаа тасалдах зэрэг эрсдэл бий болоход Монгол Улс хүнсээ дотоодоосоо бүрэн хангах чадавхтай байх ёстой. Иймд Монгол хүн, Монгол айл өрх бүрийн үндэсний худалдан авалт хамгийн том дэмжлэг болох төдийгүй эх оронч үзлийг төлөвшүүлэх нь Монгол улсыг цогцлоох сэтгэлгээний суурь өөрчлөлт болж чадна.

2023 ОНД 19 ГОЛ НЭР ТӨРЛИЙН ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХЭМЖЭЭ

МАХ <small>Үйлдвэрлэл (тонн)</small> 550,000 	МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН <small>Үйлдвэрлэл (тонн)</small> 41,879 	СҮҮ <small>Үйлдвэрлэл (тонн)</small> 990,401 	СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН <small>Үйлдвэрлэл (тонн)</small> 91,626 
ТӨМС <small>Үйлдвэрлэл (тонн)</small> 174,743 	ЛУУВАН <small>Үйлдвэрлэл (тонн)</small> 53,068 	БАЙЦАА <small>Үйлдвэрлэл (тонн)</small> 41,037 	ШАР МАНЖИН <small>Үйлдвэрлэл (тонн)</small> 35,860 
СОНГИНО <small>Үйлдвэрлэл (тонн)</small> 28,182 	САРМИС <small>Үйлдвэрлэл (тонн)</small> 2,112 	ГУРИЛ <small>Үйлдвэрлэл (тонн)</small> 186,646 	ГУРИЛАН БҮТЭЭГДЭХҮҮН <small>Үйлдвэрлэл (тонн)</small> 75,232 
ХҮРЭН МАНЖИН <small>Үйлдвэрлэл (тонн)</small> 10,149 	ХҮЛЭМЖИЙН НОГОО <small>Үйлдвэрлэл (тонн)</small> 12,869 	ӨНДӨГ <small>Үйлдвэрлэл (тонн)</small> 13,218 	ЦӨЦГИЙН ТОС <small>Үйлдвэрлэл (тонн)</small> 370 
ДАВС <small>Үйлдвэрлэл (тонн)</small> 1,610 	ТАХИАНЫ МАХ <small>Үйлдвэрлэл (тонн)</small> 681 	УРГАМЛЫН ТОС <small>Үйлдвэрлэл (тонн)</small> 1,050 	ГАХАЙН МАХ <small>Үйлдвэрлэл (тонн)</small> 485 

Мэдээлэл бэлтгэсэн: Э.Сугарбаяр
/ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч/



“ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ”-ЫН ХҮРЭЭНД ҮР ДҮНГҮЙ АЖИЛЛАСАН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ХАРИУЦЛАГА ТООЦНО

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж буй төрийн байгууллагууд 6 сар тутамд нэг удаа хуралдаж, үндэсний хөдөлгөөний үр дүн, хэрэгжилтийн явцын талаар мэдээлэл, санал солилцдог. Өнөөдрийн байдлаар нийт хоёр удаа уулзалт зохион байгуулжээ.

“Хүнсний хувьсгал”-ыг хамтран хэрэгжүүлэх төрийн байгууллагуудын анхдугаар буюу 2023 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн уулзалтаар УИХ-ын 36 дугаар тогтоолыг эрчимжүүлэх, оролцогч талуудын төлөвлөлт, уялдаа холбоог хангах, санхүүжилтийн сахилга батыг сайжруулах талаар нээлттэй санал солилцсон бол 2023.06.27-ны өдрийн 2 дахь удаагийн зөвлөлдөх уулзалтаар,

УИХ-ын 36 дугаар тогтоолын эхний жилийн /2022.06.17-2023.06.17 хүртэлх/ хэрэгжилтийн явц, 36-р тогтоолыг эрчимжүүлэх зорилго бүхий 2023 оны Монгол Улсын Их Хурлын түр хорооны 02 дугаар тогтоол, Засгийн газрын 63 дугаар тогтоолын төлөвлөлт, хэрэгжилтийн явцын талаар холбогдох газрууд мэдээллээ танилцуулж, ярилцав.

Зөвлөлдөх уулзалтад УИХ-ын 36-р тогтоолыг хэрэгжүүлэгч 35 байгууллагын 50 гаруй холбогдох албан тушаалтнууд оролцсон.

Цаашид хөрөнгө оруулалтын зээлээр хэчнээн бүтээн байгуулалт хийгдэж, техник, технологи нэвтэрч, эргэлтийн хөрөнгийн зээлээр хэчнээн тоо, хэмжээний бүтээгдэхүүн шинээр болон нэмэлтээр үйлдвэрлэж, ажлын байр нэмэгдсэн эсэхийг бодитоор тайлагнаж, ажиллахыг холбогдох байгууллагуудад анхаарууллаа.

Мөн бид бүхний өмнө хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах зорилтот ажилтай зэрэгцэн яаралтай, оновчтой, тодорхой шийдвэр гаргах, эрсдэлийг давах зэрэг олон шалгуурт ажлууд гарч болзошгүй гэдгийг анхааран олон улсын хүнсний хангамж, уян хатан нийлүүлэлт, аюулгүй байдлын тогтолцооны бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаатай мөр зэрэгцэн ажиллах нь чухал байна гэлээ.

Хамтран хэрэгжүүлэх төрийн байгууллагуудын идэвх саарч, үр дүн багасах эрсдэлтэй гэж үзсэн тул Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллалаа.

Тодруулбал Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэхээр хоёр ажлын хэсэг байгуулав. Үүнд:

- Тогтоолын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ, дүгнэлт хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаярыг ажлын хэсгийн ахлагчаар томиллоо.
- Тогтоолын арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг хүрэх үр дүнтэй нь уялдуулан өөрчлөлт оруулах, тухайн жилийн хүрэх түвшинг тодорхой болгох ажлын хэсгийг байгуулж, ахлагчаар Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх Б.Даваадалайг томиллоо.

Уулзалтын үеэр хуралд оролцолгүй тасалсан, үр дүнгүй ажилласан, ахиц дэвшил гаргаагүй байгууллагын удирдлагад хариуцлага тооцох шийдвэр гарсан юм.





ОЮУНЫ БАЯЛАГ БҮТЭЭГЧИД “ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ”-ЫГ ЧИГЛҮҮЛНЭ



Улсын Их Хурлаас баталсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36-р тогтоол, тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх бодлого, тэргүүлэх чиглэл, түүний үр дүнтэй уялдуулан хэрэгжүүлэхэд дэмжлэх үзүүлэх чиг үүрэг бүхий Эрдэмтдийн зөвлөл байгуулагдлаа.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын эрдэмтдийн зөвлөлийн даргаар Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх, Доктор(PhD), профессор Ч.Даваабаяр томилогдов.



Өөрөөр хэлбэл төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр эрчтэй өрнөж буй энэхүү хөдөлгөөнийг зөв чиглүүлэх “луужин” хэрэгтэй бөгөөд энэ үүргийг гүйцэтгэхээр оюуны баялаг бүтээгчид хүч нэмж эхэлсэн юм.

“ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ” ТББ БАЙГУУЛАГДЛАА



“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд байгуулагдсан “Хүнсний хувьсгал” ТББ-ын үйл ажиллагааны үндсэн зорилтууд болох ХАА-н экспортыг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, импортыг бууруулахад УИХ, ЗГ, НЗДТГ хамтран ажиллана гэдгээ илэрхийлээд буй юм. Ингэснээр 2024 онд “Хүнсний хувьсгал” хөдөлгөөн улам эрчээ авах төлөвтэй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлж үр дүнд хүргэх, хүнсний салбар хоорондын болон хувийн хэвшил, төрийн байгууллагуудын түншлэл хамтын ажиллагааг хөгжүүлэх үндсэн зорилго бүхий “Хүнсний хувьсгал” төрийн бус байгууллага 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн албан ёсоор үйл ажиллагаа явуулж эхлэв.

Тус байгууллагын Гүйцэтгэх захирлаар М.Болод томилогдлоо. Тэрээр Хүнс, хөдөө аж ахуйн салбарт 20-иод жил тууштай ажиллаж буй залуу манлайлагч юм.



Тус холбоо нь УИХ-ын 36-р тогтоол, УИХ-ын түр хорооны 2-р тогтоол, Засгийн газрын 63-р тогтоолтой уялдуулан импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлд түлхүү ажиллахаар 2023-2024 оны ажлын төлөвлөгөөгөө хэлэлцэн баталсан юм.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын төрийн бус байгууллагууд тус тусдаа, өөрсдийн салбарын эрх ашгийн төлөө дуу хоолойгоо хүргэдэг байсан бол “Хүнсний хувьсгал” дор нэгдэн, нийт Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуйн салбарын эрх ашиг, хөгжлийн төлөө дуу хоолойгоо хүргэж, шийдвэр гаргагчидтай хамтран ажиллах боломж ийнхүү бүрдлээ.



Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг дэмжих үндэсний хороо байгуулж Ерөнхий сайд ахална

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын мэргэжлийн холбоодын нэгдэл “Хүнсний хувьсгал” ТББ-ыг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ хүлээн авч уулзлаа.

Уулзалтын үеэр “Хүнсний хувьсгал” ТББ-ын төлөөллүүд хүнс, хөдөө аж ахуйн салбарт тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар саналаа танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлэв.

“Хүнсний хувьсгал” ТББ-ын зүгээс хүнс, хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдлыг танилцуулж хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, импортыг бууруулахад анхаарч ажиллах шаардлагатай байгааг онцлов. Дэлхийн хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын стандартуудыг бүрэн нэвтрүүлснээр экспортын чиг баримжаатай шаардлагыг хангах, хүнс, хөдөө аж ахуйн салбарын

үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх, татварын хөшүүргийг бий болгох санал гаргав. Мөн хүнсний хувьсгалын хүрээнд сүү, малын мах, гахай, тахианы мах, өндөгний зэрэг томоохон төсөл хэрэгжүүлэх, тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх, шаардлагатай хууль эрх зүйн орчныг бий болгоход ойрын хугацаанд анхаарах хэрэгтэйг уламжлав.

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ дотоодын бараа бүтээгдэхүүнээ бодлогоор дэмжих, тухайлбал, тендерийн шалгаруулалтын зарчимд үе шаттай өөрчлөлт оруулах шаардлага байгааг хэлж, судалж ажиллахыг холбогдох албаныханд даалгалаа. Мөн хүнс, хөдөө аж ахуйн салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулах мэргэшсэн институт бий болгох шаардлага байгааг сануулж Засгийн газрын түвшинд Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг дэмжих Үндэсний хороо байгуулж Ерөнхий сайд ахалж ажиллахаа мэдэгдлээ.



УИХ-ын дарга Г.Занданшатар “Хүнсний хувьсгал” ТББ-ын УЗ-ийн гишүүдийг хүлээн авч уулзан, импортыг бууруулах, экспортыг нэмэгдүүлэх, мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх, татварын орчныг шинэчлэх арга замын талаар санал солилцов.



Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар “Хүнсний хувьсгал” ТББ-ын гишүүдтэй уулзан санал хүсэлтийг нь сонсож, хэлэлцүүлэг өрнүүллээ. Мөн тэрээр нийслэлийн 1,7 сая иргэдийн хүнсний аюулгүй байдлыг шийдэх ажлыг баялаг бүтээгчидтэй хамтран эрчимжүүлж, төр хувийн хэвшил хамтран ажилладаг сайн жишиг тогтооно гэдгийг онцлов.



ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ БА ШИМ ТЭЖЭЭЛИЙН АСУУДАЛ

Монголчууд бид тал, хээр, хангай хосолсон өргөн уужим нутаг орондоо 70 гаруй сая малтай идэх мах, гурилтай, өлсөөгүй, болоод л байна гэсэн өрөөсгөл ойлголт давамгайлдаг. Бэлчээрийн даац хэтэрсэн, доройтолд орсон, хөрсөө тордохгүй, нөхөн сэргээхгүй үржил шимгүй байдал нь ургамлын аймаг багасаж үүнтэй уялдан хүнсний асуудал улам л төвөгтэй болсоор байна.

Ийм цаг үед иргэдээ хэрхэн хүнсээр тогтвортой хангах, хүртээмж, шим тэжээлийн байдлыг хэрхэх тухай ярихгүй байх боломжгүй байна.

Ийм ч учраас Монгол Улсын Ерөнхийлөгч хүнснийхээ асуудлыг өөрсдөө хангахын тулд “ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ” зарласан явдал цаг үеэ олсон чухал шийдвэр байлаа. Хүнсний аюулгүй байдал (Food Security)-ын тухай иргэдэд цэгцтэй ойлголт өгөх нь нэн чухал юм.



Олон улсын байгууллагуудын судалгаагаар Монгол улсын ХАБ-ын үзүүлэлт

Олон улсын үнэлгээгээр хүнсний аюулгүй байдлын бие даасан байдлыг авч үзэхдээ

- 10-20% хангагдсан
- 25-30% эрсдэлтэй
- 40% алдагдсан гэж ангилдаг бөгөөд

Монгол улс 42.1% байгаа нь бие даасан байдлаа


хангаж чадахгүй байна гэсэн үзүүлэлт болж байна.

Энэ удаад хүнсний аюулгүй байдлын хамгийн чухал тулгуур үзүүлэлт нь хүнсний шим тэжээлийн асуудлын талаар хөндий.

Хүн эрүүл аж төрөхийн тулд хүнсээр авах шим тэжээл, олон нэр төрлийн хүнс авч хэрэглэж чаддаг байх явдал болно.

Дэлхийн хүнсний хөтөлбөрөөс гаргадаг интерактив зураглал бүхий судалгаанд 2023 оны 11 сарын 6-ны өдрийн Монгол Улсын Хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтээр хүнсний хэрэглээ нь хангалтгүй байгаа хүмүүсийн тоо 700 мянга байгаа нь нэг сарын өмнөх үзүүлэлтээс 0.01 мянган хүнээр нэмэгдсэн гэсэн статистик үзүүлэлт гарсан ба 5 хүртэлх насны хүүхдүүдээс цочмог хоол тэжээлийн дутагдалтай нь 0.9%, архаг хоол тэжээлийн дутагдалтай нь 9.4% эзэлж байгаа нь хүүхдийн хоол шим тэжээлийн асуудалд онцгой анхаарал хандуулахыг сануулж байгаа үзүүлэлт болж байна.

Мөн НҮБ-ийн ХХААБ, Дэлхийн хүнсний хөтөлбөр болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хамтарсан “Эрүүл хооллох боломжгүй байгаа хүмүүс”-ийн судалгаагаар 2020 оны хүнсний үнийг 2022 оны 8 сартай харьцуулахад 41% өссөн нь хямралыг улам даамжруулсан ба Орос 3.5%, Хятад 12%, Казакстан 1.2%, Япон 2.5%, Солонгос 1.7%, Финлянд 0.1%, Франц 0.1%, Монголын улсын хүн амын 51.4%, хүн эрүүл хооллож чадахгүй байгааг тогтоосон байна.




Хүнс тэжээлийн дутлын тархалт, %



Хүнс тэжээлийн дутлын тархалт олон улсын байгууллагуудын 2000 оноос хойш гурван жилийн дундажуудыг харьцуулан үзүүлсэн судалгаанаас дэлхийн болон, азийн бүсийн улсуудтай харьцуулахад харьцангуй сайн буурсан үзүүлэлттэй буюу 30.5- аас 8 болтол бараг 3.8 дахин буурсан нь хоол тэжээлийн дутлаас ангижирч байгаа мэт боловч насанд хүрсэн хүн ардын хүнсний хэрэглээний мэдлэг, ойлголт, тэдэнд чиглэсэн үйл ажиллагаа огт хийгдэхгүй байна.

НҮБ, ХХААБ-ын тооцоолсноор 2022 онд 5 хүртэлх насны монгол хүүхдийн өсөлт хоцрол дэлхийн аль ч улсад байгаагүйгээр буурсан нь хамгийн сайн буюу дэлхийн дундажаас даруй 3.6 дахин бага үзүүлэлт болсон байна гэж дүгнэгджээ.(Зураг 8) Энэ сайн үзүүлэлт боловч хүүхдүүдээ тэнцвэртэй хооллож сураагүй байгааг харуулж байна.



Тав хүртэлх насны хүүхдийн өсөлт, хоцролтын тархалт, %

Хүүхдийн шим тэжээлийн үзүүлэлт хангалтгүй байгаа нь эрүүл мэндийн шинжилгээ судалгааны дүнгээс тодорхой харагдана.(Зураг 9) Зургаас харахад илүүдэл жинтэй хүүхдийн хувь туранхай хүүхдээс 10 дахин их үзүүлэлттэй байгаа нь хүүхдийг тэнцвэртэй хооллож чадахгүй байгааг харуулж байна. Цус багадалттай хүүхэд нь 5 хүртэл насны 4 хүүхэд тутамын нэг нь, А ба D амин дэмийн дутал нь 5 хүртэл насны хүүхдийн 5 хүүхэд тутамын 3 нь байгаа нь хоол шим тэжээлийн нөхцөл байдалд хүүхдэд хамааралтай бүх л оролцогч талууд анхааралдаа авч засах арга хэмжээ авахгүй бол дархлаа сул, өвчинд өртөмтгий ирээдүй биднийг угтахаар байна.

Энэ нь бид хүн ардаа эрүүл хооллуулах бодлого, зохион байгуулалтгүй байгаа байдал, хүн ард нь эрүүл шим тэжээллэг хоол хүнс хэрэглэх мэдлэг, боловсрол хангалтгүй, тэнцвэртэй хооллох хангамж, хүртээмжийн ажил огт байхгүйтэй адил, шим тэжээллэг хоол хүнс хэрэглэх санхүүгийн боломж хүрэлцэхгүй байгаагаар судлаач хүний хувьд тайлбарлаж байна.



Монгол улсын эдийн засгийн тулах цэг бол мал аж ахуй юм

Хөдөө аж ахуйн салбарын 90 орчим хувийг бүрдүүлдэг уламжлалт мал аж ахуйн салбар тэр дундаа нүүдлийн болон эрчимжсэн мал аж ахуйг шинжлэх ухаанчаар зөв хослуулах, малын ашиг шимийг бүрэн гүйцэд ашиглах, малчдын орлого, амьжиргааг сайжруулах явдал нь “Хүнсний хувьсгал”-ын амин чухал нэгэн зорилт юм.

Тиймээс малчдын залгамж халааг бэлтгэх, малын эрүүл мэндийг хамгаалах, нэгдэж хоршиж ажиллах, малын үүлдэр угсааг сайжруулах, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээрийн менежментийг сайжруулах зэрэг олон асуудлуудад “Хүнсний хувьсгал” онцгой анхаарч байна.

Ирэх 2024 онд малын вакцинжуулалт, био-бэлдмэлийн үйлдвэрлэлд онцгой анхаарч, Монгол Улс малын өвчингүй эрүүл бүс болоход түлхүү анхаарна.

Цаашлаад цөлжилт, шороон шуурганы эрсдэлийг бууруулах, ногоон хөгжлийг дэмжих, хүнс, хөдөө аж ахуйн кластер, цогцолборуудыг байгуулах, түүхий эд бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын нэгдсэн тогтолцоо, тээвэр логистикийн оновчтой сүлжээг бий болгох, жижиг, дунд үйлдвэрүүдийг дэмжих, шинэ техник технологийг нэвтрүүлэхэд онцгой анхаарах болно.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨХ
Батсуурийн ДАВААДАЛАЙ**

“БАЯЛАГ БҮТЭЭГЧ” БИЗНЕС АЯЛАЛ



Монголчууд 19 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, цаашлаад экспортлогч улс болохын тулд үндэсний үйлдвэрлэгчдээ дэмжиж, тэдний чадавхжуулах ажил өрнөж байна. Үүний нэг нь “Баялаг бүтээгч- бизнес тур” аялал юм.

Энэхүү 7 удаагийн аяллын хүрээнд, 300 гаруй үйлдвэрлэгч, хүнсний чиглэлийн 14, хөнгөн үйлдвэрийн чиглэлийн 5, боловсруулах 1, агуулах, хөргөлтийн 1, нийт 21 дотоодын үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцлаа.

Бизнес аяллын үеэр дараах байгууллагын төлөөллүүд үйлдвэрлэгчдэд мэдээлэл өгч, хэлэлцүүлэг өрнүүллээ. Үүнд:

Төрийн байгууллага

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
- УИХ-ын Байгаль орчин хүнс хөдөө, аж ахуйн байнгын хороо
- УИХ-ын Үйлдвэржилтийн байнгын хороо
- Эдийн засаг, хөгжлийн яам
- Боловсрол, шинжлэх ухааны яам
- Жижиг, дунд үйлдвэрийн газар
- Гаалийн ерөнхий газар
- Татварын ерөнхий газар гэх мэт байгууллагууд төрөөс гарч буй бодлого, шийдвэр, эрх зүйн хүрээнд олгогдсон боломж, тулгамдаж буй асуудлыг шийдэх арга замын талаар мэдээлэл өгөв.



Олон улсын байгууллага

- НҮБ-ын Аж үйлдвэржилтийн байгууллага-ЮНИДО
- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
- Жайка олон улсын байгууллага
- КОПИА Монгол төв олон улсын байгууллага гэх мэт байгууллагууд хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийг танилцуулж, үйлдвэрлэгчидтэй хамтран ажиллах, үйлдвэрлэгчдийг дэмжих боломжийн талаар мэдээлэл өгөв.

Банк, санхүүгийн байгууллага

- Зээлийн батлан даалтын сан
- Хаан банк
- Голомт банк
- Төрийн банк
- БИД ББСБ зэрэг байгууллагуудын төлөөлөл бизнес аялалд нэгдэж, “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд олгож буй бага хүүтэй, урт хугацаатай зээл олголт, зээлд хэрхэн хамрагдах болон анхаарах ёстой асуудлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, хэлэлцүүлэг өрнүүлэв.



2023.04.29. "НВЦ" группийн "Баян" өндөгний үйлдвэр

"Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үнэн шударга холбоо"-ны Тэргүүн Г.Үнэнбаяр:



"Баялаг бүтээгч- бизнес тур" аялалд хамрагдсандаа маш сэтгэл хангалуун байна. Монгол Улсад үйлдвэрлэгчдээ дэмжсэн төрийн бодлого хэрэгжиж, тэр нь үр дүнгээ өгч байгаа нь бусад нийгмийн асуудлуудад ч эерэг нөлөө үзүүллээ. Миний хувьд өмнө нь ийм гоё аялалд огт явж үзээгүй. Анх удаа л үндэсний үйлдвэрүүдийн үйл ажиллагааг дэргэдээс нь харж, мэдлэг туршлагаас нь сонслоо. Энэ хүмүүсээр үнэхээр их бахархаж байна. Мөн хэд хэдэн үйлдвэрлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангахаар боллоо. Энэ тал дээр зөвлөгөө, мэдээлэл ч өгөөд, өнөөдрийг ганзага дүүрэн өнгөрүүлж байна. Энэхүү "Хүнсний хувьсгал" бусад төрийн бодлого шийдвэрүүдээс их өөр байна. Илүү хөрсөн дээрээ буусан, үйлдвэрлэгчидтэйгээ тулж ажиллаж байна гэдгийн нэг жишээ нь "Баялаг бүтээгч- бизнес тур" аялал байлаа.

"Мөөжиг органик" ХХК-ийн Ерөнхий захирал С.Мөнхжаргал:



Миний хувьд энэ аялалд үйлдвэрлэлээ хөгжүүлэх боломж хайх, шинэ санаа олох зорилгоор оролцож байна. Энэ зорилгоо ч биелүүлж байна. Үйлдвэр эрхлэхэд түүхий эдийн чанар маш чухал. Ялангуяа бүтээгдэхүүнээ экспортод гаргахыг хүсэж



2023.06.10. "Монконди" ХХК-ийн чихрийн үйлдвэр



2023.04.15. "Еден" ХХК



2023.02.02. "Гофро" ХХК-ийн цаасан хайрцагны үйлдвэр

байгаа л бол үүнд ач холбогдол өгч, анхаарах ёстой байдаг. Манай мөөг олон бүтээгдэхүүний, ялангуяа гоо сайхны болон эмийн үйлдвэрүүдэд чухал түүхий эд болно. Тиймээс дотоодын үйлдвэрүүдтэйгээ хамтарч ажиллах нөөц бололцоо их байгаа гэдгийг олж харлаа. Мөн бусад үйлдвэрлэгчдээ хараад маш их урам зориг авч, хойшлуулж байсан ажлаа яаралтай хийе гэж шийдлээ. Юунаас айгаад, яагаад хойшлуулаад байгаа юм бэ гэж энэ аяллын үеэр өөрөөсөө асууж явлаа. "Хүнсний хувьсгал" хэрэгжсэн нь өөр олон үйлдвэрлэгчдэд зориг өгсөн гэж найдаж байна.



"ОББТМ" ХХК-ийн Ерөнхий захирал Т.Болормаа:

Сүүлийн жил надад болон манай үйлдвэрт олон сайхан үйл явдал тохиолдсон. Энэ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Хүнсний хувьсгал"



2023.01.13. Альпин үүлдрийн ямааны ферм



2023.06.10. "Монголиан грийн фармер" ХХК



2023.03.09. "Гэгээ фүүдс" ХХК давсны үйлдвэр

өрнөсөнтэй нягт холбоотой. Үйл ажиллагаагаа зогсоох гэж байсан манай үйлдвэрийг олон хүнд таниулж, бусад төрийн байгууллага, аж хуйн нэгжүүдтэй холбож өгсөнд маш их талархаж явдаг. Уг нь манайх хүүхдийн ширээ сандал үйлдвэрлэдэг. Гэвч "Хүнсний хувьсгал"-ын цар хүрээ өргөн байгаа нь бусад салбарын үйлдвэрлэгчдэд ч өгөөжөө өгч буйн нэг тод жишээ нь бид юм. Үүнээс гадна "Баялаг бүтээгч-бизнес тур" аялалд оролцсон нь миний нүдийг нээж өгсөн. Өмнө нь манайх зөвхөн хүүхдийн ширээ сандал л үйлдвэрлэнэ гээд ойлгочихсон байж. Гэтэл өөр төрлийн бүтээгдэхүүн хийж болох юм байна, яг одоо хэрэгжүүлье гэж бодож эхэлсэн. Эхний ээлжинд аялалд хамт явсан "Чиглэл" ХХК-ийн захирал, шинэхэн Аж үйлдвэрийн гавьяат ажилтан Ц.Бумцэнд ахаас зөвлөгөө авч гал тогооны ширээ сандал хийж байгаа. Удахгүй олон шинэ бүтээгдэхүүнээр хэрэглэгчидтэйгээ уулзах болно.

"Төгс ургац" ХХК-ийн Ерөнхий менежер П.Пунцагцэрэн:



Монгол Улсын Ерөнхийлөгч "Хүнсний хувьсгал"-ыг эхлүүлээд анх очсон газруудын нэг нь манай "Төгс ургац" компани байсан. Тухайн үед энэ ч үр дүнгүй ажил байх гэж бодоод итгээгүй. Гэтэл ганцхан жилийн дотор бидний хэлсэн, ярьсан асуудал болгоныг

шийдэх төрийн бодлоготой болж, улс даяар тархаж чадсан том ажил болсныг хараад их гайхаж, баярлаж байна. Манай компанийн хувьд энэ аялалд төрийн байгууллагын төлөөллүүдээс цаг үеийн болон

хөнгөлөлттэй зээл тусламжийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахаар ирсэн. Энгийн үед уулзахын тулд цаг авч хүлээсний эцэст, хагас дутуу ойлгогддог байсан албаны хүмүүс энэ аялалд оролцож байгаа нь үйлдвэрлэгчдийн маш том асуудлыг хөнгөвчилж өгч байна.

"Арвин Хишиг Эмиралд" ХХК-ийн Ерөнхий захирал Б.Адъяадорж:



Миний хувьд хүнс, хөдөө аж ахуйн салбарт орж ирж байгаа шинэхэн үйлдвэрлэгчдийн нэг. Тийм ч учраас "Баялаг бүтээгч-бизнес тур" маш том боломж, аз завшаан болж байна. Ахмад туршлагатай үйлдвэрлэгчдээс зөвлөгөө авч, хамтран ажиллана гэдэг хүссэн бүхэнд тохиох зүйл биш. Миний яг одоо туулж буй бэрхшээл бүрийг энэ хүмүүс аль хэдийн даван туулаад, амжилт гаргасан байгаа нь би ч гэсэн шантарч болохгүй юм байна гэдэг бодол төрүүллээ. Ерөнхийлөгчийн санаачилсан "Хүнсний хувьсгал" над шиг олон шинэ үйлдвэрлэгчдийг төрүүлж, энэ салбарыг хүчирхэг болгох юм байна гэж бодож байна.

"Промон Трейд" ХХК-ийн Ерөнхий захирал Н.Оюунбат:



Адилхан зовлон жаргал туулж буй үндэсний үйлдвэрлэгчдэдээ үйлдвэрээ танилцуулж, хийж байгаа ажлаа дүгнүүлэх сайхан байна. 70 гаруй сая малтай манай улсад дайвар бүтээгдэхүүн, ясаа боловсруулахгүй газарт булна гэдэг сүйрэл юм. Тиймээс бид байгальд хог болж хаягддаг малын яс, дайварыг шилдэг технологиор боловсруулж, дэлхийд эрэлттэй бүтээгдэхүүн болгодог. Энэ бүхнийгээ үйлдвэрлэгчидтэйгээ хуваалцаж нэг өдрийг сэтгэл дүүрэн өнгөрүүллээ. Ер нь үйлдвэрлэгчдэд хийж байгаа зүйлээ ойлгуулна, бусадтайгаа хамтарч ажиллана гэдэг маш чухал. Энэ чухал ажлыг зохион байгуулсан хүмүүст талархаж байна.




ХҮНИЙ НАСАН ТУРШИЙН ЗӨВ ХООЛЛОЛТ БАГА НАСНААС ЭХТЭЙ

Дэлхийн олон улс оронд хүүхдийн өдөр тутмын хоол, шим тэжээлийн байдлыг зөв хэрэгжүүлэх нь нийгмийн эрүүл мэндийн түвшинг дээшлүүлэх чухал арга зам, эрүүл зөв бие хүн төлөвшүүлэх буюу эх орны ирээдүй болсон хүүхэд залуу үеийн бие бялдрын болон оюун санааны хөгжлийг хангах, нийгмийн асуудлыг шийдэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ хэмээн үздэг.

Үүнийг сургууль, цэцэрлэгийн хоолны үйлчилгээгээр дамжуулан хэрэгжүүлэх нь өндөр үр ашигтай байдаг. Өөрөөр хэлбэл, хүүхдийн хоолны үйлчилгээ нь ирээдүй рүү чиглэсэн үнэлж баршгүй хөрөнгө оруулалт учраас дэлхийн улс орнууд анхаарлын төвдөө хөгжүүлсээр иржээ. Одоо ч урьд өмнөхөөс илүү анхаарал хандуулж байна. Түүнчлэн бага наснаас нь хоол шим тэжээлийн боловсрол олгодог.

Хүний насан туршийн дадал зуршил бага наснаас үүдэлтэй бөгөөд эдгээрт хооллох зуршил, хандлага,



амтанд дурлах байдал хамаарах боломжтой. Хэдий чинээ бага наснаас зөв хооллох ойлголт өгч, дадал зуршлийг бий болгоно төдий чинээ ирээдүйд эрүүл иргэн бий болгох үндэс болно. Үүнд гэр бүлийн болон цэцэрлэг, сургуулийн хоолны ач холбогдол оршиж байгаа юм.

Тухайлбал хүний хөгжилд аль болох бага наснаас оруулсан хөрөнгө оруулалт ирээдүйд үнэ цэн бүхий эргэх ашиг оруулдаг гэдгийг Нобелийн шагналт эдийн засагч Жим Хэкман баталсан.

Эх сурвалж: <https://heckmanequation.org/resource/the-heckman-curve/>

Тэгвэл зөв хооллолтыг дараах байдлаар ойлгож болно. Үүнд:

- Өдөр бүрийн хооллолт чухал. Өглөөний цай, өдрийн хоолыг зохих цагт нь, оройн хоолыг оройтуулахгүй байвал нэн сайн. Өдрийн үндсэн 3 хоолыг хэрэглэснээр



бие махбодын бодисын солилцоо хэвийн явагдах нэгэн нөхцөл хангагдана гэсэн үг.

- Өдөр бүр 3-4 бүлэг хүнс хэрэглэх. Нийт хүнсийг мах, сүү, үр тариа, хүнсний ногоо, жимс гэж бүлэглэдэг. Аль бүлгийг сонгох нь таны сонголт хэдий ч өдөр бүр бүлэг бүрээс хэрэглэх нь шимт бодисын дутал, илүүдэл үүсэхгүй байхын үндэс гэсэн үг. Тухайлбал сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэхгүй байснаар кальцийн дутлаас ангид байх боломж хомсдох бол хүнсний ногооны хэрэглээ бага байх



нь аминдэм, биологийн идэвхтэй бодисын хангалтгүй хэрэглээнд хүргэнэ. Харин тараг уух нь өнөөдөр дэлхий даяар хүчтэй яригдаж байгаа ашигтай бактерийн эх үүсвэр болно. Ямар нэг шимт бодисын илүүдэл, дутал бие махбодод олон жилийн дараа эрүүл мэндийн өөрчлөлт, улмаар эмгэгт хүргэнэ.

“БАЯЛАГ БҮТЭЭГЧ- ӨГЛӨӨНИЙ ЦАЙ” УУЛЗАЛТ



Баялаг бүтээгчид ажил хэрэгч өглөөний цай уулзалт хийлээ. Энэ удаагийн уулзалтад үндэсний үйлдвэрлэгч, баялаг бүтээгчдийн 50 гаруй төлөөлөл оролцсон бол урилгаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаяр, Зээлийн батлан даалтын сангийн Бизнес хөгжлийн газрын дарга Э.Тамир нар оролцов. Баялаг бүтээгчдийн ажил хэрэгч өглөөний цай уулзалт нь чөлөөтэй ярилцах, цагийг үр дүнтэй өнгөрүүлэх боломжоор оролцогчдыг хангаж чадсан бөгөөд энэ үеэр олон шинэ бизнесийн хамтрагчид бий болсноороо онцлог байв.



Үндэсний үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчдийн ажил хэрэгч өглөөний цай хоёр дахь арга хэмжээг “Хүнс, Технологийн Политехник Коллеж”-д амжилттай зохион байгууллаа. Энэхүү уулзалтад 70 орчим үйлдвэрлэгч оролцов. Мөн Монгол Улсын Эдийн засгийн бодлогын зөвлөх Б.Даваадалай, Монгол банкны мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа нар урилгаар оролцож, үйлдвэрлэгчдийг мэдээллээр хангасан юм.



ҮЙЛДВЭРЛЭГЧДЭЭ МЭДЛЭГ, МЭДЭЭЛЛЭЭР ЦЭНЭГЛЭХ НЬ “ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ”-ЫН ТОМ ЗОРИЛТ БАЙЛАА

Хувийн хэвшил төрийн худалдан авалтын тендерт ороход татвар, нийгмийн даатгал, хууль эрхзүйн зөрчилгүй байх зэрэг шалгууруудад эхний ээлжинд анхаарах хэрэгтэй.

“ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТАТВАРЫН ОРЧИН” УУЛЗАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



Үндэсний үйлдвэрлэгч, баялаг бүтээгч нарт салбарын татварын бодлого, орчин, нөхцлийн талаар танилцуулах, санал солилцох уулзалт 2023.03.21-нд Гаалийн Ерөнхий газрын Хурлын танхимд боллоо.

Тус арга хэмжээ нь хүнс, хөдөө аж ахуйн салбарын баялаг бүтээгч, үйлдвэрлэгч нарт салбарын татварын орчин, нөхцлийн талаар танилцуулах, санал солилцох зорилготой юм.

- Уулзалтаар:
- Аж ахуйн нэгжийн албан татвар, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилт,
 - Нэмэгдсэн өртөгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт,
 - Гаалийн татвар тарифийн орчин зэрэг сэдвээр санал солилцлоо.

Эрх зүйн орчны талаар зөв мэдээлэлтэй байх нь тухайн бизнес эрхлэгчид тэр хэмжээний том хөрөнгө оруулалт болдог

АРИЛЖААНЫ БАНКУУДЫН ТӨЛӨӨЛҮҮДТЭЙ САНАЛ СОЛИЛЦОХ УУЛЗАЛТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, ХХААХҮЯ, Монголбанк, арилжааны банкуудын уулзалт /2023.04.25/ Монгол банкны төв байранд боллоо. Уулзалтаар Монголбанкны тэргүүн дэд Ерөнхийлөгч Г.Дөлгөөн “Хүнсний хувьсгал”-ын

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн “Хүнсний хувьсгал” болон эрчимтэй өргөжиж буй цаг үед үндэсний үйлдвэрлэгчид төрийн байгууллагуудаас явуулж буй үйл ажиллагаа, шийдвэр, цаг үеийн мэдээллийг шуурхай хүлээн авч, төр засагтайгаа уялдаа холбоотой ажиллах нь чухал. Иймд Ерөнхийлөгчийн Тамгын газар “Хүнсний хувьсгал” хөдөлгөөний бодлого арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудаас үйлдвэрлэгчид рүү чиглэсэн сургалт олгох, уулзалт хэлэлцүүлгийг үе шаттай зохион байгуулав.



хүрээнд олгож буй бага хүүтэй, урт хугацаатай зээл олголтын ажлыг эрчимжүүлэх чиглэлийг арилжааны банкуудад өглөө.

“ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ- ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ




Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хамтран “Хүнсний хангамж, аюулгүй байдал-хууль, эрх зүйн шинэчлэлт” сэдэвт хэлэлцүүлгийг Төрийн ордонд /2023.03.28/ зохион байгуулав.

Хэлэлцүүлэгт яам, агентлаг, төрийн, төрийн бус байгууллагын холбогдох албан тушаалтан, эрдэмтэн судлаачид, баялаг бүтээгчид, малчид тариаланчдын төлөөлөл зэрэг нийт 70 гаруй хүн оролцсон юм.

Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг орчныг боловсронгуй болгох чиглэлээр Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх, Зохицуулах үйлчлэлтэй хүнсний тухай хууль, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан. Энэ хүрээнд Байнгын хороо идэвх санаачлагатай, манлайлан ажиллаж буйг дурдлаа.

“ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГААР ДЭМЖИХ НЬ” СУРГАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



“Үндэсний үйлдвэрлэлийг төрийн худалдан авах ажиллагаагаар дэмжих” сургалт, хэлэлцүүлэг боллоо.

Хэлэлцүүлгийн үеэр:

- Худалдан авах ажиллагааны эрх зүйн орчны талаарх мэдээлэл
- Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, анхаарах асуудал мэдээлэл
- Ерөнхий гэрээ, цахим дэлгүүрийн танилцуулга, мэдээлэл сэдвээр танилцууллаа.

Төрийн худалдан авах ажиллагааны газар (ТХААГ)-аас мэдээлж буйгаар, төрийн худалдан авалтад өнгөрсөн онд 10.1 их наяд төгрөгийн тендер зарлажээ. Үүний санхүүжүүлэх дүн нь 3 орчим их наяд төгрөг гарч байв. ЕБС-ийн сурагчдын “Үдийн цай” хөтөлбөрт гэхэд өнгөрсөн жил давхардсан тоогоор 66 тэрбум төгрөгийн тендер зарлаж, хамгийн багадаа жилд 1 тэрбум төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн худалдан авчээ.

Тус сургалт-хэлэлцүүлгээр төрийн байгууллагуудад бараа бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбоотой дотоодын үйлдвэрүүдэд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх, нөгөө талаас үйлдвэрлэл эрхлэгчид / захиалагч, нийлүүлэгч/ худалдан авах ажиллагаанд оролцоход анхаарах ёстой асуудлын талаар мэдээлэл өгч, хоёр тал хоорондоо уялдаа холбоотой ажиллах боломж бүрдэв.

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ТАЛААР ТАНИЛЦУУЛАХ, САНАЛ СОЛИЛЦОХ УУЛЗАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



Энэхүү уулзалт хэлэлцүүлэг нь “Хүнсний хувьсгал”-ыг эрчимжүүлэх хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн салбарын баялаг бүтээгч, үйлдвэрлэгч нарт гаалийн байгууллагын үйл ажиллагаа, холбогдох хууль, тогтоомжийн талаар танилцуулах, санал солилцох зорилготой юм.

Хэлэлцүүлгээр гаалийн тариф, татвар, хөнгөлөлт

чөлөөлөлт болон ХХАА-н салбарын Импортын бараанд баримталж буй бодлогын талаар мэдээлэл өглөө.

ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧИДТЭЙ САНАЛ СОЛИЛЦОХ УУЛЗАЛТ



Монгол Улсын ЕТГ, УИХ, ЗГ болон бусад төрийн байгууллагуудын удирдлагууд 30 орчим үндэсний үйлдвэрлэгчдийг хүлээн авч уулзан, санал хүсэлтийг нь сонсож, хүнс, хөдөө аж ахуйн салбарын тулгамдаж буй асуудал, бодлого шийдвэрүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөв.

“ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ” БА ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР ЭРХЛЭГЧИД

Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд хөнгөлөлттэй санхүүжилтэд хэрхэн хамрагдах боломжуудыг үйлдвэр эрхлэгчдэд танилцуулах сургалт, мэдээлэл өгөх арга хэмжээ болов. Арга хэмжээ 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр 08:30 цагт Блю Скай тауэрын 3 давхарт зохион байгуулав.



ГАЗАР ТАРИАЛАН, МАЛ АЖ АХУЙН САЛБАРТ ОЛГОХ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ӨГЛӨӨ

Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн хүрээнд газар тариалан, мал аж ахуйн салбарт олгох эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлийн талаар” сургалт-хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголбанк, Монголын банкны холбоо, мал аж ахуй, газар тариалангийн салбарын аж ахуй нэгж байгууллага, иргэд оролцов.





ШИНЭ ЗЕЛАНД ЛУГАА ХӨГЖЬЕ

Манай улс 70 сая малтай. Гэтэл өнөөгийн сүргийн бүтцээр бэлчээрийн даац маань 30 сая малд ноогдоно. Эхний ээлжинд бэлчээрийнхээ даацаас давсан малаа яаж ийгээд борлуулах, экспортод гаргах хэрэгтэй. Үлдсэн 30 сая малынхаа үүлдэр угсааг сайжруулж, ашиг шимийг нэмэгдүүлж, зөв менежментээр удирдана. Хэдхэн жилийн дараа Монголд малчин шиг баян хүн байхгүй болно.

Жалганд булсан хөрөнгө



2021 оны хавар улсын хэмжээнд гурван сая толгой мал хорогдсон. Тухайн үеийн зах зээлийн /Эмээлт, Хүчит шонхор зах/ ханшаар бодоход 882 тэрбум буюу нэг их наяд шахуу төгрөгийг жалганд булсан байна гэдэг тооцоог хийж байлаа. 2023 оны эхний зургаан сард 3,6 саятай байсан малын хорогдол есдүгээр сар дуусахад 3,9 саяд хүрчээ. Үүнийг мөнгөн дүнгээр тооцвол 1,1 их наяд болжээ. Бид 70 сая малтай үүнийг төгрөгөөр тооцвол хэдэн их наяд болох нь тодорхой юм.

Бидний мэдэж байгаа зүйл гэвэл малчдын амьдрал доройтохын хэрээр хот руу чиглэсэн нүүдэл ихэсдэг. Өнгөрсөн онд 20 мянган өрх шилжиж ирсэн гэж албаны хүмүүс мэдээлж байв. Ах дүү, хамаатан садныхаа хашаанд гэр барьж бууснаар яндангийн тоог нэмж утаа ихэсэн. Залуучууд нь, хуучин машин лизингээр аваад таксинд явна, түгжрэл нэмнэ. Бүсгүй хүүхдүүд нь ямар ч хамаагүй хувийн сургууль төгсөөд ажлын байргүй, цалин орлого байхгүй цаашлаад Япон, Солонгос гэх мэт орнуудад хууль бус хар бор ажил хийхээр виз мэдүүлж хүлээнэ. Ядуурал ийнхүү нэмэгдсээр... Тэгэхээр малчдын асуудал, хотын бидний ч асуудал болж хувирчээ. Тиймээс зөнд нь хаях боломжгүй.

1990 онд нийгэм солигдсоноос хойш огт шийдэлгүй яваа хэд хэдэн асуудал манайд бий. Эхнийх нь ядуурал. Сүүлийн арваад жил ядуурал 30 хувиас буусангүй. Албан бус судалгаагаар 2023 онд ядуурлын түвшин бараг 40-50 хувьд хүрч байгаа талаар мэргэжилтнүүд ярьж байна.

Хоёр дахь нь хүнсний асуудал. Хэдийгээр бид өөрсдийгөө “эко хүнстэй” гэж ярьдаг боловч хүнсний хангамж, чанарын асуудалд өнөө хүртэл анхаарал хандуулсангүй.

Гурав дахь нь бэлчээр. Хамгийн сүүлд 2018 онд Швейцарийн хөгжлийн агентлагаас манай бэлчээрийн даацыг судлаад “Нийт бэлчээрийн 13 хувь эргэж

сэргэхгүйгээр цөлжсөн, 70-аас илүү хувь нь гүн цөлжилттэй буюу ургамал нь тачир, сийрэг, нэр төрөл нь цөөрсөн байна” гэж тайландаа бичжээ. Өөрөөр хэлбэл, бэлчээрийн даац дөрөв дахин хэтэрчээ. Үүнээс хойш судалгаа хийсэнгүй. Харин малын тоо толгой бол нэмэгдсээр. Цөлжилтийг бий болгож байгаа хүчин нь жилээс жилд нэмэгдэж байхад бэлчээр дордсон уу гэхээс дээрдээгүй нь ойлгомжтой.

Малчид бол үйлдвэрлэгч.

Үйлдвэр ашигтай ажиллах ёстой

Гэхдээ боломж хэзээд байдаг. Малчид мал аж ахуйгаа удирдах аргаа өөрчилж ашигтай ажиллах, төр засаг нь үүнд тохирсон төрийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Харамсалтай нь өнгөрсөн 30 жилд төрийн бодлого буруу чиглэлд явжээ.

Хоёрдугаарт, бидний сэтгэлгээнд учир дутагдал бий.

Өнөөдөр улсын хэмжээнд 70 сая мал бүхий эргэлтийн хөрөнгөтэй 248 мянган малчин өрх байна. Үүний 48 мянга нь мал бүхий иргэд. Өөрөөр хэлбэл, ах дүү, хамаатан садан дээрээ малаа тоолж орхиод суурин газар бараадсан гэсэн үг. Үлдсэн 200 мянган өрх нь малаа маллаж байна. Товчхондоо хөдөлмөрийн насны дөрвөн хүн тутмын нэг нь мал аж ахуй дээр ажиллаж байна. Гэтэл энэ “нэг хүн” маань Монгол Улсын нийт баялгийн 10 хувийг л үйлдвэрлэдэг. Үлдсэн 90 хувийг нь уул уурхайн орлогоос олдог гэхэд болно.

Шинэ Зеландын жишээ авъя. Яг манайхтай адилхан 32 сая хоньтой, 9,9 сая үхэртэй, таван сая (2023 оны тоо) хүнтэй. Газар нутгийнхаа хэмжээгээр манайхаас дөрөв дахин бага. Энэ улс нь хонины мах, сүүн бүтээгдэхүүний экспортоор дэлхийд нэгдүгээрт, хонины ноосны экспортоор эхний тавд ордог. Үндсэндээ орлогын нэлээд хэсгийг МАА-с олдог гэсэн үг. ДНБ нь 261 тэрбум ам доллар, нэг хүн ноогдох ДНБ нь 50800 ам доллар. Тэгэхэд манай улсын ДНБ 15,3 тэрбум ам доллар, нэг хүнд ноогдох ДНБ нь энэ жил 5100 ам долларт хүрсэн гэж мэдээлж байна. Өөрөөр хэлбэл, тэднээс арав, хорь дахин ядуу...

Манай малчид мах, сүү, ноос ноолуур гэх мэт бүтээгдэхүүнүүдийг жил болгон үйлдвэрлэж амьжиргаагаа залгуулдаг.





Тэдний үйлдвэрлэлийн байр нь - хашаа хороо, эргэлтийн хөрөнгө нь - мал, газар нь – бэлчээр, хүний нөөц нь – өрхийн гишүүд гээд үйлдвэрлэл эрхлэхэд байх ёстой бүх зүйл байгаа. Гэхдээ алдагдалтай болохоос ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэл хэвийн ажиллаж байгаа юм. Монголын 200 мянган малчин өрхийг үйлдвэрлэгч, бизнес эрхлэгч гэдэг утгаар нь харах ёстой. Үйлдвэрлэл учраас зардлаа багасгах, ашигтай ажиллах ёстой. Үүний тулд зөв менежмент чухал. Хөгжсөн улс орнуудын түүхийг харахад дандаа үйлдвэрлэлээ дагаж хөгжсөн байдаг. Угтаа мал аж ахуй ч гэсэн үйлдвэрлэл. Малчин өрх болгон үйлдвэрлэгч. Энэ 200 мянган өрхийг үйлдвэрлэгч гэж харвал манайд ч бас Шинэ Зеланд лугаа хөгжих, баяжих боломж бий.

Энэ талаар 2016 оноос хойш туршилт, судалгаа хийж, 2019 оноос “ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН” хөтөлбөрийг санаачлаад, ажил хэрэг болгож явлаа. 1000 хүрэхгүй малаас жилдээ 480 сая төгрөгийн ашиг олох боломж бидэнд бий. Сүргийн бүтцээ зөв тодорхойлж, зөв менежмент хийж чадвал 500 толгой хонины мах 90 сая төгрөг, 300 толгой ямааны арьс, ноолуур, мах 50 сая, 50 толгой адууны мах 50 сая, 150 толгой үхрийн махнаас 240 сая төгрөг олох боломж байна. Гадаад руу гаргаж байгаа экспортын үнээр биш, Дэнжийн мянга, Эмээлт дээр зарж байгаа ханшаар тооцоход ийм байна.

“ХОНЬ ДЭД ХӨТӨЛБӨР”-ийн хүрээнд Говьсүмбэр аймгийг загвар болгон хэрэгжүүлж, сэтгэлгээ хандлагыг өөрчлөхөд асар их боломж байгааг харуулсан “МАЛЧНЫ ХОТНООС ДЭЛХИЙН ТЭРБУМТАНУУД” баримт кино, хэд хэдэн тайлбар тодруулга нэвтрүүлэг, гарын авлага олон нийтийн хүртээл болгоод дөрвөн жил өнгөрчээ. Товчхондоо 500 хоньтой эх сүрэг байгуулж, илүү нугаламтай барга, үзэмчин хуцаар хээлтүүлнэ. Гарсан төлөө махны гарцыг нэмэгдүүлэх хэд хэдэн арга хэрэглэхэд, намар 6-7 сартай хурганы гулууз 20-25 кг жин татдаг. Гэтэл одооны баруун аймгуудын төлөгний гулууз 15-18кг байна. Хавар нь жаахан шимт тэжээл идсэн хурга намар дорхноо томроод ирдэг. Гэтэл гурваас дөрвөн жил “махаа зулгааж” малласан, нас гүйцсэн эр хонийг 150-200 мянгаар л зах зээлд борлуулдаг шүү дээ. Энэ хооронд малчин хүн хэчнээн их хүч хөлс хүч, эрүүл мэнд, цаг хугацаагаа зарцуулдаг билээ. Жилд 480 сая байг, 200 саяар тооцоход 248 мянган малчин өрх маань жилдээ 49 их наяд 800 тэрбум төгрөгийг бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Өнөөгийн бидний олж байгаа бүх орлого буюу ДНБ 15,3 тб ам долларыг 200 мянган малчин өрх олох боломж бий. Юун уул уурхай...

Судалгаагаар манай бэлчээрийн даац ердөө 30 сая малд тохирно. Тиймээс эхний ээлжид бэлчээрийнхээ даацаас давсан малаа борлуулж экспортод гаргая. Үлдсэн 30 сая малынхаа үүлдэр угсааг сайжруулж, сүргийн бүтцээ оновчтой болгож, ашиг шимийг нэмэгдүүлээд зөв менежментээр удирдана. Хэдэн жил зарцуулан байж мянган малаас авдаг ашиг шимээ 500 малаас жил болгон авдаг болчихвол хүч хөдөлмөр, цаг хугацаа, хөрөнгө

санхүүг хэмнэн хэд дахин ашиг олох нь ойлгомжтой.

Аажимдаа Монголд малчид шиг баян хүн байхгүй болж зах зээл бизнесийн зарчмаар хэн илүү хөдөлмөрлөж оновчтой менежмент явуулсан нь Европ, Австрали, Шинэ Зеландын фермерүүд шиг нисдэг тэрэг хөлөглөж хаа дуртай газраа аялж явдаг баян малчин бизнесменүүд жин дарна. Өнөөгийн малчид ихэнх нь орлого багатай учир өргөн хэрэглээний бараанаас хэтрэхгүй хязгаарлагдмал хэрэглээтэй. Эд нар хангалттай орлоготой болоод ирэхээр хэрэглээ нь ч нэмэгдэнэ.

Нийслэл, аймаг, сумдын үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны эргэлт нэмэгдэж, орлого сайжирна. Эдийн засаг, зах зээл ингэж эргэдэг. Нэг салбарт бий болсон өсөлт нөгөө салбараа чирдэг. Жишээ нь: Дээр дурдсанчлан 200 мянган малчин өрх 50 их наяд төгрөгийн орлого олоход, үүний 20-30% нь тэжээлд зарцуулагдана. Үүнийг дагаад газар тариалангийн салбар ч эргэлтэд орж сэргэнэ.

Зуун жилийн хоцрогдол

Харамсалтай нь бид мал аж ахуй ярихаараа өнгөрсөн 100, 200, жилийн өмнөх уламжлалт сэтгэлгээнээсээ гарч чаддаггүй. Зуун жилийн өмнө бидэнд хөргөгч байсангүй. Бүгдээрээ л адилхан малаа маллаж амь зуудаг байсан учраас мах сүү гэх мэт бүтээгдэхүүнээ бие биедээ арилжаалах, ашиг олох тухай ойлголт байсангүй. Өрхийнхөө хэрэгцээг хангаад жилийн дөрвөн улиралд амьдаар нь нөөцөлж ирсэн тухайн цаг үед тохирсон менежментийн арга өнөө хүртэл өөрчлөгдөөгүй.

Социализмын үед мал нийгмийн өмч байлаа. Малчин хүн малаа өсгөх л үүрэгтэй, үр шимийг нь хүртэх эрх байсангүй. Эхнэр нь төрөөд шөлний хонь гаргахын тулд сум нэгдлийн даргаар цоцуулдаг байсан шүү дээ. Тэр үед Монгол Улс 25 сая малтай болох зорилт тавиад чадаагүй. Мал хувьчилснаар 70 сая малтай болсон, 90 сая хүргэж үзсэн удаатай. Тэгсэн хэрнээ эзэд нь ядуу хэвээрээ. Гэхдээ бид малын тоо толгойны хойноос хөөцөлдөх зорилт тавьсан хэвээрээ л байна.

Ядахдаа бид өмнөх нийгмийн үеийн тоо толгойны хойноос хөөцөлдсөн зорилтоо өөрчлөх юмсан. Жил болгон улсын сайн малчин, аймгийн, сумын сайн малчин, “мянгат малчин” шалгаруулж ирлээ. Урамшууллын систем нь дандаа тоо толгойны хойноос хөөцөлдөөд явчихсан. Улсаараа тийм нэг солиорлын байдалд орчихлоо л доо. УИХ, Засгийн газрын гишүүд нь Цагаан сараар албатай юм шиг айлын хойморт гарч суугаад, өөрсдөө өсгөж өгсөн юм шиг даналзаж байгаад баахан шагнал гардуулж, тэмдэг зүүж өгөөд явдаг. Хоёр сарын дараа мал нь үхээд эхлэхээр нэг нэг боодол өвс тэвэрч очоод хамт уйлж байгаад буцдаг эмгэнэлт жүжиг л тоглож байна. Жүжгийн гол дүрд хэн сайн тоглосон нь эрх мэдэлд хүрдэг, эргээд дараа жилийн хавар нөгөө жүжгээ давтдаг.

Сүүлийн жилүүдэд мянгат малчдын тоо тасралтгүй өсөж байгаа. Жишээ нь: 2020 онд 10200 байсан бол 2022 онд 12150 болсон. Малын тоо толгой өсөхийн хэрээр бэлчээр нь талхлагдаад, шимт чанар нь алга болоод, мал нь бэлчээрээсээ шим тэжээл авч чадахгүй мөн хөгширсөн учраас дархлаа нь сулраад өвчин тусна, дээр нь цус ойтчихсон ярьж чадахгүй болохоос эх, хургагүй л гуйвж дайваад явж байна. Яаж ийгээд онд оруулж, намар нь гайгүй борлуулахын тулд эм тариа, вакцинаар бордох хэрэгтэй болдог. Хоёр, гурван жил ингээд явчихсан малын өөх холестерин ихтэй (хур өөх гэж ярьдаг), махны чанар муу. Монголын мал, мах экспортод гарч чаддаггүй шалтгаан энэ.

Төрийн бодлого зөв, малчид нь аж ахуйгаа удирдах менежментээ өөрчилж нэг зүгт харахгүйгээр бэлчээр нутаг нь цөлжсөн, 70 сая мал нь жалганд үлдсэн хог болно.



ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН

Манайхаас цөөн хонь, цөөхөн үхэртэй, тав дахин жижиг газар нутагтай Шинэ Зеланд улс 2020 онд 9.2 тэрбум долларын (USD) махыг (400,000 тонн хонины, 471.718 тонн үхрийн) 111 оронд экспортолжээ. Ковидын үеэр байгалийн, сайн чанартай малын махны хэрэгцээ нэмэгдсэн учир махны экспорт нь өмнөх жилээс 7 хувиар өсөж, түүхэн дээд амжилт тогтоожээ.

Тэгвэл Монгол Улсын нийт экспорт 2020 онд 7.7 тэрбум доллар болсны 80 хувь нь нүүрс, зэс, алт, төмрийн хүдэр зэрэг уул уурхайн түүхий эд байна. Манай экспортын зөвхөн 92.6 сая долларыг 38.8 мянган тонн махаа худалдаж олжээ. Шинэ Зеланд 1 кг махаа дунджаар 10.5 доллароор, Монгол 2.4 доллароор зарсан байна.

	Газар нутаг км ²	Хүн ам (мянга, 2020 он)	Хүн амын нягтрал	Хонь (сая толгой)	Үхэр (сая толгой)	Махны экспорт 2020 (сая\$)
Монгол	1,564,116	3,327	2.1	30.0	4.7	92.6
Шинэ Зеланд	268,680	5,112	18.1	26.0	3.7	9,200

Монголын мах нь ийм хямд, мал аж ахуйн салбарын бүтээмж ийм дорой буйн шалтгаан нь малаа маллах, эрүүл байлгах, тэжээх, бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх, борлуулах, тээвэрлэх явц тус бүрийн өгөөжтэй холбоотой. Ийм том газар нутгаар тархсан, ганц малчин төвтэй мал аж ахуйн үйлдвэрлэлийн эргэлт өсөх чадамжгүй гэдгийг 30-аад жилийн дараа бид харж байна. Ганц нэгээрээ биш, зөвхөн хоршиж л аж ахуй өсөж хөгжих цар, чадамж бүрдэнэ гэдэг зарчмыг өдийг хүртэл бид ажил хэрэг болгож чадсангүй. Малчдыг хоршин ажиллуулах гэж төр засаг түмэн удаа оролдсон ч үр дүн нь үнэхээр чамлалттай. Учир юунд байгаа, түүнийг яаж шийдвэл зохистой вэ?

Хоршиж чадаагүй хоршоод

Монголд анхны хоршоо 100 жилийн өмнө, 1921 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр Богд хааны

зарлигаар “Ардын харилцан туслалцах хоршоо” нэртэй байгуулагджээ. Хөрөнгө, хөдөлмөр, хүслээрээ нэгдсэн энэ хөдөлгөөн олон хүнийг ажилтай болгож, нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд тухайн үедээ ихээхэн хувь нэмэр оруулжээ.

1958 оны гуравдугаар сард МАХН-ын 13 дугаар их хурал хуралдаж, нэгдэлжих хөдөлгөөнийг өрнүүлэв. 1959 онд иргэдийн амины малыг хураан авч нийгэмчлэн, дундын өмч болгон бүртгэж, 389 нэгдэл байгуулагдан малыг жигд хуваарилан хариуцуулав. “Нийгмийн өмчийг бий болгож, малчин ардууд нэг нь нөгөөгөө мөлжих явдлыг устгасан” гэж тухайн үеийн эрх баригчид онцолж байжээ.

1990 оны ардчилсан хувьсгалын дараа нэгдлийн бүх малыг малчдад нь хувьчлав. 30 жилийн дараа малын тоо 2.5 дахин өсөж, 66 саяд хүрэв. Үүний дотор хонин сүрэг 2 дахин, ямаа 5.3 дахин өсчээ. 2020 онд Монгол Улсад 4468 хоршоо бүртгэлтэй, нийт 234,633 гишүүнтэй, хувь нийлүүлсэн 49.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй, тэдний 3670 нь орон нутагт, 798 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг гэжээ (ҮСХ-ны мэдээ). Тэдний гуравны нэг нь бөөний болон жижиглэнгийн худалдаа, 30 хувь нь хөдөө аж ахуйн салбарт мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр ажилладаг гэх. Гэхдээ дийлэнх хоршоод нь үйл ажиллагаа явуулдаггүй, цаасан дээр л бүртгэлтэй аж. Монголчууд, малчид хоршиж чадсангүй. Хөдөө аж ахуйн салбарын хөдөлмөрийн бүтээмж бага, эдийн засгийн эргэлтэд сулхан оролцоотой, малчны хөдөлмөрийн үр шим бага, залуус нь хот суурин газар бараадсаар, хөдөөд хөгшчүүл нь үлдсээр байна. Монголчуудын хамгийн гол хүнс болох махны хувьд л гэхэд 90 хувь нь үйлдвэрийн бус аргаар, эрүүл ахуйн эргэлзээтэй замаар, олон гар дамжин иргэдэд хүрч байна.

Шинэ хоршоо, шинэ хөдөө

Малчид бодитоор хорших, хөдөлмөрийн бүтээмжээ нэмэх боломж түүхэндээ анх удаа, 2021 оны тавдугаар сарын 6-ны өдрөөс нээгдлээ. Энэ өдөр УИХ-аар батлагдсан “Хоршооны тухай хуулиар” хоршоод бусдаас хөрөнгө оруулалт татах, өмч хөрөнгө эзэмших, захиран зарцуулах, зээл авах, ашиг

хуваарилах зэрэг харилцааг зохицуулав. Хоршоо хуулиар хориглоогүй бүх үйл ажиллагааг эрхэлж болно.

Өмнө нь хөрөнгийг гишүүдийнхээ нэр дээр хуваан бичилт хийж ирсэн тул хоршоонд өөрт нь хөрөнгөгүй байв. Тэгвэл шинэ хуулиар хоршооны хөрөнгө нь тодорхой болж, хөрөнгөө барьцаалан зээл авах юм. Мөн болзошгүй эрсдэлээс хамгаалах санг байгуулдаг болно. Хуулийн дагуу авах арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолоор (40 дүгээр) Сум хөгжүүлэх санг Хоршооны хөгжлийг дэмжих сан болгох, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хоршоонд жил бүр санхүүжилт олгох, хоршооны шинэчилсэн бүртгэлийг зохион байгуулах, 2022 оныг “Хоршооны хөгжлийг дэмжих жил” болгож, хоршооллын хөдөлгөөнийг эрчимжүүлэх, дэлгэрүүлэх, загвар хоршоодыг байгуулах, сайн туршлагыг нэвтрүүлэх ажлыг Засгийн газарт даалгажээ.



Хоршоо нь мөн гишүүдийнхээ барааг дотоодын үйлдвэрлэгчдэд зуучлан борлуулсан орлогоосоо НӨАТ төлөхгүй болов. Тэгснээр хоршоод түүхий эд, бараагаа зууч дамжлагагүй биржээр арилжаалж гадаад, дотоодын хэрэглэгчдэд нийлүүлэх нөхцөл бүрдэх юм. Хоршооноор малын гаралтай түүхий эдийг төвлөрүүлж, анхан шатны тордолт хийх, тээвэрлэх, борлуулах, мал нядлах, хадгалах, сүү цуглуулах, боловсруулах, биржээр борлуулах, гишүүдийн хэрэгцээт бараа бүтээгдэхүүнээ илүү өгөөжтэй нийлүүлэх боломж бүрдэнэ. Малчид тариаланчид арьс, шир, ноос, ноолуур, сүү гэх мэт түүхий эдийн урамшууллаа хоршоогоороо дамжуулан авна.

Хоршооны дундын сан байгуулж, гишүүдэд бага хүүтэй хэрэгцээний зээл олгох, өвс тэжээл бэлтгэх, худалдан авах, мал эмнэлэг, үржлийн үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах боломж бүрдэнэ. Газар тариалан эрхлэгчдийн хувьд үр бордоо худалдан авах, техникийн үйлчилгээ үзүүлэх, гишүүдийн төмс, хүнсний ногооны хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтыг зохион байгуулах үйл ажиллагааны өгөөж эрс өснө. Хоршоод гишүүдийн эдийн засаг, нийгмийн хэрэгцээг хангах, цайны газар, зочид буудал, ахуйн үйлчилгээг хангах, оёдол, эсгий эдлэл, талх нарийн боов зэрэг жижиг цехийн үйлчилгээ эрхлэх, зөгий, гахай зэрэг туслах аж ахуй, хүнсний ногоо боловсруулахад хүчтэй хувь нэмэр болно.

Малчид тариаланчид хамтран хоршоо байгуулах, хоршоонд гишүүнээр элссэнээр дээрх үйл ажиллагааг эрхэлж, үйлчилгээ үзүүлэх боломжтойгоос гадна одоо үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодын



нийгмийн үнэлэмж дээшилж, хоршоодыг дэмжигч байгууллагуудын уялдаа холбоо сайжирч, хоршоодын залгамж халаа бэлтгэгдэх, ажилгүйдэл буурч, малчид тариаланчид сум, орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах юм.

Нэг баг - нэг хоршоо

Дээрх үйл ажиллагааг хоршоод их багаар эрхэлж ирсэн ч, гол сууриа олж чадаагүй. Тэр суурь нь бол газар, бэлчээр юм. Бэлчээр нутгаа хоршин ашиглаж л өндөр өгөөжтэй мал аж ахуй бий болно. Тэгж ажиллах боломжтой, хамгийн жижиг нэгж бол баг. Баг бүр өөрийн газар нутагтай. Сум бүр тав зургаан багтай. Одоо багаараа хорших, хоршоо бүр эрэгтэй, эмэгтэй ахлагчтай болох хэрэгтэй. Эмэгтэй ахлагч нь бүх эмэгтэйчүүдээ төлөөлж багийн ажилд оролцох тул нийгмийн хөгжилд ихээхэн ач тус болдгийг Солонгосын “шинэ тосгон хөдөлгөөн (Самауел Ундон)” харуулж чадсан.

Хүсэл зориг, хүч хөдөлмөр, өмч хөрөнгөөрөө хоршсон баг л хамгийн өгөөжтэй ажиллаж чадна. Багаараа хэлэлцэж бэлчээрээ яаж зөв ашиглах, аль хэсгийг нь амраах, хаана хадлангаа авах, малын хөлийн татвараа яаж зарцуулахыг зөвхөн хоршоо л шийдэх болно. Тухайн жил хаана худаг гаргах, хэний өвөлжөөнд шинэчлэлт хийх зэргээ төлөвлөж, дундын сангаасаа санхүүжүүлэх юм. Багаараа нэгдсэн хоршоо нь орлого ашгаа нэмэгдүүлэн, орон нутгаа өөрчлөн хөгжүүлнэ. Сумын засаг захиргаа нь хоршоодоо (багуудаа) өрсөлдүүлэн дүгнэж, хоршоо хөгжүүлэх сангаасаа шаардлагатай биет зүйлээр нь урамшуулж болох юм. НҮБ-ын санаачилгаар “Олон улсын хоршооллын өдөр”-ийг жил бүр тэмдэглэдэг бөгөөд 2021 оны уриа нь “Хамтдаа илүү сайныг дахин бүтээе” ажээ. Монголын малчид хоршин илүү сайныг бүтээх цаг ирлээ.





2023 ОНД МОНГОЛ УЛС ХҮНСНИЙ НОГОО ХУРААЛТААРАА ТҮҮХЭН ДЭЭД АМЖИЛТАА ТОГТООЛОО



Тариаланчид, үндэсний шилдэг хүнсний үйлдвэрлэгчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд олсон ололт, амжилтаа дүгнэн, цаашдын зорилгоо хэлэлцэж, шилдгүүдээ тодруулах “Ургацын баяр-2023” ёслол “Корпорэйт конвеншн центр”-т боллоо.

Баярын хуралд Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх оролцон хүнс үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчдэд талархал илэрхийлж амжилт хүсэн ерөөв.

Тэр бээр “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд төр, хувийн хэвшил хамтран ажилласнаар хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дотоодын хангамж, экспорт нэмэгдэж байгааг тэмдэглэв.

Олсон ололтоо улам бататгаж, цаашид уур амьсгалын өөрчлөлт, хөрсний доройтол, үрийн чанар, хүнсний үйлдвэрлэлийн түүхий эдийн чанар, стандарт зэрэгт онцгой анхаарах шаардлагатайг хэллээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, дэмжлэгийн дүнд энэ жил хүнсний ногооны 85 хувийг дотоодоос хангах боломж бүрджээ.

Ингэснээр Монгол Улс хүнсний ногоо хураалтаараа түүхэн дээд амжилтаа тогтоожээ.

Он гарсаар хүнсний салбарт олон улсын шаардлагад нийцсэн мал төхөөрөх болон мах боловсруулах, бяслаг үйлдвэрлэх 11 үйлдвэр шинээр ашиглалтад орсон байна. Махны экспортоос 277 сая ам.долларын орлого олж, хүнсний бүтээгдэхүүний импорт 12 хувиар буурчээ.

Энэ нь нэг тэрбум гаруй ам.доллаар гадаадаас хүнсний бүтээгдэхүүн худалдаж авдаг манай улс энэ жил 120 сая орчим ам.долларыг эх орондоо үлдээх боломж бүрдүүлсэн гэсэн үг юм.

“Ургацын баяр-2023” ёслолын хүрээнд “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дотоодын хэрэгцээг хангахад үнэтэй хувь нэмэр оруулсан “Хүнс, хөдөө аж ахуйн салбарын шилдэг үйлдвэрлэгчид”-ийг алдаршууллаа.

Шилдэг 35 үйлдвэрлэгчдэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит цом, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын нэрэмжит өргөмжлөлийг гардуулсан юм.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН НИЙСЛЭЛИЙН ШИЛДЭГ ҮЙЛДВЭРЛЭГЧИД

1. Траст трейд ХХК Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэгч
2. Очир дагинас ХХК Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэгч
3. Талх чихэр ХК Круассан брэнд үйлдвэрлэгч
4. Үлэмж органик ХХК Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэгч
5. Сүү ХК Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэгч
6. Витафит ХК Монгол лууван бүтээгдэхүүн үйлдвэрлэгч
7. Грийн индастри ХХК Гоймонгийн үйлдвэрлэл эрхлэгч
8. Төгс ургац ХХК Хүлэмжийн аж ахуй эрхлэгч
9. Их булгийн тохой ХХК Ногооны аж ахуй эрхлэгч
10. Майнд тэч ХХК Ургамлын тос үйлдвэрлэл эрхлэгч
11. Баялаг тахиа ХХК Тахианы аж ахуй эрхлэгч
12. Гэгээ фүүдс ХХК Амьд эрдэс давс үйлдвэрлэл эрхлэгч



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ОРОН НУТГИЙН ШИЛДЭГ ҮЙЛДВЭРЛЭГЧИД

1. Архангай Багараашант ХХК Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгч
2. Баян-Өлгий Азат ХХК Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч
3. Баянхонгор Шалса рожа ХХК Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэгч
4. Булган Гурванборхууд ХХК Газар тариалан, хүнсний үйлдвэрлэл эрхлэгч
5. Говь-Алтай Энхтаян ХХК Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгч
6. Говь-Сүмбэр Оорцог элгэн хоршоо Газар тариалан, хүнсний үйлдвэрлэл эрхлэгч
7. Дархан-Уул Дархан халдун ХХК Хүнсний үйлдвэрлэл эрхлэгч
8. Дорноговь Далд мөнгөн шанд ХХК Цай үйлдвэрлэл эрхлэгч
9. Дорнод Найнги хүнс ХХК Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэгч
10. Дундговь Говийн гэгээ ХХК Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгч

11. Завхан Завхан баялаг ХК Хүнсний үйлдвэрлэл эрхлэгч
12. Орхон Эрдэнэт мах маркет ХХК Мах боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч
13. Өвөрхангай Итгэлт хүнс трейд ХХК Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч
14. Өмнөговь Ганган тайж ХХК Гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэгч
15. Увс Увс хүнс ХК Хүнсний үйлдвэрлэл эрхлэгч
16. Сүхбаатар Дарьт шүтээн ХХК Мах боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч
17. Сэлэнгэ Өгөөж мандал уул ХХК Газар тариалан эрхлэгч
18. Монгол бяслагны үйлдвэр Хонин нуга брэнд үйлдвэрлэгч
19. Төв Цээлийн хур ХХК Газар тариалан эрхлэгч
20. Жаврай үр ХХК Газар тариалан эрхлэгч
21. Ховд Хан алтайн инээмсэглэл ЗБН Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэгч
22. Хөвсгөл Аяны жолоо ХХК Хүнсний үйлдвэрлэл эрхлэгч
23. Хэнтий Метагро ХХК Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгч



Хүнс, хөдөө аж ахуйн салбарын шинэхэн төрийн шагналтнуудыг өлгийдөн авлаа.



ДЭЛХИЙН ХЯМРАЛТ ЦАГ ҮЕ БА ЭРСДЭЛИЙГ СӨРӨХ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН САНААЧИЛГА

Дэлхий нийтийн өмнө тулгараад буй хүнсний хомсдол, өлсгөлөн, хүнсний хямралыг эрчимжүүлж буй хамгийн том хүчин зүйлс нь геополиткийн асуудлууд болон сүүлийн 10-аад жил олон улсын анхаарлын төвд байгаа уур амьсгалын өөрчлөлт юм. НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага /FAO-Food and Agriculture Organization/, Олон улсын валютын сан зэрэг байгууллага 2023 онд хүн төрөлхтөний өмнө тулгамдаж буй асуудлуудаар улс хоорондын дайн, уур амьсгалын өөрчлөлт, хүн амын өсөлт, эдийн засгийн шок зэргийг нэрлэжээ.

Дэлхий нийтийн өмнө тулгамдаж буй дээрх асуудлууд нь хэтдээ дараагийн том сорилт хүнсний хомсдол, “хүнсний хямрал”-д хүргэх юм.

2022 оны сүүлээр дэлхийн нийт хүн ам 8 тэрбум хүрч байхад дэлхийн эдийн засаг тус онд 3.2% хүртэл унаж, энэ онд бүүр 2.7% болох төлөвтэй байна. Дэлхийн инфляц 2022 онд 8.8% хүрсэн ба энэ онд 6.5%, 2024 онд 4.1% болно гэх таамаглал гарсан. Уур амьсгалын тухайд далайн дундаж температур 2021 онд түүхэн дээд хэмжээндээ хүрэв. 2021, 2022 онд дэлхийн дундаж температур +1.5-аас +20С хэм хүрч дэлхий нийтээрээ ган гачиг үзсэн халуун жилүүд үргэлжиллээ.



Дэлхийн Хүнсний Хөтөлбөрт /WFP-World Food Program/ дэлхийн хүнсний даац 8 тэрбум хүртэлх хүнийг тэжээх чадвартай, 8 тэрбум давсан тохиолдолд олон улсын хэмжээнд өлсгөлөн, шим тэжээлийн дутагдал, хүнсний хомсдол үүсэх эрсдэлтэй гэж үздэг. Гэтэл НҮБ-ын хүн ам зүйн судалгаагаар 2030 он гэхэд дэлхийн хүн ам 9 тэрбум, 2050 он гэхэд 11.5 тэрбум хүрнэ гэсэн тооцоо бий. Эндээс үзэхэд дэлхийн хүнсний хямрал 2030 онд ноцтой асуудал болж 2050 онд сүйрлийн хэмжээнд хүрэх түгшүүр харагдаж буй.


Түүнчлэн дэлхийн эдийн засаг хямралтай байгаагийн

сацуу зарим улс орны төрөл бүрийн бордоо, үр, тариалангийн бусад бодис, урвалжуудыг худалдан авах эрэлт, үнийн өсөлт нь ургацад шууд нөлөөлж байна. ОХУ Украины дайн дэлхийн үр тариа, биологийн болон химийн бордоо, наранцэцгийн үр, тос, мал амьтны тэжээлийн нийлүүлэлтэд хүчтэй нөлөөлж дэлхийн зах зээл дээр огцом үнийн өсөлт үүсгэж байгаа нь ядуу, буурай, хөгжиж буй орнуудад хүнд тусаж байна.

Дэлхийн Хүнсний Хөтөлбөрөөс дэлхий дээр 4 хүн тутмын нэг нь өлсгөлөн, 5 хүн тутмын нэг нь шим тэжээлийн дутагдалтай гэх өвөрмөц дүгнэлт гаргасан нь хүнсний асуудал хүн төрөлхтний өмнө хэдийн тулгараад буйг харууллаа.

2022 оноос олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө тулгараад буй дараагийн сорилт нь хүнсний хангамж, хүртээмж, чанарын асуудал бөгөөд 2023 оноос бүүр хурцадсан гэж үзсэн. Учир нь ОХУ, Украины дайны улмаас дэлхийн хүнс, эрчим хүч, бордооны нийлүүлэлт тасалдаж, хүнсний хямралыг өдөөгч гол хүчин зүйл болсоор байна.

ОХУ, Украин хоёр улс дэлхийн хөдөө аж ахуйн түүхий эдийн хамгийн чухал үйлдвэрлэгч орнууд юм. Хямралаас өмнө хоёр улс дэлхийн улаан буудайн экспортын 30, эрдэнэ шишийн 20 хувийг нийлүүлдэг байсан. Тэд мөн наранцэцгийн үрийн бүтээгдэхүүний дэлхийн экспортын 80 орчим хувийг бүрдүүлдэг. ОХУ азот, кали, фосфорын бордооны экспортоор дэлхийд тэргүүлдэг. 2020 оны сүүлчээс эрчим хүчний үнэ нэмэгдсэн, мөн цар тахлын улмаас тээврийн зардал нэмэгдэж дээрх бүтээгдэхүүний үнэ өсч байна. ОХУ, Украины дайны улмаас хөдөө аж ахуйн экспорт тасалдаж буй нь дэлхийн хүнс, бордооны зах зээлд эрэлт нийлүүлэлт доголдон үнэ өсөж байна.



УУР
АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТ
БА ХҮНСНИЙ
ХЯМРАЛ

Дэлхийн хүнсний хямралд эдийн засгийн хүчин зүйлээс гадна уур амьсгал, хүрээлэн буй орчин сүүлийн жилүүдэд ихээр нөлөөлөх болсон. 2000 он гарснаар олон улсын



байгууллагууд уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал ихээр нэмэгдэж буй талаар олон судалгаа хийсэн. Хүрээлэн буй орчны өөрчлөлт нь дан халалт, цөлжилт зэргээр хязгаарлагдаагүй бөгөөд үүнээс үүдэн гарсан хүнсний хямралын томоохон хүчин зүйл болж байна.

2021 оны 4-9 дүгээр сард ган гачгийн нөлөөгөөр Мадагаскар тэргүүтэй Африкийн 8 оронд цаг агаарын эрс тэс байдлаас үүдэн тариалангийн талбай сүйрэлд өртөж, 14000 орчим хүн хүнсний томоохон асуудалтай тулгарсан. Хүнсний хямралд хүчтэй өртөөд буй 53 улсын 39-д нь цаг агаарын эрс тэс уур амьсгал нь хүнсний аюулгүй байдлын анхдагч, хоёрдогч, гуравдагч хүчин зүйл болж буй.

Цаг агаарын цочрол нэмэгдэж байгаа нь хүнсний аюулгүй байдлыг улам дордуулж, 2022 онд Зүүн, Төв болон Өмнөд Африк, Евразид цаг агаарын онцгой сөрөг нөлөө үзүүлсэн. Хэдийгээр 2020-2021 онд Африкийн зарим бүс нутагт цаг агаарын эрс тэс уур амьсгалтай орнуудын тоо 15-аас 8 болж буурсан ч өөр бүс нутгуудад эсрэгээрээ уур амьсгалын тогтворгүй байдал 50 хувиар өссөн байна.

Өмнөд болон Төв Африкт Мадагаскарын Гранд Суд болон баруун өмнөд Анголд сүүлийн 40 жилд байгаагүй ган гачиг тохиож, газар тариалангийн үйлдвэрлэл таван жилийн дунджаас 50-80 хувиар доогуур байна. Малавигийн өмнөд хэсэг, Мозамбикийн хойд хэсэг, Намиби, Танзани улсад мөн орон нутгийн хуурайшилт өндөр гарчээ. Зарим улирал халуун орны шуурга, аадар бороо, үерийн улмаас Мозамбик, Эсватини, Малави зэрэг улсад газар тариалангийн талбайг сүйтгэжээ.

Зүүн Африкт Этиоп, зүүн Кени, өмнөд Сомали, Уганда зэрэг орнууд дунд болон хүнд ган гачигтай тулгарсан нь хүнсний үйлдвэрлэлийг хязгаарлаж, үнийг өсгөж, хөдөө аж ахуйн хөдөлмөр, газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлээс олох орлогыг бууруулсан.

Латин Америк болон Карибын тэнгисийн орнуудад 2020 оны сүүлээр болсон Эта, Иота хар салхины улмаас учирсан хохирол нь Гватемал, Гондурас, Никарагуад 2022 онд хүнсний нөөцийг тарамдуулсан. Гаитид хур тунадас тогтворгүй орсны улмаас дунджаас доогуур ургац авсан байна. 8 дугаар сарын дундуур Гаитигийн халуун орны шуурга газар тариалан, үйлдвэрлэлийн дэд бүтцийг сүйрүүлсэн. Евразид цаг агаарын цочрол дор хаяж таван оронд томоохон нөлөө үзүүлсэн.

Афганистанд сүүлийн дөрвөн жилд хоёр дахь удаагаа ган гачиг болж, нийт нутгийн 80 хувьд ган болж, ургац багассан. Ган гачиг, усалгааны усны хүрэлцээ муудсан нь Сири улсад их хэмжээний ургац алдахад хүргэсэн. Пакистанд Белужистан, Синд мужид ган гачиг, Хайбер Пахтунхвад бороо хур хангалтгүй байгаа нь газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийг бууруулж, хүнсний үнэ өсөхөд нөлөөлсөн. Бангладешийн Кокс-Базар дахь дүрвэгсдийн хуаранд хөрсний элэгдэл, хөрсний гулгалт, үер, салхи, шуурганы улмаас борооны

улирлын үеэр хүнсний агуулахууд бүхэлдээ сүйдсэн.

Дээрх Африк, Латин Америк, Евразийн орнуудад уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн гарсан үер, ус, хөрсний хэт халалт, уур амьсгалын огцом өөрчлөлт зэрэг нь хүнсний аюулгүй байдал, хүнсний хомсдол зэргийг өдөөгч томоохон хүчин зүйл байв. Эдгээр орон ихэвчлэн далайд гарцгүй хөгжиж буй орнууд байна.



Манай орны хувьд хүнсний хямрал, хүнсний хомсдолд өртөх эрсдэл одоогоор байхгүй. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд Хүнсний аюулгүй байдал гэх хэсэгт эрүүл аюулгүй хүнсний бүтээгдэхүүн хэрэглэх, шаардлагатай нөөцтэй байх, мал аж ахуйн эрүүл ахуйг хангах, хамгаалах талаар дурдсан байдаг. Манай улс БНХАУ-аас гадаад худалдааны 60 гаруй хувийн хамааралтай. Хил, гааль хаалтай байсан нь манай орны хөдөө аж ахуй, газар тариалангийн түүхий эд, багаж, тоног төхөөрөмжийн импортод сөргөөр нөлөөлсөн. Үйлдвэр эрхлэгчид бараа, түүхий эдээ татан авах боломж хомсдож, борлуулагчид барааны хомсдолд орсон, газар тариалан эрхлэгчид бордооны нийлүүлэлт тасарсан, БНХАУ-аар дамжин ирдэг гуравдагч орнуудтай хийж байсан худалдаа тасарч эхэлсэн.

Манай орны эдийн засгийн өсөлт бага, инфляц өндөр хүчин зүйлээс гадна уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг байдал хэтдээ ХАА-д хүнд тусгахаар байна.

2016 оноос Монгол Улсын газар нутгийн нийт цөлжилтийн хэмжээ 66%-аас 77% болтол нэмэгдсэн. 2011 онд л гэхэд улсын хэмжээнд хийгдсэн усны тооллогын дүнгээр 6646 гол горхи тоологдсоны 551 нь, 3613 нуур тоологдсоны 483 нь 2020 оны байдлаар ширгэсэн байжээ. Мөн БОАЖЯ уур амьсгалын өөрчлөлтийн талаар хийсэн судалгаанд дэлхийн дундаж температур 0.7 хэмээр нэмэгдэхэд Монгол 2 хэмээр нэмэгддэг талаар бичсэн байна. Дэлхийн дундаж температур 2050 оноос 1.5-2 хэмээр нэмэгдэхэд Монгол 4 хэмээр нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Ингэснээр манай улс зундаа +40-50 хэм хүртэл халах аюул тулгарч байна. Энэ тохиолдолд газар тариалан зогсож, бэлчээр талхлагдснаар мал аж ахуйгаа хүртэл бүхлээр нь алдах аюул тулгарч байна. Өнөөдөр Африкийн улс орнуудад тулгараад буй хүнсний хямрал манай оронд ч яваандаа тулгарах аюул ажиглагдаж байна.

Эх сурвалж: Аюулгүй байдал судлалын хүрээлэн



Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагаас

“ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ”- ЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ЧИГ ХАНДЛАГА

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДЫН БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ЧИГ ХАНДЛАГА

“Дэлхийн хүнсний аюулгүй байдал ба хоол тэжээлийн нөхцөл байдал” The State of Food Security and Nutrition in the World (SOFI): НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (FAO), Хөдөө аж ахуйн хөгжлийн олон улсын сан (IFAD), Хүүхдийн сан (UNICEF), Дэлхийн хүнсний хөтөлбөр (WFP) Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (WHO)-аас хамтран жил бүр “Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөр”-ийн хүрээнд өлсгөлөнг зогсоох, хүнсний аюулгүй байдлыг хангах, хоол тэжээлийг сайжруулахад чиглэсэн ахиц дэвшлийн талаар мэдээлэх, зорилтыг хэрэгжүүлэхэд тулгарч буй гол сорилтуудын талаар нухацтай дүн шинжилгээ хийх зорилгоор “Дэлхийн хүнсний аюулгүй байдал ба хоол тэжээлийн нөхцөл байдал” (The State of Food Security and Nutrition in the World (SOFI)) тайланг гаргадаг.

2023 оны тайланд дурдсанаар дэлхий нийтийн хэмжээнд 2019 онд 612 сая, 2020 онд 701 сая, 2021 онд 738 сая хүн хоол тэжээлийн дутагдал, өлсгөлөнд нэрвэгдсэн байна. Улмаар 2022 онд нийт өлсгөлөнд нэрвэгдсэн хүний тоо 783 сая хүрсэн нь “Тогтвортой хөгжил”-ийн чухал хэсэг болох хүнсний аюулгүй байдал, өлсгөлөн, хоол тэжээлийн дутагдлыг бууруулах тухай зорилтод хүрэхэд томоохон сорилт болж байгааг онцолжээ.

Хүн амын нягтралын хэв маяг өөрчлөгдөж байгаа нь хөдөө аж ахуйн хүнсний тогтолцоог бүхэлд нь өөрчлөхөд хүргэж, боломжит үнэтэй эрүүл хүнсээр иргэдийг хангахад хүндрэл учруулж байна. 2050 он гэхэд ойролцоогоор арван хүн тутмын долоо

нь хот суурин газарт суурьших төлөвтэй байгаа талаарх судалгааны дүнг мөн танилцуулжээ. Энэхүү судалгаанд Монгол орны хувьд 2030 он гэхэд нийт хүн амын 70,6 хувь, 2050 он гэхэд 77,7 хувь нь хот газарт суурьших төлөвтэй байгаа тухай урьдчилсан тооцоо гаргасан байна. Хотжилт, эдийн засгийн өсөлтийн болон бүтцийн өөрчлөлтийн хоорондын уялдаа холбоо сул байгаагаас хот суурин газарт хүн амын нягтрал хурдацтай явагдаж иржээ.

Түүнчлэн “Дэлхийн хүнсний аюулгүй байдал ба хоол тэжээлийн нөхцөл байдал” The State of Food Security and Nutrition in the World (SOFI) 2022 оны тайланд хөдөө аж ахуйн системийг өөрчилж, эрүүл, тэжээллэг хоол хүнсийг боломжийн үнээр үйлдвэрлэх арга замын талаар асуудлыг дэлгэрэнгүй судалсан байна.

Харин 2023 оны тайланд хот, хөдөөгийн нөхцөлд эрүүл хооллолтын бодлого, хөрөнгө оруулалтын хүрээнд “Хүнсний орчин ба хэрэглэгчийн зан байдлын бодлого”-ыг гаргасан байна. Үүнд:

- Хүнс, ундны маркетингийн зохицуулалт хийх;
- Өөх тос, сахар эсвэл давс ихтэй уургийн агууламж ихтэй хүнс, ундаанд татвар ногдуулах;
- Хоол тэжээлийн орц найралгийг шошгожуулах;
- Эрүүл хүнс худалдаалах цэгүүдийг дэмжих;
- Хоол тэжээлийн тухай боловсрол, мэдлэгийг нэмэгдүүлэх;
- Санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
- Нийтийн хоолны газруудын хүнсний аюулгүй байдалд болон тэжээллэг хүнс ашиглаж буй эсэхэд хяналт тавих;
- Тэжээллэг хоол хүнсээр хангах хүрээнд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх;

ЕХ-ноос хэрэгжүүлж буй “Farm to Fork” стратеги: Европын Холбоо 2050 он гэхэд хүлэмжийн хийн ялгаруулалтаас бүрэн ангижрах зорилтын хүрээнд Ногоон хөгжлийн бодлогын баримт бичгийг 2019 оны 11 дүгээр сард баталсан. Тус баримт бичгийн тэргүүлэх зорилтуудын нэг нь хүнсний тогтолцоог тэгш, эрүүл болон хүрээлэн буй орчинд ээлтэй болгох бөгөөд энэ хүрээнд “Farm to Fork” стратегийг хэрэгжүүлж байна. Эрүүл, тогтвортой хүнсний тогтолцоонд шилжих стратегийг хэрэгжүүлж, ЕХ 2030 он гэхэд дараахь зорилтод хүрэхээр төлөвлөжээ.

- Пестицидийн хэрэглээг 50 хувиар бууруулах,
- Хортой пестицидийн хэрэглээг 50 хувиар бууруулах;

- Шим тэжээлийн алдагдлыг хамгийн багадаа 50 хувиар бууруулж, хөрсний үржил шимийг алдагдуулахгүй байх;

- Бордооны хэрэглээг хамгийн багадаа 20 хувиар бууруулах;

- Ферм болон усны аж ахуй эхрлэгчдэд худалдаалах нянгийн эсрэг бэлдмэлийг 50 хувиар бууруулах. (Судалгаагаар нянгийн эсрэг бэлдмэлийн улмаас ЕХ-ны түвшинд жил бүр 33 мянган хүн нас бардаг болох нь тогтоогджээ);

- Нийт тариалангийн талбайн 25 хувийг органик тариалалтын талбай болгохоор зорьж байна.

Евростатаас 2020 оны статистик мэдээлэлд тулгуурлан Европын хүнсний сүлжээний тайланг 2022 эрхлэн гаргажээ. Дээрх тайланд ЕХ-ны гишүүн орнуудаас гадна Исланд, Лихтенштайн, Норвег, Швейцар улсуудыг хамруулсан байна.

Судалгаагаар 2020 оны байдлаар нийт тариалангийн талбайн 9.1 хувьд нь органик тариалалт эрхэлж байсан үзүүлэлттэй гарсан бөгөөд энэ нь 2012 онтой харьцуулахад 5.9 хувиар өссөн үзүүлэлт байна. Австри, Эстони, Швед, Швейцар, Итали улсууд органик тариалалтаар тайланд дурдсан 31 улсаас эхний тавд жагссан бол Чех улс 15 гаруй, Словак улс 10 гаруй хувьтай байна.

Түүнчлэн хэрэглэгчдийг эрүүл, тогтвортой хоол хүнсийг сонгохыг чадавхжуулахад савалгааны нүүрэн талд шим тэжээлийн тэмдэглэгээг зайлшгүй байрлуулах болон хүнсний бүтээгдэхүүний тэжээллэг чанар, уур амьсгал, байгаль орчны хүчин зүйлийн мэдээллийг агуулсан хүнсний шошгоны тогтвортой тогтолцоог бий болгох, ЕХ-ны түвшинд хуулийн дагуу зайлшгүй биелүүлэх хүнсний хог хаягдлыг бууруулах зорилтуудыг боловсруулахаар ажиллаж байгааг тайланд дурджээ.

Европын холбооны гишүүн орнууд Хүнсний хангамж аюулгүй байдлын асуудлаар Европын холбооны нэгдсэн бодлого, хэрэгжүүлж буй арга хэмжээг шууд мөрдөн ажиллаж байна.

“Нэг эрүүл мэнд” уриалга: Европын холбооны хүнс, эрүүл ахуй хариуцсан агентлагууд “One health” уриалгыг дэвшүүлээд байна. “One health” уриалга нь хүний эрүүл мэндэд учирч буй сөрөг нөлөөллийг арилгахын тулд “Хүн-Амьтан-Ургамал”-ын харилцан хамаарлыг цогцоор нь авч үзэн шийдвэрлэх ойлголт юм. Бүх салбар дахь хамтын ажиллагааг дэмжсэнээр бодитой үр дүнд хүрч чадна гэжээ.

Нэг эрүүл мэндийн хандлага нь:

- Мал, амьтныг зоонозын өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлэх.

- Хүнсний аюулгүй байдал, аюулгүй байдлыг сайжруулна.

- Нянгийн эсрэг тэсвэртэй халдварыг бууруулж, хүн, амьтны эрүүл мэндийг сайжруулна.

- Дэлхийн эрүүл мэндийн аюулгүй байдлыг хамгаалах.

- Биологийн олон янз байдал, байгаль хамгаалах.

Европын холбооны хүнс, эрүүл ахуйтай холбоотой дараах байгууллагууд нэгдээд байна.

Үүнд:

- Европын өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналтын төв (ECDC),

- Европын химийн агентлаг (ECHA),

- Европын байгаль орчны агентлаг (EEA),

- Европын Хүнсний аюулгүй байдлын газар (EFSA)

- Европын эмийн агентлаг (EMA)

ГАДНЫН УЛС ОРНУУДЫН БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ЧИГ ХАНДЛАГА

АНГЛИ УЛС: Их Британийн Хүнс, хөдөө ахуйн яамнаас 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Засгийн газрын хүнсний талаар баримтлах стратегийг өөрийн парламентдаа танилцуулсан.

Уг стратегид Их Британи Улс улаан буудай, мах, өндөг болон хүнсний ногооны үйлдвэрлэлээр өөрийн хэрэгцээг бүрэн хангах хэмжээнд байгаа ба сүүлийн 20 жилийн хугацаанд нийт хэрэглэж буй хүнсний бүтээгдэхүүний 75 хувийг дотооддоо үйлдвэрлэж байгааг цаашид тогтвортой түвшинд хадгалах зорилготой байна.

Түүнчлэн хүнсний үйлдвэрлэл нь Засгийн газрын иргэдийн амьжиргааг дээшлүүлэх бодлогын нэг цөм болно гэж үзэж байна. Хүнсний үйлдвэрлэлийн салбар Британийн боловсруулах аж үйлдвэрийн хамгийн том салбар бөгөөд автомашин, агаарын тээврийн хэрэгслийн үйлдвэрлэлээс ч өндөр дүнтэй байна.

Британийн хүнсний салбарын стратегийн баримт бичигт тус салбарт тулгарч байгаа гол бэрхшээлд хүнсний бүтээгдэхүүнээс үүдсэн таргалалт болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөг шийдвэрлэх асуудал багтжээ. Хүүхдийн дунд хэрэглэж байгаа ундаа, чипс зэрэг ядуу агуулгатай хүнсний хэрэглээг бууруулж, хүнсний ногооны хэрэглээг дэмжих үйл ажиллагаа үр дүнтэй байгаад тулгуурлан эрүүл хооллолтыг дэмжих, тогтвортой хөдөө аж ахуйн үйл ажиллагааг санхүүгийн хувьд урамшуулах бодлогыг авч хэрэгжүүлэх нь зүйтэй байгааг уг стратегийн өмнөтгөлд онцгойлон тусгасан байна.

РУМЫН УЛС: Румын Улс нь хөдөө аж ахуйн асар их нөөц бололцоотой буюу дотоодын хэрэгцээнээс илүү хэмжээгээр хүнсний түүхий эд, хоол хүнсээр хангах боломжтой орон. Энэ үзүүлэлтээр Европын холбооны орнуудын тавдугаарт буюу ойролцоогоор 80 сая хүний хүнсний хэрэгцээг хангах боломжтой. Гэвч




хүнсний нийт эрэлтийн 70 орчим хувийг импортоор хангаж байгааг тус улсын болон олон улсын судалгааны байгууллагууд тооцоолжээ. Ийм нөхцөлд Румыныг хүнсний тусгаар тогтнол, аюулгүй байдлаа хангасан гэж хүлээн зөвшөөрөх боломжгүй юм. Зах зээл дээр хүнсний хомсдол үүсээгүй ч худалдан авах чадвар буурснаар үнийн өсөлтийн шалтгаанаас үүдэн хүнсний хямрал үүсчээ. Үүнд төсвийн ажилчдын цалин, тэтгэвэр, эрүүл мэндийн даатгалын татвар, НӨАТ, инфляцийн өсөлт зэрэг нь голчлон нөлөөлдөг гэжээ.

ЧЕХ УЛС: Хүнсний аюулгүй байдлын асуудлын хувьд бодлого, хууль, тогтоомжоос гадна иргэдэд энэ талын зөв мэдээлэл, зөвлөмж өгөх, сургах ялангуяа хүүхэд, багачуудад мэдлэг, боловсрол олгох чиглэлд анхаарал хандуулж байна.

Чех улсын хувьд тус улсын Хөдөө аж ахуйн яам “Хүнсний аюулгүй байдлын мэдээллийн төв”-ийг өөрийн харьяанд ажиллуулдаг бөгөөд энэхүү төв нь иргэдэд хоол, хүнсний аюулгүй байдалтай холбоотой өргөн хүрээний сурталчлах, таниулах, сургах үйл ажиллагаа явуулж байна.

ТУРК УЛС: Тус улсад мал аж ахуйн салбарын зардал байнга өсөж байгаатай холбоотойгоор 2022 онд үхэр сүргийн тоо толгой 6 хувиар буюу 1 сая буурч, 17 сая толгойд хүрчээ.

Туркийн үхэр сүргийн бүтэц, мах бэлтгэл




Эх үүсвэр: ТуркСТАТ, 2023 он (fas.USDA.gov танилцуулгад ашигласнаар)

Хэдийгээр үхэр сүргийн тоо толгой буурсан ч тус улсад махны үйлдвэрлэл 2022 онд 12.3 хувиар өсч, 2.2 сая тоннд хүрчээ. Энэ нь 2019-2023 онд хэрэгжүүлэх 11 дүгээр хөгжлийн төлөвлөгөөг батлаж, энэхүү

төлөвлөгөөнд хүнсний аюулгүй байдлыг хангах, малын махны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилт тавин хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотой.

Турк улс дахь махны үйлдвэрлэл, 2021-2022 он



Мал аж ахуйн зардлыг бууруулах зорилгоор импортын овъёос, эрдэнэ шиш зэрэг малын тэжээлийн орцыг хөнгөлөлттэй үнээр малчдад олгох, тэжээлийн гол орц найрлагад ордог үр тарианы импортын татварыг тэглэх, малын тэжээлийн үнийн дээд үнэ тогтоох, мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн тэтгэмж олгох зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа ч, эдгээр арга хэмжээ нь мал аж ахуйн эрхлэгчдийн үйл ажиллагаанд төдийлөн үр дүнгээ өгөхгүй байгаа ажээ.

Сүүлийн үед махны үнэ тогтмол өсөж байгаа бөгөөд 2023 оны 4 дүгээр сарын байдлаар нэг кг үхрийн татсан махны үнэ дунджаар 15 ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 3 дахин өссөн байна. Энэхүү үнэ өсөж байгаа нь энэ оны 2 дугаар сард Туркийн зүүн өмнөд бүс нутгийн 11 мужийг хамарсан хүчтэй газар хөдлөлтөд мал аж ахуйн салбар ноцтой хохирол амссантай холбоотой.

Турк улсруу импортлох хүнсний болон хөдөө, аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлт, хаяг, шошгонд баримтлах журам, стандарт нарийн тодорхой байдаг ба тэдгээр нь ЕХ-ны холбогдох дүрэм, журамтай нийцсэн байхаар зохицуулагдсан ажээ. Тухайлбал, E-620-625 болон E-626-635 амт оруулагчийг бүх төрлийн боловсруулсан махан бүтээгдэхүүнд ашиглахыг хориглосон ба дөнэр, котлет зэрэг уламжлалт хагас боловсруулсан махан бүтээгдэхүүнд нитрит ашиглахыг хориглодог байна. Түүнчлэн дотоодын болон экспортлогч орны мал нядалгааны газарт тавигдах шаардлага, зөвшөөрлийн гэрчилгээ шаарддаг.

Одоогоор Турк улсад үхэр импортлох зөвшөөрөлтэй 28 улс байдаг бол стандарт хангаж, Туркийн холбогдох яамнаас мал нядалгааны газрын зөвшөөрөл авсан 10 улс байна. Мөн малын гаралтай халдварт өвчний улмаас зарим улс, эсвэл тухайн улсын тодорхой бүс нутгийг хар жагсаалтад оруулдаг аж.

БНХАУ: Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаагаар тус улсын хүн амын өвчлөлийн 80 гаруй хувь нь хоол хүнснээс үүдэлтэй байгааг нотолсон бөгөөд хүнсний аюулгүй байдлын асуудалд хамгийн их шүүмжлэл хүлээж байна. Хятадын хүнсний аюулгүй



байдлын асуудал олон улсын хэмжээнд яригдаж эхэлсэн нь 2008 оноос эхлэлтэй. Тухайн үед хүүхдийн нэмэлт тэжээл буюу хуурай сүүнээс халдвар тээгч химийн бодис байгаа нь илэрч, үүний улмаас найман нярай амиа алдаж, 30 мянган хүүхэд эмнэлэгт хүргэгдсэн байдаг. Тус улсын НАХЯ-ны мэдээлснээр Хүнсний аюулгүй байдлын тухай шинэ хуулиар бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, тариалахаас эхлүүлээд бүртгэх, шошгожуулах, борлуулах, худалдаалах зэрэг бүх шатныхны хяналтыг сайжруулан, хариуцлага тооцох хэмжээг нэмэгдүүлжээ. Өөрөөр хэлбэл, тухайн хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, тариалагчаас эхлээд тухайн бүтээгдэхүүнд үнэмлэх олгосон ажилтан, бүтээгдэхүүнийг борлуулж, худалдаанд гаргах зоогийн газар, хүнсний лангуу гээд бүх шатанд хариуцлагатай байх шаардлага тулгарч байгаа юм. Хүнсэнд хор хөнөөлтэй бодис хольсон зэрэг хууль зөрчсөн үйлдэл гаргасан бол лицензийн эрхийг нь шууд хасах бөгөөд тус бүтээгдэхүүний хамгийн дээд үнийг 30 дахин нэмэгдүүлсэн өндөр торгууль тавихаар заажээ.

Хүнсний аюулгүй байдлыг алдагдуулсан, хуурамч тайлан гаргаж ажлаасаа халагдсан хүнсний хяналт шалгалтын ажилтныг тус салбарт насаар нь дахиж ажиллуулахгүй байх хатуу журмыг хуульд заасан байна. Мөн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн газар, он сар, бүтээгдэхүүний төрөл зүйл, чанар, стандартыг худал мэдээлсэн, зөрчилтэйг мэдүүлээгүй, удаасан зэрэг зөрчил гаргавал тухайн байгууллагын гол удирдлагыг огцруулж, тухайн ажилтныг ажлаас нь халах хүртэл арга хэмжээ авна гэжээ. Үүнээс гадна ГМО буюу генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүнд хяналт тавих тухай шинэ хуулиндаа заасан байгаа аж. Хүнсний аюулгүй байдлыг хамгаалах нь Хятадын засгийн газрын нэн тэргүүний зорилт байсаар ирсэн. Тэд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортыг төрөлжүүлэх замаар хүнсний аюулгүй байдалдаа анхаарч буй.

Саяхан болсон Улс төрийн товчооны Байнгын хорооны хуралдаан дээр Ши Жиньпин дарга хөдөө аж ахуйн салбарыг тогтворжуулж, үндэсний хүнсний аюулгүй байдлыг хамгаалах шаардлагатайг дурдаад, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, нийлүүлэлт, хөдөө орон нутагт тогтвортой өсөлтийг хангахын тулд дорвитой арга хэмжээ авахаа мэдэгдэв.

Хөдөө аж ахуй, орон нутаг, тариаланчид гэсэн гурван хүчин зүйл дээр тулгуурлан хөгжлийн

төлөвлөгөөгөө гаргадаг орон нутгийн аж ахуйн бодлого эрхэлсэн хороог Ши Жиньпин дарга удирддаг. Уг хорооны бага хурал дээр ч ялгаагүй хүнсний аюулгүй байдал хийгээд хөдөө тосгоныг сэргээн хөгжүүлэхийн чухлыг онцолжээ. Хүнсний аюулгүй байдал бол нийгмийн тогтвортой байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай хүчин зүйл. Хятадын Хөдөө аж ахуйн яамны сайд Тан Рэньжян хүнсний аюулгүй байдлын хоёр чухал бүрэлдэхүүн хэсгийг онцолжээ. Тэрбээр хөдөө аж ахуйг компьютерээр зүйрлэвэл үр тариа бол чип нь гэв. Мөн тариалангийн талбайг хүнсний үйлдвэрлэлийн гол амин судас гэжээ. Эндээс үзвэл үр тариа ба тариалангийн талбай нь хүнсний аюулгүй байдлын хамгийн гол бүрэлдэхүүн хэсэг юм.

ОРОС УЛС: ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин “ОХУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратегийн тухай” зорилтыг тодорхойлохдоо, Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх, урт хугацаанд улс орны тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн гадаад, дотоод бодлогын үндэсний ашиг сонирхол, үндэсний стратегийн тэргүүлэх чиглэл нь Оросын иргэдийн амьдралын чанарыг сайжруулахад төрөөс хүнсний аюулгүй байдлыг хангах явдал нэн чухал гэж үзэв.

Түүнчлэн “Эрүүл, шинэхэн хүнсний бүтээгдэхүүн манай улсын бүх иргэдэд хүртээмжтэй байх ёстой” гэж Засгийн газрын Тэргүүн М.Мишустин «Хүнсний аюулгүй байдлын стратегийн чуулган» дээр мэдэгдэв. Энэ удаагийн чуулганаар Засгийн газрын дарга, гишүүд, мэргэжилтнүүд, үйлдвэрлэгчид “Хүнсний аюулгүй байдлын” бодлогын талаар хэлэлцжээ.

Гадны хатуу хязгаарлалтыг үл харгалзан дотоодын хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчид шинэ нөхцөлд дасан зохицсон гэж М.Мишустин үзэж байна. Энэ нь Оросын бүтээгдэхүүний өсөн нэмэгдэж буй нэр төрлөөс тодорхой харагдаж байна. Тухайлбал, 2023 оны урьдчилсан мэдээллээр, тус улсын ургамлын тосны үйлдвэрлэл төлөвлөсөн хэмжээнээс хоёр дахин нэмэгдсэн аж.

Тиймээс өмнө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд зарим салбарт хүчин чармайлтаа нэмэгдүүлэх шаардлагатай. Сүү, сүүн бүтээгдэхүүн, жимс жимсгэнээр өөрийгөө хангах түвшин нэмэгдэж байгаа ч хангалттай хэмжээнд хүрэх болоогүй байна. Төрөөс үрийн үйлдвэрлэлд онцгой анхаарал хандуулж байгаа бөгөөд оросын үйлдвэрлэгчид эх орны үйлдвэрийн түүхий эдээр олон асуудлыг орлуулах боломжтой гэж үзэж байна.

ОХУ нь өөрийн хэрэгцээтэйгээ харьцуулахад 2023 оны байдлаар үр тариа 185,5 хувь, ургамлын тос 221,1 хувь, загас, загасан бүтээгдэхүүн 153,2 хувь, элсэн чихэр 103,2 хувь, мах махан бүтээгдэхүүн 101,6 хувь, төмс 94 хувь, сүү сүүн бүтээгдэхүүн 85,7 хувь, хүнсний ногоо 89,2 хувь, жимс жимсгэнэ 44,9 хувь, хүнсний давс 65,2 хувиар дотоодын үйлдвэрлэлээрээ хангаж байна.

Мэдээлэл бэлтгэсэн: Я.Чинзориг / ГХЯ-ны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын зөвлөх /

ШУТИС Бизнесийн Ахисан Түвшний Сургууль
Тана лабораторын зөвлөх, дэд профессор
Ц.Сонинхишиг:



“Дэлхий дахин хүнснээс авах шимт бодисуудыг нэг бүрчлэн тооцоолдог хандлагаас татгалзаж байна”

2000-аад оноос эрчимтэй яригдаж эхэлсэн шим тэжээлийн доройтлын асуудлаар АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн Шим тэжээл судлалын тэнхимийн зөвлөх, дэд профессор Ц.Сонинхишигтэй ярилцсанаа хүргэж байна.

“ДАЛД ӨЛСГӨЛӨН БУЮУ БИЧИЛ ШИМ ТЭЖЭЭЛИЙН ДУТАГДАЛ МАШ ТҮГЭЭМЭЛ БАЙНА”

- Хүнс гэхээр хамгийн түрүүнд өлсгөлөнгийн асуудал яригддаг байсан ч сүүлийн үед шим тэжээлийн доройтлын асуудал анхаарал татах боллоо.

- 1990 он, зарим улс оронд 2000-аад оныг хүртэл өлсгөлөнгийн асуудлыг ярьдаг байсан. Хоол тэжээл хангалттай биш байна, өлсгөлөнд нэрвэгдсэн хүмүүс өвчилж байна, өвчтэй хүмүүсийн хөдөлмөрийн бүтээмж буурч, эдийн засагт нөлөөлж байна гэх асуудал яригддаг байлаа. Тиймээс дэлхий даяар хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих бодлого хэрэгжиж, техник технологийн хөгжилтэй уялдуулж үйлдвэрлэлийн хэмжээгээ нэмж чадсан. Гэтэл хангалттай хоол хүнс хэрэглэсэн ч хүн ам эрүүл байж чадаж байна уу гэдэг асуудал гарч ирсэн. Ингээд хүнсний хангамжийн бодлогын чиг хандлага өөрчлөгдөж ГЭДЭС ЦАТГАЖ, ХАНГАЛТТАЙ ИДЭХ БИШ ТЭЖЭЭЛЛЭГ ХООЛ ХҮНСИЙГ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭСНЭЭР ХҮН АМ ЭРҮҮЛ БАЙХ ЮМ БАЙНА гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Одоо бол дэлхий дахины хүнсний бодлого шим тэжээлийн баримжаатай хэрэгжиж байна.

Дэлхий дахины хүнсний бодлого шим тэжээлийн баримжаатай хэрэгжиж байна

- **Үйлдвэрлэлийн хэмжээгээ нэмж, дийлэнх улс орнуудын хувьд өлсгөлөн тулгамдсан асуудал биш болсон байх нь. Үүнийг дагаад хангалттай хэмжээнд үйлдвэрлэсэн хүнснээс хэрэгтэйгээ сонгож авах буюу шим тэжээлийн боловсролын асуудал гарч ирсэн болов уу?**

- Тэгэлгүй яахав. Зах зээл дээр маш олон бүтээгдэхүүн шинээр гарч ирсэн. Үүнд хэрэглэгч бэлэн биш байсан. Шинэ, гоё амттай, үзэмжтэй бүтээгдэхүүнийг сонгон хэрэглэж байсны үр дагавар нь шим тэжээлийн доройтол юм. Доройтол гэдэгт шим тэжээлийн илүүдэл болон дутагдлыг хамруулж ойлгоно.

Нэг талаас хүн амын дунд шим тэжээлийн илүүдэл, тухайлбал, үүний үр дагавар болох таргалалт нэмэгдсээр байгаа бол нөгөө талаас далд өлсгөлөн буюу бичил шим тэжээлийн дутагдал маш түгээмэл байна.

Шим тэжээлийн илүүдэл болон дутагдал нь зэрэг нэг бие дээр бий болохыг шим тэжээлийн давхар дарамт гэж мэргэжлийн хүмүүс тодорхойлдог.

- **Шим тэжээлийн дутагдлыг бид хувь хүн дээр харах ёстой юм уу эсвэл хүнсний хангамжийн асуудлаасаа харах ёстой юу?**

- Олон нийтийн сүлжээ, мэдээллийн хэрэгслээр гарч байгаа мэдээллүүд ихэвчлэн хувь хүн рүү чиглэж байна. Тийм ийм юм, энэ тэр хүнсийг идээрэй гэсэн зөвлөгөө хэлбэрийн мэдээллийг тухайн хувь хүний бие махбод, ажил хөдөлмөр, амьдралын хэв маягт нийцүүлэн хэрэглэж байна уу, үгүй юу гэдэг эргэлзээтэй. Яг үнэнийг хэлэхэд хэрэглэгч үүнд бэлэн биш бөгөөд “сайн” гэж тодотгосон зүйлийг л авч хэрэглээд байна.

Нөгөө талаар Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын бодлого гэж бий. Хүнсний аюулгүй байдал гэдгийг зөв ойлгох хэрэгтэй. Хэзээ улс орны хүнсний аюулгүй байдал хангагддаг вэ гэхээр,

Хүн бүр тэжээллэг, эрүүл хүнсээр хангагдах боломж нь бүрдсэн, өөрөөр хэлбэл Монгол Улсын хаана ч очсон гол нэрийн хүнс байж байдаг,

Хүнс нь иргэн бүрд тэгш хүртээмжтэй байх буюу ямар ч нийгмийн давхарга, орлогын түвшний хүн гол нэрийн хүнсийг хэрэглэх боломж бүрдсэн,

Хэрэглэгч хүнсээ зөв сонгож, зохистой хэрэглэх боловсролтой болсон гэсэн гурван үндсэн шалгуур хангагдсан үед хангагдлаа гэж үзнэ.

Одоогийн байдлаар улсын хэмжээнд хүн ардад хүрэлцээтэй хоол хүнсстэй байна уу, дотоодын хэрэгцээгээ хангаж байна уу үгүй юу гэдгээр аюулгүй байдал хангагдсан эсэхийг тодорхойлоод байна. Тэр хүрэлцээтэй хоол хүнсийг иргэн бүр хүртэж чадаж байна уу, зөв зохистой хэрэглэж байна уу гэдэг нь хүнсний аюулгүй байдлын маш чухал хэсэг бөгөөд үүгээр хүн амын хүнс тэжээлээс хамааралтай эрүүл мэндийн асуудал тодорхойлогдоно.

“ХЭРЭГЛЭГЧИЙН БОЛОВСРОЛ ЭЭЖ ХҮНСЭЭ ЦУГЛУУЛАХ, ХООЛОО АЯГАЛАХААС ЭХЭЛДЭГ”

- **Тэгэхээр эхлээд хангамж, хүртээмжийн асуудлыг ярьж байж хэрэглэгчийн боловсрол руу орох хэрэгтэй байх нь ээ?**

- Тийм ээ. Мэргэжлийн хүмүүс хангамжаа хараад хүн амын тоотойгоо харьцуулаад иргэдэд тэрийг, энийг сонгож хэрэглээрэй гээд зөвлөмж өгөх боломжтой. Байхгүй хүнсийг хэрэглэж гэж зөвлөх нь учир дутагдалтай.

Хоёрдугаарт хүртээмжийг ярих хэрэгтэй. Хүнс хангалттай байгаа нөхцөлд хэрэглэгч үнэ харж сонголтоо хийдэг. Эдийн засгийн чадамжаараа өөр өөр давхаргын хүмүүс боломждоо тааруулаад хүнсээ сонгодог. Жишээ нь, орлого багатай хүн шим тэжээлтэй гэхээсээ илүү ходоодоо цатгах хүнсийг сонгоно шүү дээ. Хүнсний хангамж бүрдлээ гэдэг нь жигд хүртээмжтэй байна гэсэн үг биш.

Тиймээс өндөр хөгжилтэй орнууд бага орлоготой хүмүүс амьдардаг бүс нутагт шим тэжээлтэй хүнсний үнийг хямд байлгах зохицуулалт хийдэг туршлага бий. Эсрэгээрээ өндөр орлоготой хүмүүсийн амьдардаг хороололд хүнсний бүтээгдэхүүн дунджаас өндөр үнэтэй байдаг. Энэ нь хүн ардаа тэжээллэг хүнсээр хангах зохицуулалт, улмаар БОДЛОГО хийж байгаагийн нэг жишээ юм.

Байхгүй хүнсийг хэрэглэж гэж зөвлөх нь учир дутагдалтай. Хангалттай байгаа хүнсийг эдийн засгийн боломж, газар зүйн байрлалаас үл хамааран тэгш хүртэх нөхцөл бүрдсэний дараа хэрэглэгчийн боловсролын асуудал яригдана.

Хэрэглэгчийн боловсрол ээж /эсвэл хүнс хариуцсан хүн/ хүнсээ цуглуулах, хоолоо аягалахаас эхэлдэг. Ээж хүн хүнсээ цуглуулахдаа нөхөртөө, өсвөр насны, бага насны хүүхдэдээ юу идүүлэх ёстойгоо бодож цуглуулдаг уу, яаж боловсруулдаг вэ, хоолоо аягалахдаа хэрхэн хуваарилдаг вэ гэдгээс эхлэх учиртай. Гэтэл бид энэ чухал шат дамжлагуудыг алгасаад шууд ам руу орох зүйлийг яриад байдаг.

- **Хоол хүнс сонголт хийж хүний ам руу орох хүртэл**

маш олон шат дамжлага байгаа гэлээ. Энэ шим тэжээлийн боловсролыг хэрхэн иргэдэд олгодог вэ?

- Хүнсээ зөв сонгож цуглуулахын тул ээж хүн өсвөр насны хүүхдэд юу дутагддаг вэ гэдгийг мэддэг байх хэрэгтэй болж байгаа биз. Гэхдээ зүгээр мэдэх биш шүү. Бүр ухамсарласан байх ёстой.

Би Японд доктороо хамгаалсан. Тэнд суралцаж байх даа бага сургууль, цэцэрлэгийн хүүхдэд олгодог шим тэжээлийн боловсрол олгох хөтөлбөрийг үнэхээр биширсэн.

Бага сургуулийн 4 дүгээр ангид/10 настай/ сурч байхдаа манай хүүхэд тухайн өдөр идсэн хүнсний бүтээгдэхүүний илчлэг, нүүрс усыг гэх мэт баримжаалж чаддаг болчихсон байсан.

Энэ чадварыг олгохдоо багш нь самбарын өмнө гараад энэ бол тийм сайн, хэрэгтэй хүнс гээд яриад байдаггүй. Харин цэцэрлэгийн хүүхдүүд тоглож байхдаа, сургуулийн хүүхдүүд үдийн хоолонд өгч байгаа хоолыг дагуулж өгдөг жижигхэн тайлбар захианаас мэдээлэл авдаг. Албан ёсны биш, жижигхэн тайлбар хоолоо дагуулаад байнга өгдгийг нь хүүхэд заримдаа уншина, заримдаа уншихгүй. Тиймээс байнгын давтамжтай өгөөд байхаар ухамсарт нь нөлөөлж, аяндаа идэж байгаа зүйлээ ямар шим тэжээлтэй вэ гэдгийг мэддэг болчихдог юм билээ.

Ийм хүүхэд насанд хүрээд ээж болохдоо шим тэжээлийн боловсролтой, өөрт болон өрөөл бусдын хоолонд анхаарах чадвартай болдог.

- Хоёр жилийн өмнөөс манай ерөнхий боловсролын сургуулиудад эрүүл мэндийн хичээл эргэн ирсэн. Шим тэжээлийн боловсролын агуулга эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрт багтсан уу?

- Эрүүл мэндийн хичээлд шим тэжээлийн хэсэг багтсан. Яг тэр хөтөлбөрийг боловсруулахад манай баг орж ажилласан юм. Хүүхдийн нас насанд нь тохирсон агуулгыг хөтөлбөрт тодорхой оруулж өгсөн байгаа.

2019 онд ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ батлагдаж, сургуулийн үдийн хоолыг хийх, түгээх үйл ажиллагаа, шим тэжээлийн боловсрол олгох ажлыг хоол зүйн мэргэжлийн хүн удирдан зохион байгуулах тухай энэ хуульд тусгасан бий. Үүнийг дагаад хоол зүйн мэргэжилтний эрэлт нэмэгдэж байна.

- Манай улсад хоол зүйн мэргэжилтэн бэлтгэх хэдэн сургууль байдаг вэ?

- Хоол зүйн мэргэжилтэн бэлтгэдэг хэд хэдэн их дээд сургууль бий. Улсын сургуулиас ШУТИС, АШУУИС, хувийн сургуулиас Хүрээ дээд сургууль, Шинэ анагаах ухааны их сургууль гэх мэт.

АШУУИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуульд Шим тэжээл судлалын тэнхим хоёр жилийн өмнө байгуулагдсан.

Би 1998-2000 онд АНУ-д хоол зүй, шим тэжээлийн мэргэжлээр магистр суралцаж төгсөөд Монголдоо ирсэн юм. Яг тэр жил ШУТИС Хоол зүй, шим тэжээлийн анги нээж байсан. Би шууд багшаар ажилд орсон, одоог хүртэл энэ салбарт ажиллаж байна. Хүн эрүүл байхад шим тэжээл, хоол хүнсний зохистой хэрэглээ чухал гэдгийг хүн бүр ойлгож байгаа энэ цаг үед энэ ангид элсэх оюутнуудын тоо нэмэгдэх хандлагатай байгаа.

“ХЭРВЭЭ ХУУЧИН ШИГЭЭ ХООЛЛОЁ ГЭЖ БАЙГАА БОЛ ХӨДӨӨ ГАРААД МАЛ МАЛЛАЖ, НҮҮДЭЛЧДИЙН АХУЙГААР АМЬДРАХ ХЭРЭГТЭЙ”

- Хүнсний ногоо, жимс ид гээд зөвлөдөг. Нөгөө талаас “Монгол хүн махаа идээд болоод ирсэн” гэх байр суурийг бас илэрхийлдэг. Энэ тухайд Та ямар тайлбар өгөх вэ?

- Олон судалгааны үр дүнгээс хүнсний ногооны хэрэглээ маш бага хэмжээтэй байгааг харж болно. Хоногт 300 гр хүнсний ногоо хэрэглэж байж шаардлагатай бичил тэжээлээ авахаар байхад манайхан дунджаар 30-40 гр ногоо хэрэглэж байна.

“Монгол хүн махаа идээд болоод ирсэн” гэх тухайд бол бид амьдралынхаа хэв маягийг харах ёстой. Хэрвээ хуучин шигээ хооллоё гэж байгаа бол хөдөө гараад мал аж ахуй эрхэлж, нүүдэлчдийн ахуйгаар амьдарч, байнгын идэвхтэй хөдөлгөөнтэй байх хэрэгтэй. Тэгээд ч уламжлалт

ахуйгаар амьдарч байсан нүүдэлчид маань өнөөдрийнх шиг замбараагүй, хэрэгцээнээсээ хэтрүүлж хооллодоггүй байсан. Ер нь уламжлалт хооллолт гээд маш том сэдэв бий. Мах гэхээсээ илүү маш олон төрлийн бичил тэжээл агуулдаг цагаан идээ, улирлын чанартай ургамлын хүнс хэрэглэж байснаас гадна байнгын биеийн идэвхтэй хөдөлгөөнтэй байсан нь хүн эрүүл чийрэг байхад их нөлөөлж байсан болов уу.

Бид барууны орнуудын иргэд шиг орон сууцанд амьдарч, суугаа ажил хийдэг, тэдэнтэй адил амьдралын хэв маягтай болсон. Бидэнтэй төстэй хэв маягтай барууны орнуудад хүнийг 10, 20 жил мөшгөж судалсан судалгааны үр дүнгүүд байдаг. Орчин, амьдралын хэв маяг, хооллолтын хэлбэрийг нь харьцуулж судлаад, ямар тохиолдолд өвчилж байна, шалтгаан нь юу вэ, хооллолтын асуудал мөн үү биш үү гэдгийг тогтоодог. Манайд тэгж хийгдсэн бодитой урт хугацааны судалгаа ховор шүү дээ. Урт хугацааны судалгаа хийх боломж ч байхгүй. Шинжлэх ухаан технологийг дэмжих төслүүд голдуу л 2-3 жилийн хугацаатай, бас төсөв мөнгө нь бага байдаг. 10 жил судалгаа хийх төсвийг хэн өгөх вэ? Тиймээс аль болох ойролцоо нөхцөл, амьдралын хэв маяг дээр хийгдсэн судалгааны үр дүнг авч ашиглахаас өөр аргагүй болдог.

Энэ дашрамд хэлэхэд үнэхээр бодлогын ач холбогдолтой, урт хугацааны судалгаа хийхэд шинжлэх ухаандаа хангалттай хөрөнгө хаях хэрэгтэй. Харин судалгааг мэргэжлийн өндөр түвшинд, чанартай хийж байна уу гэдэг нь өөр асуудал.

- Бид аль хүнснээсээ ямар шим тэжээл авах вэ гэдгийг хамгийн энгийнээр хэлж өгөөч?

- Мэргэжлийн хүмүүс хүн өдөрт ямар шим тэжээлийг ямар хэмжээтэй хэрэглэх вэ гэдгийг тухайн хүний нас, хүйс, амьдралын хэв маяг, ажил эрхлэлт, хөдөлгөөний идэвх, эрүүл мэндийн байдал гээд олон хүчин зүйлүүдийг харгалзан тооцдог. Харин жирийн иргэн тийм тооцоолол хийх шаардлагагүй. Монгол хүнд хамгийн тохиромжтой хооллолтын хэлбэрийг илэрхийлсэн ГЭР ЗӨВЛӨМЖ-ийг баримтлахад болно.

Гэхдээ энэ зөвлөмж энгийн хүмүүсийн хэрэглээнд нэвтрэхгүй байна. Ер нь улс орнууд иргэд, энгийн хүмүүст ойлгогдох зохистой хооллолтын зөвлөмжийг гаргасан байдаг. Жишээ нь, мах идэхдээ хамтад нь хүнсний ногоо идэх хэрэгтэй. Учир нь махыг шингээх, биед тэжээл болох үйл явцад оролцдог амин дэм хүнсний ногоонд агуулагддаг. Их, бага идэх гэхээсээ илүүтэй тэнцвэртэй хооллох нь өвчлөхгүй байхад чухал нөлөөтэй.

- Тэгэхээр би үүнийг идээд уураг, тэрийг идээд нүүрс ус ямар хэмжээгээр авах вэ гээд тооцоолоод байх шаардлагагүй. Энгийн, бэлэн байгаа загвараа мөрдөх хэрэгтэй байх нь ээ?

- Уг нь зөв хооллох нь маш энгийн ойлголт. Шимт бодисын талаар хэтэрхий их бодох хэрэггүй. Тэнцвэртэй л хооллох хэрэгтэй. Дэлхий дахин шимт бодисуудыг нэг бүрчлэн тооцоолдог хандлагаас татгалзаж байна. Яагаад гэдгийг жишээ авч тайлбарлая, мах уураг ихтэй ч ганцхан уургаас тогтдоггүй, маш олон амин дэм, дээрээс нь шимт бодист тооцогддоггүй ч хүний биед хэрэгтэй нэгдлүүдийг агуулдаг. Хүнс гэдэг ийм нийлмэл зүйл учраас ганц хоёр шимт бодисыг онцолж сонголт хийх нь учир дутагдалтай юм.

Харин махыг ногоотой хэрэглэж байна уу, махыг гурилтай хэрэглэж байна уу гэдгийг, өөрөөр хэлбэл хооллолтын хэв маягт анхаарах болсон.

- Хүнсний хангамж бүрдүүлэх, жигд хүртээмжийг хангах, боловсрол олгох зэрэг нь хувь хүний гэхээсээ илүү бодлогоор зохицуулалт хийх шаардлагатай асуудал юм байна.

- Тийм ээ. Бодлогын түвшинд суурь асуудал буюу хүнсний хангамж, хүртээмжээ шийддэггүй байж шууд шим тэжээлийн боловсрол ярих нь учир дутагдалтай. Суурь асуудлуудаа шийдсэн улс орнууд боловсрол олгох асуудлыг ч бодлогоор дэмждэг. Тухайлбал, Японд албан байгууллага ажилчдадаа шим тэжээлийн боловсрол олгох үүргийг хуулиар хүлээдэг. Зөвхөн боловсролын байгууллагуудын үүрэг биш гэж үздэг.

- Ярилцсанд баярлалаа.

Ярилцсан: Г.Номин



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
АХЛАХ ЗӨВЛӨХ
Сүрэнжавын **ЛҮНДЭГ**

МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт баялаг бүтээгч, хүнс үйлдвэрлэгч та бүхэндээ энэ сайхан өдрийн мэндийг өргөн дэвшүүлье!

Аливаа улс орны аюулгүй байдлын нэгэн суурь баталгаа бол ард иргэдийн хүнсний найдвартай, хүртээмжтэй, тогтвортой хангамж, аюулгүй байдал билээ.

Ийм ч учраас Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх эх орондоо “Хүнсний хувьсгал”-ыг өрнүүлж, ирэх таван жилийн хугацаанд гол нэр төрлийн 19 төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, улмаар бүс нутагтаа хүнс экспортлогч улс болох санаачилга гарган ажиллаж байна.

Энэхүү санаачилгыг манай төр засаг, түмэн олон санал нэгтэй дэмжиж, УИХ, Засгийн газар зохих тогтоол шийдвэрийг цаг алдалгүй гаргаж, бүх нийтээрээ хүчээ нэгтгэн хамтран хэрэгжүүлж байна.

Үүний үр дүнд, өнгөрсөн хугацаанд хүнс үйлдвэрлэгч, баялаг бүтээгч 1857 иргэн, аж ахуй нэгжид 5-6 хувийн хүүтэй, нийт 675 орчим тэрбум төгрөгийн зээлийг дотоодын арилжааны 10 банкаар дамжуулан олгож, бага хүүтэй, урт хугацааны санхүүжилтээр дэмжлээ.

Мөн хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлд нэн шаардлагатай түүхий эд, тоног төхөөрөмжид гааль, татварын хөнгөлөлт үзүүлж, нийт 19 үйлдвэрлэлд нэн шаардлагатай 428 төрлийн тоног төхөөрөмж хамрагдлаа.

Төр засгаас хүнс үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчдийнхээ үйл ажиллагааг дэмжихэд шаардлагатай хууль эрх зүй, бодлого шийдвэр, дүрэм, журам болон бусад холбогдох арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлж байна.

Төр, хувийн хэвшил хамтран ажилласны үр дүнд 19 гол нэр төрлийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл тодорхой хувиар нэмэгдэж, жилдээ манай улс дотоодын хүнсний хэрэгцээнийхээ 50 орчим хувийг гаднаас авч үүнд 1.0 тэрбум гаруй ам.доллар зарцуулдаг байсан бол өмнөх оны мөн үеэс 12 хувиар бууруулж, 120.0 сая орчим ам.долларыг эх орондоо үлдээх боломжтой боллоо.

Цаашид Та бид хүрсэн амжилтаа бататган бэхжүүлж, “Хүнсний хувьсгал”-аа бүрэн хэрэгжүүлж, төр засгаас хүнс үйлдвэрлэгч, баялаг бүтээгч ард иргэд, аж ахуйн нэгжээ үргэлжлүүлэн бүх талаар дэмжиж, төр-хувийн хэвшлийн түншлэлээ улам сайжруулж, сэтгэл зүтгэлээ нэгтгэн хамтран ажиллах шаардлагатай байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнүүд нь өөр хоорондоо нягт уялдаатай, үр дүнтэй хэрэгжсэнээр манай улсын тогтвортой хөгжлийн үндэс суурь бүрдэх учиртай.

Бүх нийтийн хамтын хичээл зүтгэл монголчууд биднийг өрх бүлээрээ хүнс үйлдвэрлэгч, улс орноороо хүнс экспортлогч болох зорилгод хүргэх болно.

Монгол эх орны минь хөрс үржил шимтэй, хүнс нь амин дэмтэй, монгол хүмүүн эрүүл саруул байх болтугай.